

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY




Өрсөлдөөн ширүүслээ

Их бүтээн байгуулалт
дагасан гундуу төрх

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2011. 09 сар. №007

www.mongolianeconomy.mn



Уул уурхайн хөгжил шинэ
сэтгэлгээ шаардаж байна



ХАРИЛЦАХ ДАНСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Танд мөнгөн хөрөнгөө найдвартай, эрсдэлгүй, орон зайг үл харгалзан удирдах боломжийг олгоно.

Та харилцах дансаа дараахь

MNT USD EUR
JPY RUB CNY

валютаар нээх боломжтой.



Хамгийн өндөр хүү

Найдвартай, шуурхай

Орон зайгаар
хязгаарлагдахгүй

Хямд



НҮҮРСНИЙ ЭРЧИМ ХҮЧ БИДНИЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙГ ӨӨРЧИЛСӨӨР БАЙНА

ОЛБОРЛОЖ ДУУССАНЫ ДАРАА БИД БАЙГАЛИЙГ УНАГАН ТӨРХӨӨР НЬ НӨХӨН СЭРГЭЭДЭГ

“Пийбоди Энержи” нь нүүрс олборлодог дэлхийн хамгийн том хувийн хэвшлийн компани төдийгүй ил уурхайн аюулгүй ажиллагаа болон өндөр түвшинд нөхөн сэргээх туршлагаараа дэлхийд тэргүүлдэг юм. Олборлолт хийсэн газрыг олборлолт хийхээс өмнөх байдалтай адил түвшинд, эсвэл түүнээс илүү сайжруулан нөхөн сэргээх нь Пийбодигийн эрхэм зорилго юм.

Бид Монголд анх удаа Монгол улсын төр захиргааны байгууллага болон олон улсын багтай хамтран Булган аймаг дахь нүүрсний уурхайн нөхөн сэргээх төслийг амжилттай хэрэгжүүллээ. Эрээний уурхай байсан газрын бэлчээрийг нөхөн сэргээж, энэ нутгийн иргэдийг урт хугацаанд ундны усаар хангах чадалтай худаг гаргаж өглөө.

Сүүлийн гурван жилийн хугацаанд бид дэлхийг хамарсан үйл ажиллагааныхаа хүрээнд мянга мянган га газрыг нөхөн сэргээж, 1 сая мод тарьснаар байгаль орчныг хамгаалах чиглэлийн 20 гаруй шагнал хүртсэн юм.

Эдийн засаг хүчирхэгжиж, хүмүүсийн амьдралын түвшин сайжрахын хэрээр нүүрсний хэрэглээ улам бүр өсөх төлөвтэй байна. Ирээдүйн хөгжилд нүүрс чухал үүрэгтэй хэвээр байгаа цагт Пийбоди хэзээд та бүхний итгэлтэй түнш байна.



Тэжээлийн Ургамлын Үр Үйлдвэрлэгчдийн Холбоонд хүлээлгэн өгсөн үрслүүлэгчийн ажиллагаатай багийн гишүүд танилцаж байгаа нь.

Пийбоди **Peabody**
Энержи **ENERGY**

PeabodyEnergy.com

Өрсөлдөөн ширүүслээ

Урхай гэхээр л аварга машин механизм, нүсэр тоног төхөөрөмжөөс өөр нийлүүлэх юм үгүй гэж бодож байвал сэтгэхүйгээ цэгцлэх болжээ. 10



“Яг л байснаараа”



...1999 оноос тус уурхайн удирдлагууд биологийн болон техникийн нөхөн сэргээлтэд анхаарч тодорхой хөрөнгө мөнгө зарцуулснаар өдгөө 129.2 га талбайг нөхөн сэргээгээд байгаа аж... 22

Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд-II



...“Reuters” энэ оны есдүгээр сарын 1-нд Тавантолгойг тойрсон асуудалтай холбоотойгоор уг нийтлэлээ шинэчлэн гаргасан байна...24

Хариуцлагатай уул уурхай

- 9 Уул уурхайн хөгжил шинэ сэтгэлгээ шаардаж байна
- 10 Өрсөлдөөн ширүүслээ
- 13 Их бүтээн байгуулалт дагасан гундуу төрх
- 15 Монголын хууль гурав хоног...
- 18 Т.Лхагвадорж: Амжилтын гол үндэс хүн хүчдээ л байдаг
- 22 Яг л байснаараа
- 23 Монголын байгаль уйлж байна
- 24 Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд
- 25 “Баялгийн хараал”-ыг дайрч биш, тойрч гаръя
- 30 “Discover Mongolia” өнгөт эсгийг Монголд моодонд оруулсан
- 35 Монгол инженерүүдийн дэлхийн энэтэй “бүтээл”
- 36 Би ирээдүйд сайхан амьдарна аа!
- 38 Зэсийн хомсдол үүснэ

Эдийн засаг

- 39 Эдийн засгийн өсөлт Дулмаад хамаагүй
- 40 Б.Болд: IPO хийхийн тулд тогтсон үйл ажиллагаа, сайн үнэлгээтэй байх ёстой
- 43 Яагаад
- 44 Инфляци өссөнд гахай буруутай
- 45 IPO хийхэд таагүй болжээ

Бизнес


- 47 Мод хөглөөч
- 48 Бизнес эхэлж буй хүний долоон алдаа

Б.Болд: IPO хийхийн тулд тогтсон үйл ажиллагаа, сайн үнэлгээтэй байх ёстой



...Монголын хөрөнгийн бирж дээр 10-20 сая ам.долларын хөрөнгө босгодог орчныг бүрдүүлмээр байна... 40

Инфляци өссөнд гахай буруутай



...Хамгийн аймшигтай нь эдүгээ хятадууд төдийгүй дэлхийг сандаргаад буй 6.5 хувь гэх үзүүлэлт зүгээр л статистикийн хуурай тоо аж...44

Мод хөглөөч



...Б.Баярсайханы хэлснээр мод бүхэн өөрийн хөг “хэл”-тэй байдаг гэнэ. Морин хуур урлаж буй хүн модны юу гэж хэлэхийг сонсож чаддаг мөн өөрийгөө ойлгуулдаг байх нь хамгийн чухал ажээ... 47



ТОНАР
МАШИНОСТРОИТЕЛЬНЫЙ ЗАВОД

Монгол




Машин үйлдвэрлэлийн “ТОНАР” үйлдвэр нь ОХУ-ын чиргүүлийн хамгийн том үйлдвэрүүдийн нэг бөгөөд өөрийн бүтээгдэхүүн болох бүх төрлийн хагас болон бүтэн чиргүүлүүдээ хүнс, хөдөө аж ахуй, газар тариалан, уул уурхай, барилга, холын тээврийн зэрэг салбарт нийлүүлж байна.

Уг үйлдвэр нь “Өнөөдөр санаа маргааш бүтээгдэхүүн” гэсэн зарчмаар ажилладаг тул ямар нэгэн тогтсон хэв маягт баригдалгүйгээр хэрэглэгчийн хүссэн хүсэл, шаардлагыг хангасан, орчин үеийн технологийг ашиглан бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж байна.

Тус үйлдвэр нь “Хьюндай Моторс Монгол” ХХК-ийн захиалгаар Монгол орны эрс тэс цаг агаар, нүүрсний тээврийн замын даац, нөхцөлд тохирсон 80 тоннын даацтай чиргүүлийн загварыг хийж, туршин, үйлдвэрлэж эхлээд байна.

Энэхүү чиргүүлийн шал нь нэг чиглэлд хэсэгчлэн, эсрэг чиглэлд бүхлээрээ хөдөлж, үрэлтийн хүч, хүндийн жинг ашиглан ачааг ачих буулгах гидрийн системтэй хийгдсэн.

Энэ технологийг анх удаа Монголын уул уурхайн салбарт нүүрсний, тээвэрт нэвтрүүлсэн нь өнөөдөр гарч буй бэрхшээлүүдийг шийдсэнээрээ онцлог юм. Энэ загварын чиргүүл нь технологийн илүү дамжлага буюу дугуйт ачигч шаардлагагүй, өвлийн нөхцөлд тэвшинд хөлдүүс хөлдөхгүй байх, аюул осолгүйгээр нүүрсийг буулгах боломжийг бүрдүүлсэн эдийн засгийн үр ашигтай шийдэл болж чадсан байна.



Чиргүүлийн даац /кг/ :	80000
Тэвшний дотор хэмжээс /мм/ : урт	13540
өргөн	2400
өндөр	2289
Тэвшний багтаамж /м3/:	74,4

Машин үйлдвэрлэлийн “Тонар” үйлдвэр нь “Хьюндай Моторс Монгол” ХХК-ийг Монгол Улс дахь өөрийн албан ёсны дистрибьютерээр сонгон ажиллаж байна.



Official Distributor: **HYUNDAI MOTORS MONGOLIA LLC**

HYUNDAI
TRUCK AND BUS

Вэб: www.hmm.mn,
И-мэйл: info@hmm.mn
Утас: 50111212, Факс: 50111214,
Гар утас: 99110860, 91111656

Үүсгэн байгуулагч,
Эрхлэгч: Д.Бэхбаяр
9999 4248

Үүсгэн байгуулагч,
Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал
8800 6228

Англи хэлний редактор:
Terrence Edwards

Сэтгүүлч:
Д.Мөнхчимэг
Х.Хулан
Э.Зоригт

Орчуулагч:
Э.Өлзийлхам

Дизайнер:
Ш.Оюундарь

Маркетингийн менежер:
Д.Баринжав
8880 0825
Б.Энхцэцэг
9901 5476

Хаяг:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23
Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/ х-2762

Утас/Факс: 976 - 7011 5476

www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

“Улаанбаатар принт”
ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Зиг заг" автосервис

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетин бүх салбар

"Макс" супермаркетин бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

Эрхлэгчийн зурвас

Discover Mongolia -д оролцож буй гаднын төлөөлөгчид болон хөрөнгө оруулагчид Тавантолгойн асуудлаар шинэ мэдээлэл, шийдвэр сонсохгүй нь. Монголчуудын ч, гаднынхны ч толгойг эргүүлсэн мөнөөх л учир битүүлэг байдал хэвээрээ. Харин цөмийн хог хаягдлыг Монголд булшлах тухай шуугиантай холбоотой сүүлийн үеийн шинэ мэдээлэл тэдний сонорыг "мялаана". Энэ тухай Монголын хэвлэлээр тасралтгүй гарч байгаа ч "Mongolian Economy" сэтгүүлийн англи хэлний редактор Terrence Edwards-ийн бичсэн нийтлэл манай уншигчдад таалагдана гэдэгт найдаж байна.



Монголын уул уурхайн салбарын хөгжил тойрсон асуудлууд улам бүр сонирхолтой болж байгаа энэ үед ес дэх жилдээ "Discover Mongolia"-д зочноор уригдаж байгаа дотоодын болон гадаадын төлөөлөгчдөд "Mongolian Economy" сэтгүүл уул уурхайтай холбоотой олон сэдвийг онцлон хүргэж байгаагаа тэмдэглэхэд таатай.

Монголын хувьд өнөөдөр уул уурхай хөгжих үү, эс хөгжих үү гэдэг асуулт байж таарахгүй. Их бүтээн байгуулалт, хөрөнгө мөнгө далласан уул уурхайн хөгжлийн галт тэрэг хэдийнэ хөдөлсөн учраас тэр. Харин одоо хариуцлагатай уул уурхайг хэрхэн хамтдаа хөгжүүлэх вэ? гэдэг тухай байнга ярих учиртай. Тиймээс "Mongolian Economy" сэтгүүлийнхэн уул уурхайтай холбоотой нийтлэл, сурвалжлагуудаа хариуцлагатай уул уурхай руу чиглүүллээ. Уншигч Та уул уурхайн нөхөн сэргээлтийг орхигдуулалгүй анхаарч явбал ямар үр дүн харагддагийг манай сэтгүүлчийн "Багануур"-ын уурхайгаас хийсэн сурвалжлагаас хараарай. Түүнчлэн нөхөн сэргээлтээс холуур өнгөрч, ашигт малтмалын ангуучдын гарт өртсөн сайхан байгальтай газрууд түүх болон дурсагдах төдий болсон эмгэнэлийн тухай ч баримт жишээтэй бичлээ. Үсрэнгүй хөгжил, баян монголчуудын /гэхдээ энэ өгүүлбэрээр ирээдүй цаг дээрхийг хэлж байгаа/ амьдралын баталгаа болох Тавантолгойн дүр төрх өнөөдөр ямар байгаа тухай манай хоёр ч сэтгүүлч газар дээрээс нь сурвалжиллаа. "Их бүтээн байгуулалт дагасан гундуу төрх", нүүрсний тээвэрлэлтийн тухай "Явдаг нүүрс" гэсэн гарчигтай нийтлэлүүд танд нэгийг бодуулах болов уу.

Оюутолгой, Тавантолгойд орж ирж буй олон тэрбум доллараас монголчууд хэр хэмжээгээр хутгах вэ? Тэгвэл томоохон төслүүдэд бараа, үйлчилгээ нийлүүлж ахиухан мөнгө олохын тулд явал зохилтойг Та "Өрсөлдөөн ширүүслээ" нийтлэлээс уншиж болох юм. Түүнчлэн уул уурхайн салбарт гялалзтал ажиллаж яваа "Хүннү Коал" компанийн захирал Т.Лхагвадоржийн ярилцлагыг ч мөн сонирхоорой.

"Mongolian Economy" сэтгүүлийн 100 хуудас зөвхөн уул уурхайд зориулагдчихаагүй. Эдийн засаг, бизнесийн шинэ, сонирхолтой мэдээллүүдээр уншигч таны мэдлэг, оюуныг цэнэглэхээ бид мартаагүй ээ. Тухайлбал, Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ын дарга Б. Болдын ярилцлагаас хэрвээ IPO хийхийг сонирхдог бол багагүй зүйлийг мэдэж авна. Түүнчлэн "Made in Mongolia" булангаас Монголын соёлыг дэлхийд гайхуулдаг морин хуур хэрхэн бүтдэг талаар сонирхох боломжтой.

Орлогч эрхлэгч И.Отгонжаргал

UNLIMITED SPIRIT

RADO

SWITZERLAND



SWISS WATCH SHOP

Наран Пойнт дэлгүүр. Хувьсгалчдын гудамж

Утас: +976-11-326435

RioTinto



Оюу Толгой, Олимпийн баг Рио Тинтогийн бахархал

“Лондон 2012” Олимпийн медалийг Оюу Толгойн алт, мөнгө, зэсээр.

www.riotinto.com/london2012



RioTinto

Монголын Үндэсний
Олимпийн хороо
АЛТАН ТҮНШ

уурхайн гүнээс
аваргын энгэрт





Фотог Б.Бямба-Очир

Онцлох сэдэв

Уул уурхайн хөгжил шинэ сэтгэлгээ шаардаж байна

Д.Мөнхчимэг

Уул уурхай монголчуудыг хэдэн үеэр нь тэжээнэ гэсэн хүлээлт бий болжээ. Алт, зэс, нүүрс тэргүүтэй 80 төрлийн ашигт малтмалыг хэвлийдээ тээсэн, Монгол нутаг минь уул уурхайн аварга машин, механизмуудын сүрд дарагдан хүчин мөхөсгөнө. Гадаадын шууд хөрөнгө оруулалт гэрлийн хурдаар нэмэгдэж, өмнө зүгт их бүтээн байгуулалт өрнөж байх зуур говьд уушгины өвчтэй нялхас мэндэлж, хүүхэд хөгшид тоос шороогоор амьсгалах ажгуу. Нэг талд нь Оюутолгойн ажил ундарч, Тавантолгойн асуудал шуударч байхад нөгөө талд нь “нинжа” нар газраа сэндийчсээр, шар металлын хэлтэрхийний төлөө бяцхан үрсээ бачуу нүх рүү мөлхүүлсээр. Монголын талаар “Төв Азийн Кувейт”, “Азийн дараагийн бар”, “Чоно эдийн засаг”, “Нүүрсний Саудын Араб” зэрэг сайныг зөгнөсөн нэршил олон дуулдах нь таатай. Гэхдээ Монгол орныг “Mineralia”, “Monsoalia” хэмээн уурхай, нүүрстэй нь холбон хочлох нь ч бий. Баялгаасаа болж баяжсан орнууд байхад баларсан орны жишээ ч мундахгүй байдгийг “Mongolian Economy” сэтгүүл сануулах

гэсэндээ энэ сэдвийг хөндсөнийг уншигчид маань хүлээж авах биз ээ. Бид Австрали, Чили шиг хөгжилд хүрэх үү, эсвэл Зимбабве, Боливи шиг арчаагаа алдах уу? “Эдүгээгийн өөр ямар ч үндэстэн Монгол шиг салаа зам, түүхэн сонголтын өмнө нүүр тулж байгаагүй биз” хэмээн “Wall Street Journal”-ын сурвалжлагч Маурэн Орд онож бичсэн байдаг.

Олон арван жилийн турш гадаадын хөрөнгө оруулагчид Монголын баялаг говьд нүдээ унагаж ирсэн ч зайгаа барьдаг байлаа. Оюутолгой, Тавантолгойгоос татгалзаад, хамраа сөхөөд буцсан “BHP Billiton” одоо амаа барьж байгаа биз. Өмнө нь монголчууд гаднынхныг царай алддаг байсан бол одоо гадаадын том компаниуд Монголд ирж, ажил хайж байна шүү дээ. “2000 онд бид Тавантолгойг яаж эдийн засгийн эргэлтэд оруулах вэ? гээд толгойгоо гашилгадаг байлаа. Энэ ордод хөрөнгө оруулж өгөөч гэж олон оронд хандаж, гуйж байсан боловч хэн ч тоохгүй байсан” хэмээн “Энержи ресурс” компанийн гүйцэтгэх захирлын орон тооны зөвлөх Р.Сундуй

хуучилж байв. Үнэхээр “BHP Billiton”-д “гологдоод” хоцорсон Тавантолгойд үйл ажиллагаа явуулахын тулд таван тивийн томоохон компаниуд хүч сорино гэж тухайн үед хэн ч төсөөлөөгүй биз.

10 жилийн өмнө байдал ямар байв? Монголын уул уурхай гэхээр “Эрдэнэт”, “Монросцветмет”, олон тооны жижиг алтны уурхайнаас өөр юу ч байгаагүй шүү дээ. Харин өнөөдөр “Vale”, “Rio Tinto”, “Peabody Energy”, “Cameco” зэрэг олон улсын “акул” Монголд ажиллаж байгаагийн зэрэгцээ уул уурхайн үсрэнгүй хөгжлийн босгон дээр үндэсний зарим компани өргөжин тэлж байгааг тэмдэглэх нь зүйтэй байх. “Энержи ресурс” л гэхэд дэлхийд толгой цохих “Leighton Asia” компанийг хөлсөлж ажиллуулаад, Хонконгийн хөрөнгийн биржид хувьцаагаа арилжиж, усгүй говьд нүүрс баяжуулах үйлдвэрээ босгоод авлаа. Монгол компани гадаадын хөрөнгийн зах зээлээс мөнгө босгоно гэж 10 жилийн өмнө хэн нэгний толгойд орж байсан болов уу? Бас нэг сонирхолтой зүйл гэвэл 158 жилийн түүхтэй, зөвлөгөө болон хяналтын салбартаа дэлхийд эхний дөрөвт жагсдаг “Pricewaterhouse Coopers” болон олон улсын “Behre Dolbear” групп Улаанбаатарт салбараа нээж амжсан.

Дотоодын хэрэгцээгээ чадан ядан хангаж ирсэн нүүрсний салбар маань экспортын зах зээлд хөл тавьж, гуравхан жилийн дотор Хятадад нийлүүлж буй коксжих нүүрсний хэмжээгээрээ Австралийг гүйцээд ирлээ. Нөөцөө ч илрүүлж амжаагүй ▶▶

хэрнээ нүүрсний олборлолт, экспортоор дэлхийд тэргүүлдэг Австралитай өрсөлдөж чадна хэмээн зоригтой дуугарах болсныг “Хүннү коал” компанийн захирал Т.Лхагвадоржтой хийсэн ярилцлагаас уншиж болно. Энэ мэтээр тоочоод байвал барагдахааргүй олон шинэчлэл манай уул уурхайн салбарт болж байна. 10 жилийн өмнө энэ бүхэн мөрөөдөл төдий байсныг сануулах юун.

ДНБ-ий 30, экспортын орлогын 80 гаруй хувийг бий болгож буй уул уурхайн салбарыг Монголын эдийн засгийн зүтгүүр гэдэг. Эрдэс баялгийнхаа ачаар манай ДНБ ирэх арван жилд жилдээ 20 хувиар өсөхийг албаны хүмүүс ярьж байна. Ашигт малтмалынхаа гавьяагаар энэ оны эхний хагас жилд л гэхэд хагас тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт Монгол Улсад шингэжээ. Зөвхөн Оюутолгойг ашиглалтад оруулахын тулд өдөртөө л долоон сая ам.доллар зарцуулж буйгаа “Оюутолгой” компанийн гүйцэтгэх захирал Камерон МакРэй онцолсон. Энэ бол монголчуудын хэзээ ч өмнө нь хараагүй бүтээн байгуулалт юм. Үүний хажуугаар “Эрдэнэс Тавантолгой” нүүрсээ экспортлоод эхэлсэн байхад Ухаа худаг, Овоот толгой, Цагаан суварга зэрэг нүүрсний томоохон уурхайн ажил эрчимжиж байна. Монгол орон газрын тос олборлогч болсноо дэлхийд тунхагласны зэрэгцээ уран, газрын ховор элемент мэтийн баялгаа ч эдийн засгийн эргэлтэд оруулах асуудал хөндөгдөх боллоо.

Олон улсын жишгийн дагуу үйл ажиллагаа явуулж буй компанийн тоо нэмэгдэж байхад ухсан нүх, овоолсон шороогоо тэр чигээр нь хаяад явдаг “хүнд гарууд” ч оршин тогтносоор. Алтны төлөө амь насаараа дэнчин тавин шороо малтдаг “нинжа” нараа ч зохицуулж чадахгүй хэвээрээ. Энэ байдлыг үргэлжлүүлж болохгүй гэсэн дохиог уул уурхайн хөгжил бидэнд өгч эхэллээ. Хариуцлагатай уул уурхайн тухай ойлголт хожуу ч гэсэн хүч түрэн орж ирж байгаа нь сайшаалтай.

Монгол Улсын хууль журмыг сайтар сахиж, татвараа төлж, орон нутгийн иргэдийн эрх ашгийг хүндэлж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй дэвшилт технологи ашиглаж, нөхөн сэргээлтээ хийж, үйл ажиллагаагаа ил тод явуулж буй компанийг хариуцлагатай хэмээн нэрлэдэг. Ийм компани нэг үеэ бодвол олширч байгаа бол төр, засаг ч энэхүү ойлголтод анхаарлаа хандуулж эхэлснээ Монголын эдийн

засгийн чуулганы үеэр баталсан билээ. Түүнчлэн ес дэх удаагаа зохион байгуулагдаж буй “Discover Mongolia” чуулга уулзалтын үеэр хариуцлагатай уул уурхайн сэдвээр тусгай хэлэлцүүлэг өрнөх гэж байна. Гэхдээ л монголчуудын хувьд хэтэрхий шинэлэг энэ ойлголтыг уншигчдадаа хүргэх нь “Mongolian Economy” сэтгүүлийн энэ дугаарын гол зорилго болж буй.

Уул уурхай улам томорч, хурдтай хөгжиж буйгаас эрдэс баялгийн орлогоо хэрхэн зөв зүйтэй хуваарилах вэ гэсэн томоос том асуултын тэмдэг бий боллоо. Алт, зэс, нүүрсээ ухаж зараад, бэлэн мөнгө тараагаад бид хөгжилд хүрэх

бил үү? Үгүй ээ, хүнээ хөгжүүлж байж л жинхэнэ утгаараа хөгжиж чадах учир “Mongolian Economy” сэтгүүлийн бас нэг чухал сэдэв энэ болсныг тэмдэглэе. Түүнчлэн ашигт малтмалын олборлолт, экспортын хэмжээ нэмэгдэх тусам дэд бүтцийн гачаал мэдрэгдэж байгааг хөндөхгүй өнгөрч болсонгүй. Энэ мэтчилэн өдрөөр биш цагаар өөрчлөгдөж буй уул уурхайн салбар маань биднээс шинэ бодлого, шинэ сэтгэлгээ шаардах болсон учраас “Mongolian Economy” сэтгүүлийн хамт олон ч уул уурхайн сэдвийг цогцоор нь хөндөхдөө шинэлэг хэлбэрээр хүргэхийг зорилгоо. ■

Уул уурхайн ханган нийлүүлэлт

Өрсөлдөөн ширүүслээ



Д.Марал

Мөнгөний уурхайгаас халбаганыхаа хэрээр хутгах уу, шанаганыхаа хэмжээгээр хутгах уу? Дэлхийд хоёрдугаарт жагсах зэс, алтны

уурхайг ашиглалтад оруулахын тулд “Оюутолгой” компани өдөр бүр долоон сая ам.долларын бараа, үйлчилгээ худалдаж авч байгаа нь дотоодын ►►

► төдийгүй гадаадын компаниудын аазгайг хөдөлгөж байна. Өдөр бүр 80 ачааны машин Хятадаас Оюутолгой руу хөвөрч байгаагийн зэрэгцээ Америк, Австрали, Герман, Канадын ханган нийлүүлэгч компани олноороо орж ирж, бараа, үйлчилгээгээ санал болгох болов. Үндэсний үйлдвэрлэгчид нэгийг бодох болсон юм биш үү? Оюутолгойгоос зөвхөн алт, зэсийн биш, мөнгөний, мэдлэгийн уурхайг олж харах цаг иржээ. Тэгж чадвал монголчууд Оюутолгойгоор зогсохгүй Тавантолгой хийгээд дараа дараагийн томоохон төслөөс ахиухан юм “чангаана”. Том яривал дэлхийн хэмжээний тоглогч болно.

Уурхай гэхээр л аварга машин механизм, нүсэр тоног төхөөрөмжөөс өөр нийлүүлэх юм үгүй гэж бодож байвал сэтгэхүйгээ цэгцлэх болжээ. Барилга байшин, тавилга, цахилгаан хэрэгсэл, үзэг цааснаас эхлээд уурхайчдын өмсөх хувцас, идэх талх гээд ерөөсөө тэдний хэрэгцээ мундахгүй. Тоног төхөөрөмжийн засвараас авахуулаад ажлын хувцасны угаалга, цэвэрлэгээ зэрэг үйлчилгээг ч Оюутолгойн төсөл мөнгөөр худалдаж авна. Энэ бүх хэрэгцээг хангаад байхад л олон тооны үндэсний компани хөлжих боломж бүрдээд байгаа юм. Гэхдээ энэ нь тийм ч амар ажил биш. Өнөөдөр “Оюутолгой” компанийн ханган нийлүүлэгч гэх “шошго”-той компанийн тоо 2500 давжээ. Гэвч 60 хүрэхгүй монгол компани л багахан хэмжээний бараа, үйлчилгээ байнга нийлүүлдэг гэсэн мэдээлэл бий. Товчхондоо, уурхайн барилгын ажилд зарцуулж буй таван тэрбум ам.долларын дийлэнх хэсэг нь гаднын компаниудын ашиг, орлого болж хувирч байна. Яагаад дотоодын аж ахуйн нэгжүүд маань энэ их мөнгөнөөс атга дүүргэж чадахгүй байна вэ? “Үнэн хэрэгтээ манай үндэсний компаниуд хүчин чадал, санхүү, менежмент болон боловсон хүчний хувьд дэндүү дорой байна” хэмээн Оюутолгойн ханган нийлүүлэлтийн консорциумын ерөнхийлөгч С.Балчиндорж учирлажээ. Дэлхийн хэмжээний төсөл мэдээж дэлхийн стандартад нийцсэн бараа, үйлчилгээ шаардана. Түүнийгээ монголчуудын мэддэг “танил тал”-аар биш, олон улсын нээлттэй тендерээр худалдаж авдаг билээ.

“Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ батлагдсанаар ханган нийлүүлэгч компаниудын маш том сүлжээ үүсэж байна. Ирэх онуудад Монголд олон тооны гадаад компани үүд хаалгаа

нээх болно” гэж ХААН банкны зөвлөх Питер Морроу тэмдэглэж байсан нь биеллээ хэдийнэ оллоо. Өнгөрсөн жилийн “Discover Mongolia”-гийн үеэр Австрали, Герман, Канадын ханган нийлүүлэгч олон компани үзэсгэлэн гаргаж, бараа, үйлчилгээгээ танилцуулж байв. Монголд асар их боломж байгааг гаднынхан мэдээд ирж байна. Энэ урсгал улам л эрчимжих төлөвтэй. Олон жилийн туршлагатай, дэлхийн хэмжээний компаниудтай бид яаж өрсөлдөх билээ гэх айдас монгол компаниудад төрөх нь лавтай. “Нэг тендерт ялагдана, хоёр дахид нь дахиад ялагдана, гурав дахь удаагаа ялдаг болно. Тэр үйл явц л одоо явж байна” хэмээн “FSCo” корпорацийн гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан тэмдэглэсэн юм. Үндэсний компаниудын бараа, үйлчилгээ Оюутолгойд гологдож байгаа нь үнэн. Үүнийгээ монголчууд мэдэрч эхэлсэн нь хамгийн сайн хэрэг ажээ. Юундээр алдаж байна вэ гэдгээ бодож, яаж түүнийгээ залруулах вэ гэсэн оролдлого эхнээсээ гарч эхэлснийг анзаарахад хялбар аж. Уул уурхайн ханган нийлүүлэлтийн тухай сэдэв байн байн хөндөгдөж, энэ чиглэлийн уулзалт семинар ч тасрахаа байх төлөвтэй. Нэгдье, нийлье, томорье гэсэн санал санаачилга ч гарч эхэлсэн нь сайшаалтай. “Монголчууд нэгдээд, санхүү, менежмент, маркетингийн чадвараа дээшлүүлж байж л Оюутолгойтой харьцах шаардлага гарч байгаа. Ингэснээр бид томоохон ажил, өндөр ашигтай захиалга авч чадна. Дэлхийн стандартаар үйл ажиллагаагаа явуулдаг компаниас нэг өдрийн өмнө ч гэсэн суралцаж чадвал монголчууд дараа дараагийн томоохон ордоо өөрсдөө ашиглаад эхэлнэ” гэж С.Балчиндорж учирласан юм.

Үндэстэн дамнасан корпорациуд зөвхөн доллар тээж ирэхгүйг Гадаадын хөрөнгө оруулалтын газрын орлогч дарга З.Баттүшиг онцолж байсан. Тэдний оруулж ирэх техник, дэвшилт технологи тав, арван тэрбум доллараар ч хэмжигдэхээргүй их хөрөнгө оруулалт болох учиртай. Зөвхөн мөнгөний биш, оюуны, технологийн хөрөнгө оруулалтын давалгаа айсуу. Тиймээс үндэсний компаниуд мөнгөнөөс гадна мэдлэг шүүрч авч чадваас дэлхийн тавцанд гарах үүд хаалга нээлттэй байна. Ийм туршлагыг далайн чанадаас ч биш, дотоодын бизнесмэнүүдээсээ судалж болно шүү дээ. Тухайлбал, 1996 онд байгуулагдсан “Геосан” Монголд үйл ажиллагаа явуулдаг “Би

Эйч Пи Биллитон”, “Вале”, “Камеко”, “Айвонхоу майнз” зэрэг гаднын компанид үйлчилгээ үзүүлсээр байгаад олон улсын стандарт хангаж чаддаг болсон. Эдүгээ тус компани Монголоос халиад, Бирм (Мьянмар), Хятадад ажиллаж буй компаниудаас захиалга авч байна шүү дээ. Өөрөөр хэлбэл, монголчуудад маш их боломж байна. “Рио Тинто”, “Пибади Энержи” гээд дэлхийн уул уурхайн бүхий л том компани Монголд байгааг ашиглаад зүгээр л тэдний шаардлагыг биелүүлээд сурах хэрэгтэй аж. Үүний тулд мэдээж Европын стандартыг хангаж, компанийн засаглал, менежментийн соёл зэргийг нэвтрүүлэх хэрэгтэй болно. Үүнийг монголчууд одооноос бодолцож, үйл ажиллагаагаа идэвхжүүлж, өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх цаг иржээ. Ингэж чадвал монгол компаниуд олон улсын зах зээлд хувьцаагаа гаргаж, өөрсдөө стратегийн хөрөнгө оруулагч ч болж чадахыг мэргэжилтнүүд ярьж байна.

Хэвлийдээ асар их хэмжээний баялаг тээсэн Монгол орныг гадаадын хөрөнгө оруулагчид даан ч сайн мэддэг болсон нь боломжийг бүр их нэмэгдүүлж буй. “Петро матад”, “Энержи ресурс” зэрэг уул уурхайн цөөнгүй монгол компани гадаадын хөрөнгийн биржээс мөнгө босгож чадсан шүү дээ. Гэхдээ зарим хөрөнгө оруулагч уул уурхайн компаниудаасаа илүү ханган нийлүүлэгчид нь ашигтай ажилладаг гэж үздэг тухай “CPS International” компанийн захирал Б.Мөнхдөл тайлбарласан юм. Оюутолгой, Тавантолгойн ажил жигдрээд ирэхээр ханган нийлүүлэгчид нь ачааллаа дийлэхээ байгаад, үйл ажиллагаагаа өргөтгөхийн тулд хөрөнгө босгож таарна. Ийм ирээдүй харагдаж байгаа учраас гадаадын хөрөнгө оруулагчид ч Монголын ханган нийлүүлэгчдийг ойлгож, үнэлэх төлөвтэйг тэрбээр мөн тэмдэглэсэн. Гэхдээ ингэж чадах, эсэх нь дотоодын аж ахуйн нэгжүүдийн идэвх, санаачилгаас л хамаарч байгааг ахин дахин сануулах нь зүйтэй болов уу. Уул уурхайн салбарт орж байгаа нэг доллар бусад салбарт дөрвөн долларын хэрэгцээг бий болгодог гэсэн олон улсын жишиг бий. Тэгвэл Монголын эрдэс баялгийн салбарт орж ирэх мөнгөний хэмжээ гэрлийн хурдаар нэмэгдэж байгаа нь боломжийг улам ихэсгэж буй. Өрсөлдөөн улам ширүүслээ. Шинэорчин монголчуудаас богино хугацаанд олон улсын түвшинд хүрэхийг шаардаж байна. ■



Дэд бүтэц-

Фотог.Б.Бямба-Очир

“Явдаг нүүрс”

Э.Зоригт

Говийн тэнгэрээс мөн газраас нар зэрэг төөнөж байна уу гэлтэй дөрвөн зүг найман зовхисоос халуу шатна. Хараа бүдрэх чулуугүй нүцгэн талд утаа, шороо хоёр агаар тэнгэрийг бүрхэн хуулирах бөгөөд тоосон дунд хүнд машин механизм дуу хадаан бүртэлзэх нь дайн болсон мэт сэтгэгдэл төрүүлэх ажээ. Хүнд даацын машин хөрс онгилон, тоос, шороо манарган уухилна. Нүүрээ угаагаагүй жаал шиг халтар гэрүүд хаа сайгүй бүртийнэ. Тоосон дунд цээж нүцгэн эрс тос, тоос хоёрт дарагдаад хав хар болцгоожээ. Эдгээр хүн өөрсдийгөө “явдаг нүүрс” хэмээн хочлох нь тун оносон мэт. Энэ бол “Тавантолгой”, “Эрдэнэс Тавантолгой”-н нүүрсийг урд хөрш рүү гаргах нүүрсний зам дагуу орших Цагаан-Овоо бригадын өдөр бүрийн өнгө ажгуу. Энд хүн төрж, хүүхэд тоглож, хөгшид амьдарна. Эрүүл мэндийн хувьд хэтэрхий аюултай уг газар өөр өөрийн гэсэн хуурамч бодлоор сэтгэлээ тордон амьдрах хүмүүс олон. Ийм их тоос, нүүрсний утаанд өөрийнхөө болоод гэр бүлийнхээ эрүүл мэндийг хэрхэн хамгаалж байна вэ? гэсэн асуултад тэд өөр өөрсдийнхөөрөө хариулна. Тухайлбал, “Хүний уушгинд нүүрсний утаа сайн байдаг юм гэсэн. Тийм болохоор зуны улирал ч гэсэн гэртээ гал түлж утаа амьсгалдаг” гэх нэгэн байхад, “Манайхан ямар дэд

бүтэц бий болгоход санаа зовох биш. Дарга нар өөрсдөө нүүрс зөөдөггүй, тоосон дунд амьдардаггүй болохоор ойлгодоггүй байх. Гэхдээ яах вэ одоо ч утаа, тоос хоёрт дасаад гамрит өвчин маань хүртэл ор мөргүй алга болсон” гэдэг хариулт өгөх хүн ч байна. Усны нөөц тун хомс энэ газар хэзээ хамгийн сүүлд усанд орсон гэдгээ мэдэх хүн ховорхон.

Монгол Улсын хөгжлийн түүчээ, эдийн засгийн өсөлтийн том эх үүсвэр, Өмнөговь аймгийн хөгжлийг өндөр түвшинд аваачих гээд олон сайхан амлалт, тодотгол дагуулсан “олон толгойн” эргэн тойронд бодит байдал ийм л байна. Нүүрсний зам дагуу энэ нутагт зам, ус, цэцэрлэг, сургууль, цахилгаан, эмнэлэг гээд дэд бүтцийн асуудал хамгийн хөндүүр сэдэв болжээ. Энэ талаар 45 жил үйл ажиллагаа явуулаад байгаа “Тавантолгой” ХХК-ийн дэд захирал Р.Зоригбаатараас тодруулахад, “Манайх анхаарч байгаа. 1.5 метр зузаантай зам тавих төлөвлөгөө боловсруулаад байна. Цогтцэций суманд сургууль байгуулахаар шавыг нь тавиад байгаа. Ирээдүйд нутгийн нийт өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах төлөвлөгөө боловсруулсан” гэх мэт ирээдүй цаг дээрх олон сайхан хариулт өгсөн. Сар гаруйн өмнөөс үйл ажиллагаагаа эхлээд буй “Эрдэнэс

Тавантолгой” ч мөн адил ирээдүй цаг дээрх төлөвлөгөө боловсруулчихсан додигор сууна. Шинэхэн уурхайн хувьд ийнхүү суух нь аргагүй биз. Нэг сав газраас олборлолт хийж буй “Энержи ресурс”, “Эрдэнэс Тавантолгой”, “Тавантолгой” нь урд хөрш рүү чиглэсэн өөр өөрийн гэсэн олон салаа зам тавих төлөвлөгөөтэй, зарим нь тавьж эхлээд байна. Тухайлбал, “Энержи ресурс” Тавантолгойгоос Гашуун сухайт хүртэл 250 орчим км хатуу хучилттай зам тавьж байгаа юм байна. Хэдийгээр зам тавих ажил ахицтай явж байгаа ч Авто тээврийн газраас хэд хэдэн шаардлага тавьжээ.

-Нэгдүгээрт, тухайн зам хоёр газраа нэлээд нарийхан болчихсон. Тиймээс тухайн хэсэг дээр машин зөрөхөд хүндрэлтэй учир хоёр хэсгийг өргөсгөх үүрэг өгсөн.

-Хоёрдугаарт, энэ зам гурван газраа огцом эргэлттэй. Нүүрс тээвэрлэж байгаа автомашинууд нь том оврынх болохоор огцом эргэлт дээр эргэхэд хүндрэлтэй, замын цаад хэсэг нь харагдахгүй өөдөөс нь гэнэт машин гараад ирэх магадлалтай. Тиймээс огцом эргэлттэй хэсгүүдийг өөрчлөхийг шаардсан.

-Гуравдугаарт, замын нөхцөлд тохирсон тэмдэгтүүдийг байрлуулахыг шаардсан байна. Эдгээр шаардлагыг биелүүлэх аваас уг зам ашиглалтад орно.

Нүүрс тээвэрлэх замын асуудлаар “Энержи ресурс” компанийн зөвлөх Р.Сундуй хэлэхдээ “баялгаа урагш нь зөөх 10 салаа зам барих юм уу? Тэгээд баахан машин зэрэгцээд уралдаад байх юм уу?” гэсэн юм. Ингээд бодохоор бидэнд дэд бүтцийн нэгдсэн бодлого, эв хамт санаа туйлын хэрэгтэй байна. Эдгээр уурхайн захирлуудын ярианаас сонсоход үнэхээр л 10 салаа зам тавих төлөвтэй. Гэвч дорвитой хийсэн бүтээн байгуулалт үгүй шав төдийхөн байна. Хийсэн зүйлгүй байгаа нь өөр өөрсдийн гэсэн томоохон шалтгаантай. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Өмнөговь дахь салбарын захирал Б.Батсайхан “Бид саяхан л үйл ажиллагаагаа эхэллээ. Ирээдүйд хийх зүйлийн талаар бодож төлөвлөсөн юм их бий” гэв. “Тавантолгой” ХХК-ийн захирал Х.Түмэнбаяр “Манай компани юм хийхийг хүсэж байна. Гэхдээ бидэнд хөрөнгө мөнгө зарцуулах эрх мэдэл байхгүй. Бүгдийг дээрээс ТУЗ-ын гишүүд үүрэг даалгавар өгдөг. Бүх л хөрөнгө мөнгөний асуудлыг тэд шийддэг. Хэдийгээр би ерөнхий захирал ч гэсэн нэг удаа зарцуулж болох мөнгөний хэмжээ таван сая орчим төгрөг ▶

байдаг” гэсэн юм. Харин Өмнөговь аймгийн Засаг дарга, “Тавантолгой” компанийн ТУЗ-ын гишүүн Г.Цог-Өрнөх хийх зүйл их байгаа талаар дурдахдаа “Манай суманд 5000 гаруй хүнд даацын авто машин нүүрс зөөж байна. Үүнээс үүдэлтэй тоосжилтын асуудал нэлээд хүндрэлтэй болсон” гэлээ. Ямар ч байсан тэд зам тавихаас эхлээд олон ажил хийх санаа өвөрлөжээ. Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын үүрэг даалгаврын дагуу Тавантолгойгоос Цагаан хад хүртэлх нүүрсний тээврийн замыг хаасантай холбогдуулан Авто тээврийн газрынхан Өмнөговь аймагт очиж, уурхайн холбогдох хүмүүст зохих шаардлага тавьжээ. Энэ талаар Авто тээврийн газрын улсын ахлах байцаагч С.Батболд ярихдаа “Тавантолгойн удирдлагуудыг дуудсан боловч ирээгүй. Саяын шалгалт нь “Энержи ресурс”

компанийн хүсэлтийн дагуу хийсэн ажил. Харин “Тавантолгой” компани одоогоор ямар нэг тайлбар ирүүлээгүй байна. Цогтцэций сумын Засаг дарга Г.Цог-Өрнөх “Тавантолгой” компанийн ТУЗ-ын гишүүн юм билээ. Түүгээр дамжуулан “Тавантолгой” компани замтай холбоотой юу хийх ёстойг хэлсэн” гэжээ.

Нүүрсний тээврийн жолооч нарын хэлж байгаагаар шороон замаар явах нь туйлаас аюултай байдаг. Тухайлбал, хэт их тоос, шороо босч өмнө яваа машинаа харахгүйн улмаас осол гарах нь их. Мөн тээврийн замд их тохиолддог хамгийн дүрхшээлтэй асуудал нь даацын дугуй хагарах. Өөрийн жин нь 20-30 тонн машинд 100 орчим тонн нүүрс ачина. Ёстой нөгөө уухилна гэдэг л болдог гэлтэй. Ийм үед дугуй нь хагарвал ноцтой осол гарах

нь ойлгомжтой. Ийм хүнд нөхцөлд ажиллаж байгаа жолооч нартай хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй гэж “Эрдэнэс Тавантолгойн” ажилчид гомдоллож байна. Манайхаас өөр нүүрсээ автомашинаар тэр дундаа шороон замаар экспортолдог орон, дэлхийн өөр хаа ч байхгүй. Дэлхийд нөөцөөрөө гайхагдах энэ том ордын бүх нүүрсийг шороон замаар экспортолж дуусгана гэвэл юу болох бол? Маргааш, нөгөөдөр ирээдүйд энэ их мөнгө далласан том ордын дэд бүтцийн асуудал нааштай шийдэгдээсэй. Энэ мэт нүүрс тээвэрлэлт тойрсон хийх ёстой, хийх гэж буй зүйлсийн талаар бичвэл эх адаггүй зүйл болно. Тиймээс энэ удаа нүдээр харж хийсэн сурвалжлагаар зогсьё. ■

Орон нутгийн хөгжил

Их бүтээн байгуулалт дагасан гундуу төрх



Цогтцэций сум, зам засварын ажил

Х.Хулан

Шүдний эмчийн хайгуулд

Цогтцэций сумын төвийн хүнсний дэлгүүрээс цэвэр ус авах зуур гаднаас нэгэн эрэгтэй хүн аахилсаар гүйж орж ирэв. Тэрбээр “Ёох, шүдээ авахуулах газар олддоггүй. Зөндөө гүйлээ” гээд духныхаа хөлсийг арчлаа. Лангууны ард зогсож байсан дэлгүүрийн эзэн “Яагаад шүдийг чинь авдаггүй юм бэ” гэж асууж амжихад мөнөөх эр “Миний энэ шүд ёзоор болчихсон юм аа. Тэгээд авах хүн олдхогүй байна” гэж тайлбарлах аж. “Би бахиар татаад, аваад өгөх үү” хэмээн дэлгүүрийн

худалдагч наргиан болгож, чанга инээлдэв.

Цогтцэций сум хаана байдаг вэ?

Инээдтэй мэт санагдах энэхүү болсон явдлын цаана эмэгнэлтэй дүр зураг нуугдаж байна. Учир нь, ийм инээдэмтэй юм шиг хэрнээ гунигтай дүр зураг манай орны, ялангуяа хөдөө, орон нутагт тохиолдож болзошгүй ч их бүтээн байгуулалт өрнөж, хөгжил цэцэглэх энэ газарт хүн эмнэлгийн үйлчилгээ ийм дор түвшинд байгаа нь нүд орой дээр гарахаар зүйл мэт санагдсаныг тэмдэглэе. Өмнөговь

аймгийн Цогтцэций суманд нэг дор гурвын гурван том уурхайн орд байрладаг. Өмнөговь аймгийн төв Даланзадгадаас 100-гаад км-ийн зайтай орших энэ суманд суурин 4000, хөдөлгөөнт 8000, нийт 11000 орчим иргэн амьдарч байна. Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөн улам нэмэгдэж буй Цогтцэцийд ажилгүйдлийн түвшин харьцангуй бага, таван хувьтай гэж Тамгын газрын дарга Б.Цэцмаа ярилаа. Тус суманд үйл ажиллагаа явуулдаг 80-аад аж ахуйн нэгжийн ихэнх нь уул уурхайн салбарынх. Уул уурхайгаас гадна мал аж ахуйг түшиж хөгжүүлэх концептэй сумын нийт малын 60 гаруй хувь зуданд хорогдож, одоогоор 40 гаруй мянган малтай. Цаашид эрдэс баялгийн салбарыг түшиглэсэн хот суурин барих, эрчимжсэн мал аж ахуй, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын хүртээмжийг сайжруулах, шинээр сургууль, эмнэлэг барьж байгуулах гэхчлэн хийх ажил тус суманд ундарсаар.

Дэд бүтцийн өнөөгийн байдал

Шинээр барьж байгаа улаан тоосгон барилгууд, энд тэндгүй овоолсон шороо, засвартай зам биднийг Цогтцэций суманд ирэхэд угтсан юм. Сум зочилсон хүн бүрт ус ▶



Цогт-Овоо сумын сургууль

эцсийн арга хэмжээ нь дэлгүүрээс лонх сархад сугавчлаад гарч одлоо.

Сумын сургууль, цэцэрлэг

Цогтцэций сумын төвд есдүгээр сарын 1-нд “Орчлон” сургуулийн салбар үүдээ нээхээр зэхжээ. Ийнхүү шинээр нээгдэх төлбөртэй цэцэрлэг, төлбөргүй бага сургууль олон эцэг, эхчүүдийг баярлуулж байгаа нь лавтай. Одоогийн байдлаар 75 хүүхдийн цэцэрлэгт 120, 400 хүүхэд суралцах сургуульд 800-гаад сурагч багтаах гэж зовдог тухай Б.Цэцмаа хэлсэн. Сумын иргэн С.Отгонбаяраас энэ талаар асуухад “Хүүхдүүд цэцэрлэгт явж чадахгүй, гэртээ сууцгааж байна. Гэр цэцэрлэг ажиллуулахыг зөвшөөрдөггүй юм” гэлээ. Иймээс хүрэлцээг сайжруулах үүднээс цэцэрлэгт өргөтгөл хийж, сургуулийг харин шинээр барихаар төлөвлөж байна. Дашрамд дурдахад 85 км-ийн зайтай орших Цогт -Овоо сумын төвийн сургуулийн гадна талбайд ургах цэцэг, мод уул уурхайн салбарыг зөв хөгжүүлж чадвал говийн эдгээр сум хөгжилд хүрэх болов уу гэсэн найдлагаар сэтгэл цэлмээн.

Орон нутагт хувь нэмэр оруулдаг уу?

Нэгэнт газар нутаг дээр нь үйл ажиллагаа явуулж, ашиг орлого олж улсын төсөвт хөрөнгө оруулж байгаагийнхаа хувьд уул уурхайн компаниуд орон нутгийн хөгжилд гар бие оролцох ёстой. Цогтцэций сум уул уурхайн компаниас дэмжлэг авдаг талаар засаг, захиргааны албаны хүнээс асууж дараах мэдээллийг олж авав. “Энержи Ресурс” сумын эмнэлэгт “Фургон” маркийн авто машин, сургуульд 15 компьютер өгч, байгаль орчны асуудалд анхаардаг гэнэ. “Таван толгой” компани малчдад өвс тэжээлийн тусламж, “Таван толгой транс” харин эмнэлгийн өвчтөний өрөөг тохижуулахад хувь нэмрээ оруулжээ. 2011 онд 4.7 сая тонн нүүрс олборлох төлөвлөгөөтэй ажиллаж байгаа “Таван толгой” компанийн гүйцэтгэх захирал Х.Түмэнбаяр энэ талаар “256 км зам тавих үйл ажиллагаанд манай компани бүх хөрөнгийн 50 хувийг, “Энержи Ресурс” талыг нь гаргасан. Мөн бетонон хучилттай зам тавих зураг хийлгээд, маршрут тавих ажилд ороод явж байна” гэлээ. Энэ мэтээр уул уурхайн компаниуд хөгжлийн төлөө орон нутагтай хамтарч, ард иргэдийн амьдрах орчныг сайжруулж, юуны өмнө нутгийн иргэдийн эрүүл мэнд, боловсрол, дэд бүтцэд хөрөнгө оруулах нь чухал билээ. ■

гэдэг нандин эрдэнийн үнэ цэнийг ирсэн өдрөөс эхлэн яван явтал ягштал ойлгуулдаг онцлогтой. 500 гаруй км донсолгоотой замыг машинаар туулсан бидэнд замын тоосноос салахад балга ус л ногдсон юм. Дотроо усгүй, ариун цэврийн өрөөгүй зочид буудлын хажуухан талд харин халуун усны газар ажиллах бөгөөд замын тоосонд даруулсан хүмүүс, нутгийн иргэд тасрахгүй үйлчлүүлдэг байна.

Цогтцэций суманд төсвийн байгууллагуудыг холбосон халаалтын шугамыг 498 сая төгрөгийн өртөгтэй хийж байгааг Засаг дарга Г.Цог-Өрнөх дурдлаа. Тэрбээр суманд тулгарч буй хамгийн гол асуудал бол зам, усны хангамж болоод байгааг онцлон тэмдэглэв.

Тоосжилт, эмнэлгийн үйлчилгээ

Зам барих асуудал шийдэгдэх хүртэл нүүрс тээвэрлэдэг том машинуудын тоос сул хөрстэй нутгийг битүү утаагаар бүрхсээр л байх нь. Мал эмнэлгийн хүрээлэнгийн мэргэжилтэн нүүрсний тээврийн зам дагуу бэлчээрлэдэг малыг шинжилж үзэхэд, уушгинд нь уут үүсэж, элсээр дүүрсэн байсан үнэмшихэд ч бэрхтэй шинжилгээний хариу гарсан байна гээд бод доо. Нүүрсний тээврийн их тоос шороо малд төдийгүй тэнд аж төрж буй хүмүүс, нэн ялангуяа бага насны хүүхдэд ч нөлөөлж байгаа тухай Цогтцэций сумын хүн эмнэлгийн их эмч Д.Дэлгэрмаа хэллээ. Тус эмнэлгээр энэ оны хагас жилийн байдлаар 0-2 хүртэлх насны 80 гаруй хүүхэд хэвтэж

эмчлүүлснээс 75 хувь нь тоосжилт болон бохирдсон агаартай холбоотой харшил, бронхит гэх мэт амьсгалын замын өвчнөөр өвдсөн тухай зүрх шимшүүлсэн баримт байна.

Утаа тоосгүй уул уурхай гэж байхгүй. Гэсэн ч ард иргэдийнхээ эрүүл мэндийг жаахан ч болов хамгаалъя гэвэл ногоон бүс байгуулж, сул хөрстэй талбайг зүлэгжүүлж моджуулах шаардлага Цогтцэций суманд тулгамдсан асуудал болжээ. Хүн амын суурьшил нягтаршиж, төрөлт ихэссэн сумын төв эмнэлэгт дөрвөн их эмч, таван бага эмч, мөн тооны сувилагч ажиллаж байна. Нэг их эмч 50-60 хүн үзэж, ачаалалтай ажилладаг гэж Дэлгэрмаа эмч яриу. Одоогийн эмнэлгийн байр олон хүн үзэж, хэвтүүлэх хүчин чадал дутмаг тул удахгүй шинэ эмнэлэгтэй болох юм байна. Дэлгэрмаа эмч нарийн мэргэжлийн дагнасан эмч нар, багаж тоног төхөөрөмж, рентген лаборатори, бариазаслын эмчилгээ, шүдний эмчийн үйлчилгээ нэн даруй шаардлагатай байгааг онцлон тэмдэглэв. Шүдээ авахуулах газар олдохгүй байна гэж ярьсан эрэгтэйн асуудал руу эргэж орёе. Сумын төвд шүдний хоёр хувийн эмнэлэг байдаг ч тогтвортой ажилладаггүй гэнэ. Цоожтой хаалга мөргөсөн шүд нь өвдсөн хүмүүс хаачих ёстой болж байна вэ? Эсвэл байсан ч ёзоор авахгүй гэж хэлэх шүдний эмчийн мэргэжлийн түвшин ямар байх вэ?

Ямартай ч шүд нь өвдөж орох байхаа олж ядсан эр нэгэнт эмнэлгийн үйлчилгээ авч аргагүйд цөхөрсөндөө



Шог зургийг А.Амарсайхан

Хууль, эрх зүй

Монголын хууль гурав хоног...

Д.Марал

Төсвийн асуудлаасаа болж Францын Ерөнхийлөгч Николя Саркози ээлжийн амралтаа эдэлж чадалгүй яаран ажилдаа орж, Засгийн газрын ээлжит бус хурал хийсэн. Глобалчлагдсан энэ ертөнцөд АНУ, Европын өр, төсвийн асуудлаас үүдэн ахиад хямрал нүүрлэж болзошгүй гэх айдас улс орнуудын эрх баригчдыг сандаргаж эхэллээ. Харин манай төр, засгийн эрхмүүд тоосон шинжгүй. Баяр наадамдаа яарсан УИХ-ын гишүүд хаврын чуулганаа хаахдаа ээлжит бус чуулган хийнэ хэмээн амлаж байсан нь саяхан. Гэтэл улс, аймаг, сум, байгууллагын цуварсан ой, найр наадам хэсэж, хөдөө гарч морь уяхдаа сайн гишүүд маань Төрийн ордонд үзэгдэхгүй байгаагаас харахад дээрх амлалт талаар болоо биз ээ. Монголын эдийн засгийн хөгжлийн зүтгүүр болсон уул уурхайн салбарт үүссэн хууль эрх зүйн ойлгомжгүй байдал, хөрөнгө оруулагчдын эргэлзээ ирэх аравдугаар сарын 3-нд нээгдэх намрын чуулганаас нааш тайлагдахгүй бололтой.

Эрдэс баялгийн салбар манай ДНБ-ий 30, экспортын 80 гаруй хувийг бий болгож байгаагийн зэрэгцээ сонгуулийн амлалт хэмээн монгол хүн бүрт бэлнээр өгч буй мөнгөний

эх үүсвэр болж, Хүний хөгжил санг санхүүжүүлж байгааг санацгаая. Түүнчлэн манайд орж ирж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 гаруй хувь нь чухам уул уурхайн салбарт шингэж буй. Гэтэл Ашигт малтмалын тухай хуульд оруулахаар зэхэж буй нэмэлт, өөрчлөлт, “Урт нэртэй” хуулиас үүдсэн маргаан, Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээ зэрэг улс орны хувьд амин чухал асуудал тодорхой бус хэвээр байгаа нь хөрөнгө оруулагчдыг хүлээлтийн байдалд оруулаад удаж буй. Энэ бүхэнтэй зэрэгцэн дэлхийн санхүү, эдийн засаг эргээд хямрах магадлалтай болсон нь Монголд орж ирсэн их мөнгөний урсгал гадагшлах эрсдэлийг дагуулах боллоо.

Уул уурхайн томоохон компаниудын орлогын 40 хувийг авах татвар санаачилсан Австралийн Ерөнхий сайд Кевин Радд дэлхийн хэмжээний сенсаац дэгдээж байв. Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр “супер татвар” хэмээн алдаршсан энэхүү хуулийн төслөөс болж Австралийн эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалт буурч, ажлын байр багасна хэмээн уул уурхайн “акулууд” эрх баригчдаа сүрдүүлэхдээ Монголд хэрэгжээд бүтэлгүйтсэн 68

хувийн татвараар жишээ авч байлаа. Товчхондоо, шинэ татвараас болж Австралийн уул уурхайн хөгжил ухарч болзошгүй гэсэн таамаг амархан гарч ирсэн бөгөөд энэ нь Кевин Раддын огцрох шалтгаан болсон юм. Эрх зүйн орчноор тоглох ямар эмзэг байдгийг дээрх үйл явдал дэлхийд харуулсан билээ. Уул уурхайн 200 гаруй жилийн түүхтэй Австралид ийм байхад Монголд хууль эрх зүйн орчин “хаврын тэнгэр шиг ааштай” байгаа нь ямар үр дагавартай вэ?

“Манай улсын уул уурхайн салбар үнэн хэрэгтээ хөл дээрээ босоогүй байна. Жишээлбэл, алтны салбарт гэхэд дэлхийн хэмжээний ганц уурхай байгаа бол бусад нь олон улсын зах зээлийн хувьд үнэлэгдэхээргүй жижиг ордууд. Тиймээс монголчуудын хувьд анхан шатны хөрөнгө оруулалт босгох асуудал хамгийн чухал юм. Гэтэл ийм нөхцөлд хууль эрх зүйн орчин тогтворгүй байна гэдэг нь өөрөө асар том асуудал” хэмээн “Rodman & Renshaw” хөрөнгө оруулалтын банкны тэргүүн дэд ерөнхийлөгч Ж. Жамул Монголын өдөр тутмын сонинд ярилцлага өгөхдөө тэмдэглэж байв. Тэрбээр банкныхаа шугамаар Монголын хэд хэдэн төсөлд хөрөнгө босгож өгөх гэж ажиллаж байх үед буюу 2010 оны тавдугаар сараас хайгуулын тусгай зөвшөөрлийг зогсоох тухай хууль гаргасан нь хүнд цохилт болжээ. Энэхүү шийдвэрийн дараа олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа арилждаг монгол компаниудын үнэлгээ ч эрс буурсан юм. “Хууль эрх зүйн орчны талаарх Монголоос гарч байгаа мэдээлэл зөвхөн ард түмэндээ л чиглээд байгаа мэт санагддаг. Нэг захирамж гарлаа гэхэд тэрийгээ зөвхөн иргэдэдээ л ойлгуулахгээд байдаг болохоос хөрөнгө оруулагчдыг анхаардаггүй. Тиймээс компаниуд өөрсдөө л тайлбарлахаас аргагүй байдаг” хэмээн “CPS International” компанийн захирал Б.Мөнхдөл онцолж байв. Ямар нэгэн хууль, захирамж гаргахдаа тэр нь уул уурхайн салбарт сая сая доллараа зарцуулсан хөрөнгө оруулагчдад хамгийн түрүүнд нөлөөлөхийг эрх баригчид анзаардаг болов уу?

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар буюу бидний ярьж заншсанаар 68 хувийн татварыг цуцалсан нь Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг батлах хөшүүрэг болж, улмаар хөрөнгө оруулагчдын итгэл ч сэргэсэн билээ. Гэтэл үүний дараахан “Урт нэртэй” хэмээн хочлогдсон Гол, мөрний урсац ▶▶

PPP түншлэл

Концессын зүйлийн жагсаалтад 2000 км төмөр замын төсөл оржээ

Уурхайд хэрэгжих PPP-ийн талаар ТӨХ-ны Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын газрын дарга Б.Заяабалаас тодрууллаа.

-Засгийн газраас баталсан PPP-ийн жагсаалтад уул уурхайн төсөл байгаа юу?

-Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад уул уурхайн төсөл байхгүй ч уул уурхайтай харилцан уялдаатай дэд бүтцийн төслүүд бол цөөнгүй. Тухайлбал, уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалт бүхий авто замууд, эрчим хүчний эх үүсвэр барих, төмөр зам барих, хилийн боомтын нэвтрэх чадварыг дээшлүүлэх, боомтын суурьшлын бүс байгуулах гэх мэт томоохон төслүүд бий.

-Төмөр зам барих төслийн тендерт компаниуд хандаж байгаа юу?

-Концессын зүйлийн жагсаалтад нэмэлт өөрчлөлтөөр нийт 2,000 орчим км төмөр замыг хоёр үе шаттайгаар барьж байгуулахаар тусгасан. Эхний үе шатанд төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгож, тус төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн судалгааг хийж байгаа. Судалгааны урьдчилсан дүнд төмөр замын хоёр дахь үе шаттай хамтатган нэг төсөл болгож хэрэгжүүлнэ. Энэ нь хөрөнгө оруулалт татах, суурь бүтэц барих зардлыг бууруулах, цаг хугацаа хэмнэх зэрэг талтай. Төслийг хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний санхүүжилт шаардлагатай бөгөөд Тавантолгойн нүүрсний ордны стратегийн хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, нөхцөлтэй уялдаатайгаар шийдвэрлэхээс өөр аргагүй юм. Хуулийнхаа дагуу холбогдох шийдвэрүүд нь тухай бүрдээ гараад явна. Авто зам барих төслүүдийн тухайд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалттай авто зам барих концесс олгох уралдаант шалгаруулалтыг явуулж байгаа, дотоод гадаадын компаниуд ч идэвхитэй оролцож байгааг хэлэхэд таатай байна.

-Уул уурхайн салбарт PPP-ийг хэрхэн хэрэгжүүлэх боломжтой вэ?

-Олон улсын туршлагаас харахад уул уурхайн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх боломж тухайн орны эдийн засгийн хөгжил, хууль эрх зүйн орчноос хамаарч харилцан адилгүй байдаг. Монголын хувьд уул уурхайн салбарыг хөгжүүлэх, хурдыг нь нэмэгдүүлэхийн тулд дэд бүтцийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх өргөн боломж, мөн зайлшгүй шаардлага байгаа. Төр, хувийн хэвшлийн түншлэл буюу концессын гэрээг байгуулахад баримталдаг зарчим болох төслийн төрөл бүрийн судалгаа, шинжилгээг аль болох ул суурьтай, олон сонголтыг хооронд нь харьцуулж хийх, өрсөлдөөн, ил тод байдлыг дэмжих, гэрээ байгуулсны дараах хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх гэх мэтээр төр, хувийн хэвшлийн аль алинд нь ашигтайгаар амжилттай хамтран ажиллах бололцоотой.

Монголын хувьд төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсанаар бид дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэхтэй холбогдсон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Мэдээж дэд бүтцийн төслүүдийн дийлэнх нь уул уурхайн салбарын хөгжилд чухал нөлөө үзүүлэхүйц төслүүд бий. Концессын хуулиас гадна Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль гэх мэт бусад хууль тогтоомжоор дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөн утгаар хэрэгжүүлж байгаа гэж ойлгож болно. ■

► бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль мэндэлсэн. Анхандаа байгаль орчноо хамгаалах сайн хуультай боллоо гэж ард иргэд ч алга ташин хүлээж авсан ч удалгүй монголчууд нөхөн төлбөрийг нь яагаад ч өгч дийлэхгүйгээ мэдсэн. Компаниудад зардлыг нь өгөөд шахаж гаргалаа ч дараа нь алтны шороон ордууд руу нинжа нар орж, байгаль орчныг бүр ч сүйтгэнэ гэсэн болгоомжлол төрж эхэлсэн. “Урт нэртэй” хуулийн хүрээнд 1700 гаруй лицензийг хамруулж, тэдгээрээс эхний ээлжинд алтны шороон ордны 254 тусгай зөвшөөрлийг цуцлах шийдвэр гарсан боловч бодит амьдрал дээр хэрэгжиж чадахгүй өдий хүрвэ. Мэндлээд хоёр жил болсон уг хууль өнөөг хүртэл хэл ам дагуулсаар л байна. Энэ хуулийг байгаагаар нь хэрэгжүүлэх гэж оролдсоноор хэзээ ч үр дүнд хүрэхгүй гэж О.Чулуунбат тэргүүтэй хэсэг улстөрч үзээд, нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг оны эхээр өргөн барьсан боловч бас л таг чиг.

“Аж ахуйн нэгж хайгуул хийгээд огт юм олоогүй бол эрсдэлээ өөрөө даах ёстой байдаг. Гэтэл энэ хуулийн дагуу хайгуул хийсэн бүх компанид улс зардлыг нь өгөх гэж байна. Татвар төлөгчдийн мөнгийг ингэж үргүй зарцуулж болохгүй биз дээ” хэмээн УИХ-ын гишүүн Я.Батсуурь тэмдэглэсэн нь бий. “Урт нэртэй” хуулийн дагуу тусгай зөвшөөрлөө цуцлуулах компаниудын нөхөн олговорт 500 гаруй тэрбум төгрөг хэрэгтэй гэсэн тооцоо байхад хоёр их наяд төгрөг зарцуулна гэсэн мэдээлэл ч дуулддаг. “Энэ жил болон дараа жилийн төсөв нийлээд ч төлж барахгүй их мөнгө” гэж УИХ-ын гишүүн О.Чулуунбат онцолсон нь бий. Үүний хажуугаар уул уурхайн компаниуд лицензээ барьцаалаад арилжааны банкуудаас асар их хэжээний зээл авсан байдаг учраас “Урт нэртэй” хууль санхүүгийн салбарт ч хүнд цохилт үзүүлэхийг Монголбанкныхан анхааруулсан. Мөн тусгай зөвшөөрлөө хураалгаад, үйл ажиллагаагаа зогсоох олон тооны алтны уурхайд ажиллаж байсан хүмүүс хоногийн хоолгүй болж, эцэстээ “нинжа” болж мэднэ гэх таамаглал ч гарах болов. Энэ бүхнээс болж УИХ-ын зарим гишүүн дээрх хуулийг тууштай эсэргүүцэж байгаа бол хууль санаачлагчид нь буу шийдэмдэг тулах нь холгүй тэмцэл ►

▶ өрнүүлж явна.

Ганц энэ жишээнээс үзэхэд хууль санаачлагчид дараа нь яаж хэрэгжих, ямар үр дагаварт хүргэх нь тодорхойгүй, судалгаа муутай “бүтээгдэхүүн” үйлдвэрлэдэг, түүнийг нь УИХ бодолцох юмгүйгээр баталдаг нь харагдах биз. Тэгээд болохгүй бол нэмэлт, өөрчлөлт оруулах шиг амархан юм байхгүй болчихож. Энэ чинь амьдрал дээр хэрэгжихгүй байна гэхээр “Өө тэгвэл засчихъя” гээд л... Өнөөдөр “Урт нэртэй” хуулийг эсэргүүцээд байгаа хүмүүс хууль баталж байх явцад хаана байсан юм бэ гэдэг ч их сонин.

Хаврын чуулганы сүүлчийн өдөр УИХ дөрвөн ч хууль баталсан билээ. Ийнхүү ганц өдөрт хэд хэдэн хууль бөөнддөг нь сайн уу, муу юу? Яг нэг жилийн өмнө Парламентын 20 жилийн ой болоход энэ хугацаанд 500 гаруй хуулийн төсөл хэлэлцэж баталснаараа сайрхаж байсан. Уг нь хэчнээн хууль

баталснаараа биш, тэдгээр нь амьдралд хэр зэрэг хэрэгжиж байгаагаар л ажлаа дүгнэх ёстой бус уу? Хууль батлах нь ч, нэмэлт өөрчлөлт оруулах нь ч амар хялбар болсон энэ үед ёстой нөгөө “Монголын хууль гурав хоног” гэдэг үг биелэлээ олж байна уу гэлтэй.

Мөн Монголын эдийн засгийн өсөлтийн хөшүүрэг болсон уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчныг тодорхой, ойлгомжтой болгохгүй бол горьгүйг мэргэжилтнүүд ч онцолж байна. Олон улсын санхүү, эдийн засаг эргээд хямралд орох юм бол Монгол шиг жижиг, нээлттэй эдийн засаг гарцаагүй өртөх тухай Дэлхийн банк ч анхааруулжээ. Гэтэл гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын амин чухал уул уурхайн салбарын “малгай хууль” ч тодорхой бус хувь заяатай байна. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт хийсний эцэст хайгуулын лиценз олгож эхлэх чиглэлийг Ерөнхийлөгч өгөөд байгаа шүү дээ. Өнгөрсөн хаврын чуулганаар

амжиж энэ хуульд нэмэлт өөрчлөлт оруулна гэж ярьж байв. Анх дөрвөн ажлын хэсэг тусдаа ажиллаж байсныг хумиж, Ерөнхийлөгчийн дэргэд ажлын хэсэг байгуулагдсан билээ. Иргэний танхимаар хэлэлцүүлэг өрнүүлж, салбарын хүмүүс, эрдэмтэн мэргэдээс санал авч байгаагаас үзэхэд урт удаан хугацаанд хэрэгжүүлж болохоор хууль төрөх байх хэмээн салбарын хүмүүс горьдож буй аж. Ашигт малтмалын тухай хуулийг анх 1994 онд баталсан бол 1997 онд агуулгын хувьд нэлээд өөрчилж, 2006 онд бас л гар хүрсэн билээ. Тиймээс УИХ, Засгийн газар бүр санааныхаа зоргоор хуулийг өөрчилж байдаг жишиг тогтчих вий гэсэн болгоомжлол олон нийтэд бийг сануулах юун. Муу нэр баллавч арилахгүй гэдэгчлэн гадаадын хөрөнгө оруулагчдын дунд “тогтворгүй” данстай болж мэдэх нь. ■

Компанийн нийгмийн хариуцлага

Улсынхаа хөгжлийн төлөө юу хийж чадах вэ?

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн ивээл дор Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГОУХАН)-ийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрөөс “Өрсөлдөх чадвар ба компанийн нийгмийн хариуцлага”, Хариуцлагаа ухамсарласан аж ахуйн нэгж эдийн засгийн тогтвортой хөгжлийн төлөө юу хийх ёстой вэ? сэдэвт олон улсын бага хурлыг энэ сарын 6, 7-нд “Их тэнгэр” цогцолборт зохион байгууллаа. Бага хурлаар компанийн нийгмийн хариуцлагыг хэрхэн ойлгох, компанийн нийгмийн хариуцлагын стандартыг нэвтрүүлснээр аж ахуйн нэгж байгууллагуудын өрсөлдөх чадвар хийгээд улс орны эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх боломж зэрэг асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Ер нь дэлхий дахинааараа даяарчлагдаж буй өнөө үед аж ахуйн нэгжүүд компанийн нийгмийн хариуцлага (КНХ)-ын стандартуудтай байнга тулгарч, нийгмийн зүгээс ирж буй хүлээлт, хэрэгцээнд зохицож ажиллах шаардлагатай болоод байгаа билээ. Иймээс аж ахуйн нэгжүүд урт хугацааны турш эдийн засгийн өрсөлдөх чадвартай байж нийгэмдээ



хүлээн зөвшөөрөгдөхийн тулд өөрийн хүрээлэн буй нийгэм, экологийн орчинд стратегийн хөрөнгө оруулалт хийж хөгжүүлэх нь чухлыг хуралд оролцогчид санал нэгтэй тэмдэглэсэн.

Тус хуралд Дэлхийн компанийн засаглалын нэгдсэн сүлжээг үүсгэн байгуулагч Брад Гоогинс, Германы компанийн засаглалын төвийн удирдах зөвлөлийн гишүүн Михаель Бюрш, Германы томоохон компаниудын төлөөллөөс гадна Монголын аж ахуйн нэгжүүд мөн төр, төрийн бус байгууллагын нийт 120 гаруй төлөөлөгч оролцсон юм. Энэхүү арга хэмжээг

Монголын компанийн засаглалын хөгжлийн төв, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, Германы компанийн засаглалын төв, Герман-Монголын бизнес эрхлэгчдийн холбоо, Монголын бизнесийн зөвлөлтэй хамтран зохион байгуулж, мэдээллийн түншээр “Mongolian Economy” сэтгүүл ажилласан. Монгол Улсын хувьд шинэлэг компанийн нийгмийн хариуцлагын тухай хариуцлагатай ярьсан дээрх хурлын дэлгэрэнгүй сурвалжлагыг манай сэтгүүлийн дараагийн дугаараас уншаарай. ■

Салбарын хүний үг

Д.Мөнх

Монгол захиралтай компани олон улсын хөрөнгийн зах зээлээс мөнгө босгоод, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг дааж, эх орныхоо нэрийг сайнаар гаргаж байгааг сонсоход сайхан. Ийм нэгэн жишээ бол “Хүннү коал” компани юм. 2010 оны хоёрдугаар сард Австралийн хөрөнгийн биржид IPO хийж, 20 сая доллар босгосон тус компанийн зах зээлийн үнэлгээ хэдхэн сарын дотор тав дахин өсөж, олныг гайхшруулсан удаатай. Шинэ оны босгон дээр Австралийн уул уурхайн “Resourcestocks” сэтгүүл Монголын “Хүннү коал” компанийг шилдгийн шилдгээр шалгаруулсан юм.

Тус компанийг удирддаг монгол залуу Т.Лхагвадоржийг гадаадын хөрөнгө оруулагчид Жорж нэрээр нь андахгүй. Тэрбээр “Эрдэнэт”, “Монросцветмет”, “Энержи ресурс” зэрэг Монголын уул уурхайн томоохон бүтээн байгуулалтад гар бие оролцож явсан нэгэн. Австрали түнш Матью Вүүдтэйгээ хамтарч өөрсдийн бизнесийг босгох хүсэл нь түүнийг ид хөгжлийн гараан дээрээ ирээд байсан “Энержи ресурс” компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалаас татгалзахад хүргэжээ. Өдгөө тэрбээр Австралийн хөрөнгө оруулагчдыг алмайруулсан “Хүннү коал” компанийг удирдан явна. Үүний хажуугаар тэрбээр алт, зэсийн “Вояжер ресорсез” компанийн захирлын албыг хашиж, монгол компаниудад Австралийн хөрөнгийн биржид гарах дардан замыг нээсэн. Учир нь, “Хүннү коал”-ыг харууцлагатайг мэдэрсэн австраличууд хожим нь Монголын төмрийн хүдрийн хайгуулын “Харанга ресорсез” компанийг ч алга ташин хүлээж авсан билээ.

Нүүрсний хайгуулын чиглэлээр 10 гаруй төсөл хэрэгжүүлж, монголчуудаа дэмждэг “Хүннү коал” компани өнөө маргаашгүй олборлолтоо эхлүүлэх гэж байгаа юм. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Т.Лхагвадоржтой хийсэн ярилцлагаас сонирхоно уу.



Т.Лхагвадорж: Амжилтын гол үндэс хүн хүчдээ л байдаг

-Яг нэг жилийн өмнө уулзаж байхад “Хүннү коал”-ын хувьцааны ханш Австралийн хөрөнгийн биржид гэрлийн хурдаар өсөж байсан. Энэ хугацаанд танай ажил хэр урагшлав?

-Хувьцааны үнийн тал дээрх компанийн амжилтыг орхиод, хэр зэрэг өргөжсөнөө эргээд нэг харъя л даа. Жилийн өмнө “Хүннү коал” 15 ажилтантай байсан бол одоо 100 орчим ажилтантай болсон байгаа. Мэдээж ажлын ачаалал ихэссэн учраас л олон хүнтэй болсон гэсэн үг. Дээр нь манай төслүүд дээр туслан гүйцэтгэгч 300-400 хүн ажиллаж байна. Хамгийн гол нь хайгуулын ажил учраас төслүүддээ бид нэлээд мөнгө, цаг зарцуулж байгаа юм. Дээрээс нь хайгуулаа хийгээд, нөөцийг нь тогтоосон газруудаа ашиглалтад оруулахын тулд олон талын судалгаа хийж байна. Жилийн өмнө бид дөнгөж хайгуулаа эхэлж байсан бол одоо нэлээд эрчимтэй хайгуултай, олон улсын стандартын дагуу тогтоосон нөөцтэй, уурхай эхлүүлэх гэж байгаа компани болсон байна. Ер нь цар хүрээ нэлээд нэмэгдсэн гэж хэлж болно.

-Өмнөговь дахь танай Цант-Уул төслийн нөөц нь ямаршуу байгаа вэ. Уурхайгаа энэ оны аравдугаар сард багтааж эхлүүлнэ гэж байсан, бэлтгэл ажил хэр явж байна вэ?

-Цант-Уул нүүрсний уурхайг нээгээд, ашиглалтынхаа лицензийг аваад удаагүй байна. Өнөө маргаашгүй

ТЭЗҮ-ийг нь хэлэлцүүлэх гэж байгаа. Тоног төхөөрөмж есдүгээр сардаа багтаад уурхайд ирчихсэн байх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Цант-Уулын хэмжээнд олон улсын стандартаар тогтоосон нөөц нь 167 сая тонн нүүрс. Тэндээс бид ойрын 5-6 жилдээ олборлож болох 20 орчим сая тоннын нөөцтэй хэсэг газрын тооцоог илүү нарийвчлалтай хийгээд, ТЭЗҮ боловсруулсан байгаа. Бэлтгэл ажил эрчимтэй явж байна. Өнгөрсөн хавар бид тэнд хоёр га газарт мод бут тарьсан. Уурхайн орчимд болон зам дагуу цэцэрлэгжүүлэлт бий болгосноор тоосжилтоос хамгаалж байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, бид уурхайгаа эхлүүлэхээсээ өмнө урьдчилаад бэрхшээлээ олж харж, түүнийг шийдвэрлэх арга замаа эрэлхийлж байгаа юм. Мөн археологийн малтлага судалгаа заавал хийх ёстой байдаг. Энэ ажлыг манайхан хийлгээд дуусчихсан. Уурхайн орчимд нутагладаг айлуудыг нүүлгэн шилжүүлэх асуудлыг орон нутгийнхантай яриад зохицуулсан. Энэ нь газар хөндөхөөсөө өмнө бүх ажлаа яг таг болгож байна гэж ойлгож болно.

-Жилдээ хэдэн тонн нүүрс олборлохоор байгаа вэ. Дэд бүтцийн асуудлаа шийдсэн үү?

-Эхлээд нэг их олборлож чадахгүй ээ. Энэ он дуустал сайндаа л 300 мянган тонныг олборлох болов уу. Багцаагаар сардаа 100 мянган тонн гэж тооцоолж болно. Энэ хэмжээ

ирэх жилээс ойролцоогоор 1.5 сая тоннд хүрнэ. Төслийн хүчин чадлыг жилдээ гурван сая тоннд хүргэнэ гэсэн зорилготой байгаа. Дэд бүтцийн хувьд манайх одоо нүүрс зөөж байгаа замаас 38 километрийн зайд байдаг юм.

-“Хүннү коал” нүүрсний хайгуулын 10 гаруй төсөл хэрэгжүүлж байгаа. Тэдгээрээс хамгийн их найдлага тавьж байгаа, амин судас нь аль вэ?

-Амин судас гээд нэгийг нь онцолж нэрлэхэд хэцүү л дээ. Олон хүүхэдтэй айлаас аль хүүхдэдээ хайртай вэ гэдэг шиг юм асууж байна шүү (инээв). Бид бол мэдээж төсөл болгоноо чухал гэж үзэж байгаа. Гэхдээ байршил, нүүрсний чанар зэргээсээ болоод хэдийд алийг нь ашиглалтад оруулбал эдийн засгийн үр өгөөжтэй байх вэ гэдгээ харж байж төлөвлөгөөгөө боловсруулж байгаа юм л даа. Одоогийн байдлаар хайгуул хамгийн сайн хийсэн, нөөцийг нь тогтоосноороо Цант-Уулын уурхайд ач холбогдол өгч байна. Нүүрс нь Тавантолгойн хэмжээнд хүрсэн өндөр чанартай биш ч гэсэн эдийн засгийн үр ашигтай ажиллах тооцоо гарсан төсөл учраас хамгийн түрүүнд хэрэгжүүлж гэж байгаа юм. Дараагийн төсөл гэвэл Говь-Алтай аймаг дахь “Алтай нүүрс” нэртэй төсөл. Тэнд өмнө нь хайгуул хийгдсэн ч нарийвчилсан судалгааны тал дээр арай учир дутагдалтай байгаа учраас бид одоогоор өрөмдлөгийн ажлаа явуулж байна.

-Эхний уурхайгаа ашиглалтад оруулчихаад, Хонконгийн хөрөнгийн биржээс мөнгө босгоно гэж Та ярьж байсан. Энэ ажил хэр урагшилж байна вэ?

-Бид энэ жилдээ хувьцаагаа Хонконгийн хөрөнгийн биржид санал болгохоор төлөвлөж байсан. Гэхдээ сарын өмнөөс дэлхийн эдийн засаг хямралын байдалтай болчихлоо. Олон улсын зах зээл хөдөлгөөнтэй болоод ирэхээр хөрөнгө оруулагчид болгоомжтой хандаад эхэлдэг. Бидний ажлын хувьд ч гэсэн одоо уурхай эхлэх гэж байна, дөнгөж саяхан нэг шинэ төсөл авсан, түүнийхээ хайгуулыг хийгээд үр дүнг нь зарласны дараа Хонконгийн биржид гарах юм бол хөрөнгө оруулагчдын итгэлийг төрүүлэх хэмжээнд байх болов уу. Тиймээс тэр ажлыг тодорхой хугацаагаар хойшлуулсан. Гэхдээ олон улсын хөрөнгө оруулагчид хувьцаагаа хэзээ гаргах болон ямар хэмжээний мөнгө босгох вэ гэдгийг сонирхоод л байгаа. Тэр бүхэнд “бидэнд наана нь хийх гэрийн даалгавар байна, түүнийгээ

хийж байна” гэж хариулж байна.

-Америк, Европын төсөв, өрийн хямралаас болж олон улсын хөрөнгийн зах зээл цохилтод орж байгаа энэ таагүй байдал хэр удаан үргэлжлэх бол?

-2008 оны хямралыг 1929 оны биржийн хямралын хэмжээнд хүрсэн гэдэг шүү дээ. Саяын хямралыг бас л бараг тэр хэмжээнд хүрлээ гэсэн мэдээлэл гараад байсан. Гэхдээ АНУ, Европын орнуудын эрх баригчид хямралыг бүр гүнзгийрчихээс нь өмнө ямар арга хэмжээ авах нь вэ? Гуравхан жилийн өмнөх гашуун туршлага байж байгаа учраас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар ид ярьж байх шиг байна л даа. Мэдээж гарц олж л таарна. Гэхдээ эдийн засгийг сайжруулах ямар нэгэн арга хэмжээ авахаар үр дүн нь шууд гардаггүй, тодорхой хугацаа шаардана. Тэр хугацаа нь харин нэг жил байх нь уу, хоёр жил байх нь уу гэдгээс л шалтгаална. Тиймээс бид өдөр тутам санхүүгийн мэдээ мэдээлэл хараад, байдлыг ажиглаж байна.

-Австралид бол “Хүннү коал” хамгийн таатай үед гарсан, тийм ээ?

-Тэгсэн. Гэхдээ одоо бол Австралид тийм ч таатай биш байгаа. Засгийн газраас уул уурхайд өндөр татвар ногдуулах, байгаль орчны талаасаа илүү өндөр шаардлага тавих бодлого баримталж эхэлсэн. Тиймээс хүмүүст Австралид хөрөнгө оруулж байхаар гадагшаа хөрөнгө оруулсан нь дээр гэсэн бодол төрж эхэлсэн байх.

-Тэр тусмаа Австралийн хөрөнгө оруулагчдын дунд Монголын уул уурхай, монгол компаниуд моодонд ороод байгаа юм биш үү?

-Сүүлийн үед ажаад байхад Австралиас хөрөнгө оруулагчид Монголд олноор ирж байна. Зарим нь илээр, зарим нь далдаар, зарим нь дуугүйхэн шиг ирээд салбар компаниа байгуулаад, боломж юу байна вэ? гэж харж байна. Манай орны хувьд үнэхээрийн ашигт малтмалын нөөцөөр баялгийн зэрэгцээ одоохондоо хамаг юм тэгтлээ үнэд орчихоогүй байгаа үе гэх үү дээ. Тийм ч болохоор зөвхөн Австрали гэлтгүй Канадаас ч, Америкаас ч хөрөнгө оруулах сонирхол маш их байна. Хөрөнгө оруулалтаас шалтгаалаад манай төгрөг ч чанга хэвээр байх шинж ажиглагдаж байгаа.

-Танайхыг IPO хийх гэж байх үед Австралийн “супер татвар”-ын тухай яриа ид өрнөж байсан. Тэр үеэс л Австрали улс уул уурхайн компаниудад ээлтэй биш болох нь

тодорхой болсон шүү дээ. Гэтэл “Хүннү коал”-ын хувьцааны ханш эхний хэдхэн сарын дотор тав дахин өссөн. Австралид байдал муудах тусам монгол компаниудад сайнаар нөлөөлж байна гэж Та бодохгүй байна уу?

-Хувьсгалын тохироо бүрдсэн л гэдэг юм хэлэх гээд байх шиг байна аа даа (инээв). Мэдээж Австралийн уул уурхайн компаниуд татварын өндөр дарамтад ажиллаж байхаар арай гайгүй газар хөрөнгө оруулья гэж харж байгаа. Дээр нь байнгын өсөлттэй яваад байх боломжтой газар хаа байна

Монгол Улс бусад орныг бодвол урт удаан настай, өөрийн гэсэн хөгжлийн түүхтэй. Заавал дайн байлдаан хийсэндээ биш, тэр гүрнийг босгохын тулд ямар бодлого баримталсан бэ? Тэр бодлогыг л авч чадвал Монголын шилдэг хөгжлийн загвар болох байх.

гэж эрэлхийлнэ.

Тухайлбал, нэг сайн үйлдвэр байлаа гэхэд тэнд хөрөнгө оруулчихвал жилдээ 20 хувийн ашигтай байна гэдэг нь тодорхой. 20 хувийн ашгийг хангалттай гээд, сэтгэл хангалуун байдаг хөрөнгө оруулагч нар байна. Гэтэл өнөөдөр ашиггүй ч дараагийн ашиг нь 10, 20, 30, 40 хувь гээд өсөөд явах боломжтойг харуулдаг бизнес төлөвлөгөөтэй шинэхэн компаниуд ч бий. Иймэрхүү компаниудыг сонирхдог, ирээдүйн өндөр ашгаа бодож итгэдэг хөрөнгө оруулагчид ч мөн байна. Тийм итгэлийг төрүүлсэн газар нь Монгол байсан байж магадгүй юм.

-Итгэлийг хүлээнэ гэснээс “Хүннү коал” Австралийн хөрөнгийн биржийн 2010 оны шилдэг IPO-гоор шалгарсан. Мэдээж компанийн засаглалыг сайн хэрэгжүүлж байж

► **хөрөнгө оруулагчдынхаа итгэлийг хүлээж байгаа байх. Энэ тухай ярихгүй юу?**

-Миний өмнө нь хэлсэнчлэн 15 хүнээс 100 гаруй ажилтантай болно гэдэг том өсөлт. Гэхдээ томрох тусам илүү хариуцлага хүлээнэ. Хувьцаа нь олон нийтэд зарагдаж байгаа болохоор тэр хариуцлага байнга ухамсарлаж байх хэрэгтэй болно. Тайлан тооцоогоо яг л хөрөнгийн биржээс шаарддаг стандартын дагуу хугацаанд нь гаргаж өгч байхаас эхлээд үүрэг хариуцлага их. Тайлангаас зарим хүн хэрэгтэй мэдээллүүдээ авна, гэвч хэдий сайн тайлан гаргалаа ч бас ойлгомжгүй зүйл байхыг үгүйсгэхгүй. Тийм учраас үйл ажиллагааныхаа явцын талаар гол хөрөнгө оруулагч нартаа очиж, биечлэн уулзаж танилцуулах нь нэлээд чухал байдаг. Тухайлбал, нэг том хөрөнгө оруулалтын сан 100 компанид мөнгөө хуваагаад хийчихсэн байж болно. “Хүннү коал”-ын хувьцаа өнөөдөр сайхан харагдаж байснаа хоёр, гурван сар ямар ч мэдээлэл өгөхгүй, холбоо тогтоохгүй байвал за за сүүлийн үед эднийхээс ердөө чимээ алга, нэг л биш дээ гээд сонирхол нь буураад хувьцаагаа зарчих тохиолдол байж болно. Тийм сан 100 компанийн санхүүгийн тайланг нэгбүрчлэн уншихгүй шүү дээ. Тиймээс л бид хөрөнгө оруулагчдын итгэл, үнэмшлийг олохын тулд ийш тийшээ явж, мэдээллээ өгч ярилцахад цаг заваа зарцуулдаг юм. Хөрөнгө оруулагчид ч “Хүннү коал” хоосон цаасаар ажилладаг компани биш юм байна шүү гэдгийг хардаг.

-Амжилтын нэг хэсэг нь мэдээллийн ил тод байдал, мэдээллээ хүргэж буй арга барил гэж Та хэлэх гээд байна уу?

-Энэ зүгээр нэг хэсэг нь (инээв). Амжилтын гол үндэс хүн хүчдээ байдаг учраас манай компанийн чадалтай ажилтнууд, төслийг хариуцаж яваа монголчууд маань шүү дээ. Тэд нар л хариуцлагатай хандаад, бидний хүлээж байсан үр дүнг гаргаад ирж байгаа юм. Тэдний л гавьяа.

-10 жилийн дараа танай компани ямаршуу байх вэ?

-Ер нь бол 10 жил битгий хэл, таван жилийн дараахыг урьдчилаад хэлэх хэцүү. Гэхдээ юмыг сайхнаар төсөөлөхөд Америкийн “Пибади”, Хятадын “Шиньхуа” гэдэгтэй адил Монголын нүүрсний компани гэхэд “Хүннүкоал”-ыг хүмүүсмэддэг болоосой гэж хүсдэг. Мэдээж олон улсын уул уурхайн “мангас” компаниудын дайнд

очихгүй ч “Хүннү коал” ажлаа сайн хийдэг, хариуцлагатай, үйл ажиллагаа нь жигд явдаг гэсэн нэр хүндтэй, байр суурьтай болсон байх болов уу.

-Тэгвэл 10 жилийн дараа танай төслүүд хэр урагшилсан байх бол.

-Ямар ч байсан ойрын таван жилийн дотор багаар бодоход гурван нүүрсний уурхай ажиллуулчихсан байх төлөвлөгөөтэй. Энэ бол том ажил. Нэг компани гурван уурхай ажиллуулах амар зүйл биш ч гэсэн бид тэр зорилгод хүрэх төлөвлөгөөтэй байгаа. Хэмжээ нь бол мэдээж зах зээлээс хамаарна. Зүгээр нүүрс ухаад гаргах нэг ажил. Түүнтэй холбоотой дэд бүтцийг хэрхэн шийдвэрлэх вэ, төр, засгийн бодлоготой яаж нийцүүлэх вэ гэдэг л ээдрээтэй асуудал болов уу. Тэр бүхэнтэй уялдуулаад л ажиллана даа.

-Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэхээр ярьж байгаа. Таны хувьд ямархуу байдлаар өөрчлөлт ороосой гэж бодож байна вэ?

-Одоогоор би ямар хуулийн төсөл яваад байгааг мэдэхгүй. Ямар ч л байсан тогтвортой, байнга мөрдөөд явж болох, нэг их хүн айлгаад байхааргүй л хууль байгаасай гэж бодож байна.

-Нүүрсээр манайх Австрали улстай өрсөлдөж чадах уу?

-Чадна.

-Та их итгэлтэй байна аа. Сүүлийн үед улс орнууд сэргээгдэх эрчим хүчинд анхаарлаа ихэд төвлөрүүлж буйгаас нүүрсний эрэлт хэрэгцээ буурна гэж үзэх хүн цөөнгүй байгаа юу гэж боддог вэ?

-Ер нь манай нүүрсний экспортын зах зээл хоёр, гуравхан жил үргэлжилж байна. Өөрөөр хэлбэл, бид нялхаараа дөнгөж учраа олох гээд л, зах зээлд гарах гээд л хөлсөө гоожуулаад үзээд байна. Дэлхийн зах зээл гэдгийг томоор харах хэрэгтэй. Япон улсад гэхэд л газар хөдлөлтийн хохирлоо нөхөн сэргээхэд нь түүхий эд, тэр дундаа нүүрс маш их хэрэгтэй болно. БНСУ хурдтай хөгжиж байна, Хятадын өмнөхөн талд Энэтхэг гэсэн маш том зах зээл байна. Заавал Энэтхэг манайхаас нүүрс авна гэдэгтээ биш, Энэтхэгийн зах зээл Хятадынхтай өрсөлдөнө гэсэн үг. Тэгэхээр Хятадын Австрали, Америк, Бразил зэрэг орноос авч байгаа нүүрсийг тодорхой хэмжээгээр Энэтхэг хуваалцах хэрэгтэй болно оо доо? Тэр зайг нь Монгол нөхөхийн тулд яах вэ? Дээр нь тэрбум хүнтэй Африк тив сүүлийн үед хөгжлийн шатандаа ороод байна. Тийм болохоор хөгжсөн орнуудын зах зээл ханачихсан юм шиг харагдаад

байгаа боловч хөгжиж буй орнуудын маш том зах зээл байгаа учраас нэг их эмээх зүйлгүй. Манай нөөц дуусна гэж ч эмээх хэрэггүй, бид нөөцөө илрүүлж ч амжаагүй байна. Тийм учраас ажиллах хэрэгтэй.

-10 жилийн дараа “Хүннү коал” ямар байхыг Та хэлсэн. Тэгвэл 10 жилийн дараа Монгол Улс ямар байх бол. Сүүлийн хэдэн жилд уул уурхай өргөжин тэлж байна, энд тэндгүй уурхай ажиллах боллоо. Энэ бүхэн биднийг юунд хүргэх бол.

-Зөвхөн уул уурхай дээр түшиглэн хөгжөөд бид баян болно гээд суугаад байх юм уу? Арабын орнууд газрын тосоо зараад л баяжаад байна гэдэг шиг байвал буруудна. Уул уурхайн орлогыг эргээд удаан хугацааны хөгжилд шаардлагатай хөрөнгө оруулалтад зарцуулах нь зөв болов уу. Эхний ээлжинд ашгийнхаа ихэнх хувийг боловсрол, эрүүл мэндэд зарцуулах хэрэгтэй гэж би боддог. Дараа нь мэдээж дэд бүтэц болон бусад асуудлаа анхаарах хэрэгтэй. Хүн эрүүл, боловсролтой байх юм бол улс орноо хөгжүүлж чадна шүү дээ, тэр нь газар дорх баялгаас ч илүү чухал.

-Тэгвэл манай төр, засаг хэрэгтэй зүйлээ оноод хийж чадах болов уу?

-Угаасаа нийгэм өөрөө шаардана. Шаардлага үүсээд эхлэхээр аяндаа шийдвэр гарах байлгүй дээ. Одоо ч боловсролын тал дээр нэг үеэ бодвол нэлээд анхаарал тавьдаг болчихсон байна. Хүн мэдээж эрүүл, боловсролтой байхыг хүснэ. Үүнд л нийцүүлж бодлого шийдвэрээ гаргах байх. Монголын хувьд цөөхөн хүн амтай, дээр нь залуу иргэдтэй. Залуучууд нь чадвартай байх нь л чухал шүү дээ.

-Хөгжлийн загвар гэж яриад байгаа. Монгол Улс маань Чили, Австрали, эсвэл Арабын нэгдсэн Эмират шиг бодлого баримталбал хөгжих юм байна гээд байдаг. Таны хувьд Монгол аль улсыг дагавал зүгээр вэ?

-Монгол Улс чинь бусад орныг бодвол урт удаан настай, өөрийн гэсэн хөгжлийн түүхтэй. Заавал дайнбайлдаан хийсэндээ биш, тэр гүрнийг босгохын тулд ямар бодлого баримталсан бэ? Тэр бодлогыг л авч чадвал Монголын шилдэг хөгжлийн загвар болох байх. Түүнээс биш энэ улсынх мундаг юм аа гэхгүй. Яагаад гэвэл монгол хүн, Монголын газар нутаг, түүх нь хүртэл их өвөрмөц гэж ярьдаг шүү дээ. Тийм хүмүүс бусдыг дагах шаардлага байхгүй л гэж бодож байна (инээв). ■

Энгийн асуулт

Уул уурхайн салбар Монгол Улсыг хөгжилд хүргэх үү? Хөгжинө гэж үзвэл бидний амьдралд ямар өөрчлөлт гарах вэ?



Ж.Жаргалсайхан /Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга/:

Уул уурхайг хөгжүүлэх нь хүмүүсийн амьдралыг сайхан болгох үндэстэй. Ганцхан зөв жолоодож авч явах чухал. Үүнд нэгдүгээрт, төрийн бодлого шийдвэрлэх үүрэгтэй. Төр эрдэс түүхий эдийн ордоо яаж ашиглах вэ гэдгээ зөв тодорхойлоод явбал бизнес эрхлэгчид тэр л түвшинд үйл ажиллагаагаа явуулна.

Мөн гадаад зах зээлд борлуулах экспортын чиглэлийн бодлого хэрэгтэй. Удаан хугацааны гэрээ хэлэлцээр улс орнуудтай байгуулна гэсэн үг. Жишээлбэл, бид Тавантолгойгоос нүүрс гаргаж байна. Хоёр, гурван компани тус тусдаа гаргаад байвал бүтэхгүй асуудал. Харин баяжуулаад, угаагаад, тэгээд Хятад, Солонгос, Япон, Европын улс орнуудтай удаан хугацааны гэрээ хэлэлцээр байгуулах хэрэгтэй. 30-40 жилийн турш Монгол Улс нь Солонгос, Хятадад баяжуулсан нүүрс нийлүүлнэ гэсэн Засгийн газрын түвшний гэрээ хэлэлцээр хийх төрийн дэмжлэг хэрэгтэй. Тэр тохиолдолд найдвартай зах зээлээ олж байна гэсэн үг. Германчууд бол коксжсон нүүрс авъя гээд байгаа. Уул уурхай Монголын ард түмний амьдралыг сайжруулна, гэхдээ аж үйлдвэрийг хөгжүүлж байж үр дүнд хүрнэ.



Я.Норомпил/ Төв аймгийн Баянхангай сумын малчин/:

Уул уурхайгаа ашиглаад хөгжилд хүрнэ гэдэгт итгэл муутай байна. Урагшаа зөөгөөд л байдаг. Зөв юм хийвэл болж л байна. Олж байгаа баялгаа ард түмэндээ зөв зориулж, монгол орныг хөгжүүлэх. Энэ салбар хөгжвөл бидний амьдралд өөрчлөлт орно, бага ч болов ухамсар сууна.



Б.Төмөртоогоо / МУИС-ийн 1-р курсын оюутан/:

Удирдлага нь зөв сайн удирдаж, хөгжүүлж чадах юм бол уул уурхайгаар Монгол Улсыг хөгжүүлэхэд амархан байх. Ингэж зөв хөгжүүлэх бүрэн боломжтой. Зөв ашиглаад ажил эрхлэлтийг дэмжиж болно. Ажилгүй хүмүүсийг ажилтай болгох гэх мэтээр хөгжүүлбэл бүх хүмүүст ашигтай, улс оронд ч гэсэн хэрэгтэй. Харин буруу ашиглавал, байгаль орчныг сүйтгэсэн дэмий зүйл болно гэж бодож байна.



Д.Бат-эрдэнэ /"Моннис интернэшнл" ХХК-ийн Геологийн төслийн дэд захирал/:

Монголд их хэмжээний хөрөнгө татах, гаднын хөрөнгө оруулагчдын сонирхох салбар бол эрдсийн салбар мөн. Манай хөдөө аж ахуйн салбарын хөгжил голдуу дотоод зах зээлээ хангахад чиглэсэн байдаг. Монгол малынхаа махыг гадагшаа гаргахад хэцүү. Жуулчлал гэхээр дэд бүтэц, үйлчилгээ, цаг агаар гээд нэг их хөгжиж чадахгүй байна. Бид эрдэс баялгаа эрж хайж, олборлож, боловсруулж, борлуулж мөнгөтэй болоод тэгээд тэр мөнгөө боловсрол, эрүүл мэнд, шинэ технологид оруулах хэрэгтэй. Дан ганц эрдэс баялгаа ашиглаад хөгжинө гэж байхгүй.



В.Батцэнгэл /МУИС-ийн Газар зүй, геологийн сургуулийн захирал/:

Уул уурхайн салбар улс орон бүрийн эдийн засагт янз бүрээр нөлөөлсөн байдаг. Энэ нь тухайн үйлдвэрлэлийн салбарын түүхэн хөгжилтэй холбоотой юм. Уул уурхайн үйлдвэрлэлийн салбар тухайн орны эдийн засагт эерэг нөлөө үзүүлсэн, ач холбогдолтой, улсын хөгжилд тэргүүлэх салбар болсон зарим нэг улс орнууд байдаг. Гэтэл ихэнх орнуудын хувьд эдийн засгийн шууд эерэг нөлөө багатай. Үүнээс урьдчилан сэргийлэх олон арга бий. Дэлхийн энэ чиглэлээр хөгжиж ирсэн улс орны эдийн засгийн хөгжлийн түүх, бэлээхэн туршлага байгаа. Үүнийг л анхаараад, зөв зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх хэрэгтэй. Шууд хэлэхэд, уул уурхайн эдийн засагт үзүүлэх нөлөө цагаар хэмжигддэг. Үнэ, хэрэгцээ хоёр өөрчлөгдөж байдаг. Үүнийг бас мэдэрч, энэ талын судалгааг давхар хийж байх ёстой. Уул уурхайг дагаад бусад салбар хөгжиж байх хэрэгтэй. Ялангуяа боловсруулах үйлдвэрүүдийг бий болгох ёстой. ■

Нөхөн сэргээлт

Яг л байснаараа



"Багануур"-ын уурхайн нөхөн сэргээлтийн байдал 2011.08.24

Э.Зоригт

Нуурын ус тайван мяралзаж, мөнгөн долгион дээрээ нарны алтан цацрагийг түмэн өнгөөр ойлгох нь үзэсгэлэнтэй. Ангир шувууд дуу аван ганганалдаад нуурын усанд умбан зугаацна. Намрын зөөлөн салхи өвсний толгойг ганхуулах агаад тэртээ зүүн урд талын жижиг дов толгодоор үхэр идээшлэнэ. Энэ бүхэн хангай нутгийн үзэсгэлэнг санагдуулах ажгуу. "Багануур"-ын уурхайн ойролцоох энэ хэсэгхэн байгалийг харахад 30 гаруй жил нүүрс олборлолт явуулсан газар гэж хэлэхийн аргагүй. 1978 оноос өдгөө хүртэл үйл ажиллагаа явуулж байгаа эл уурхайн нөхөн сэргээсэн талбай 20-иод жилийн өмнө ширгэх дөхсөн нуур, шороо тоосонд дарагдаж, эвдэрч хөндөгдсөн нүүрсний зам байжээ. 1999 оноос тус уурхайн удирдлагууд биологийн болон техникийн нөхөн сэргээлтэд анхаарч тодорхой хөрөнгө мөнгө зарцуулснаар өдгөө 129.2 га талбайг нөхөн сэргээгээд байгаа аж. Тус компани төвийн бүсийг эрчим хүчний системийн харъяа дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах буюу Улаанбаатар хотын иргэдийг гэрэл цахилгаантай, хүйтэнд дулаацах халаалттай байлгахын тулд нүүрс олборлож эхэлсэн гэнэ. Өнөөдөр "Багануур"-ын уурхай дээрх чиг үүргийн

дагуу 8.8 сая шоо метр хөрс хуулж онгон, зэрлэг байгалийн гоо үзэмжид халдсан байна. Хэдийгээр байгальд хор хөнөөлтэй ч гэсэн эрчим хүчгүйгээр хормыг ч төсөөлшгүй энэ үед нүүрс олборлохгүй байна гэдэг боломжгүй. "Багануур" ХК-ийн тэргүүн дэд захирал Б.Базар "Нүүрс олборлохгүй бол дулаан, эрчим хүчний дутагдалд орно. Бид байгальд хортой үйл ажиллагаа явуулж байгаа уурхайн хувьд сүйтгэсэн байгалиа сэргээх нь нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага, үүрэг мөн" гэсэн юм. Тус уурхайн нийт ашигласан талбайн хажууд 129.2 га гэдэг бага тоо хэдий ч огт нөхөн сэргээлт хийгээгүй олон уурхайн хувьд үлгэр дуурайл болохуйц ажил болсон нь харагдана. Ямартай ч эдний нөхөн сэргээсэн талбай дээр нь мал бэлчихтэйгээ. Өнөөдөр "Багануур"-ын уурхай уулын нэг, хоёр гэсэн хэсгүүдэд ашиглалт явуулж байгаа бөгөөд жилдээ 4.0 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай. Харин хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаараад жилдээ 3.0 сая тонн орчим нүүрс олборлодог ба 12-14 сая шоо метр хөрс хуулж байна. Харин уурхайн хувьд жилдээ 10 га газар нөхөн сэргээдэг ажээ. Ашигт малтмал олборлож байгаа тэр дундаа нүүрс олборлодог ил уурхайн хувьд

хөрс хуулах, хэт их тоосжилт үүсгэх, гол горхи ширгээх, үүний улмаас ан амьтан устгах хүртэл байгальд хор хөнөөлтэй үйл ажиллагааг явуулдаг. Манайд ашигт малтмал олборлож буй компаниуд, нөөц дуусаагүй бол нөхөн сэргээлт хийх боломжгүй гэдэг. Энэ ойлголтоос хамаарч байгальд хэзээ ч нөхөгдөшгүй хор хохирол учруулдаг. Тухайлбал, 40 гаруй жил үйл ажиллагаа явуулж байгаа жижиг "Таван толгой" ХК-ийн Үйлдвэр эрхэлсэн дэд захирал Р.Зоригтбаатар "Манай нөөц дуусах болоогүй. Өнөөдрийн байдлаар Одоогоор 10 орчим жилийн нөөцтэй гэж судлагдсан. Гэхдээ энэ нөөц нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байна. Тийм учраас нөхөн сэргээлтийг уурхай хаасны дараа л хийнэ. Өмнө нь хийх боломжгүй" гэсэн юм. Харин "Багануур"-ын уурхайн тэргүүн дэд захирал "Уурхайн нөөц дуусахаас нааш нөхөн сэргээлт хийж болохгүй гэсэн ойлголт байхгүй. Харин ч уурхайн үйл ажиллагаа дууссан хойно хаалтын нөхөн сэргээлт хийнэ гэдэг маш их хөрөнгө мөнгө шаардах ажил. Энэ нь магадгүй уурхайг анх нээж байсантай адил үнэ өртөг шаардаж ч болно. Энэ нь эргээд тухайн компанид хүндрэлтэй юм. Харин уурхайг нээсэн цагаасаа эхлээд нөхөн сэргээлтийн ажилд тодорхой хүн хүч, хөрөнгө мөнгө зарцуулж чадвал хаалтын үед хүндрэл гарахгүйгээр барахгүй үр дүн сайн гарна" гэж өөрсдийн туршлага дээр тулгуурлан хэлсэн юм.

Хэдийгээр 1999 оныг хүртэл "Багануур" ХК нь нөхөн сэргээлтэд огт анхаараагүй ч 10 гаруй жилийн өмнөөс энэ ажилд ханцуй шамлан зүтгэжээ. Олборлолт явуулсан бүх газрыг нөхөн сэргээх зорилго өмнөө тавьсан тэд жилд ойр орчимдоо 2000-4000 мод, бут зэргийг тариалдаг байна. Уурхайн явцад гарсан шороог шимт хөрс болон бусад гэж ялгаад хэлбэржүүлэлтийн ажлыг хийж нутгийн уур амьсгалд тохирсон нэг наст, олон наст ургамлыг хольж тариалдаг. Мөн уурхайн ойр орчимд цөөрөм байгуулсан бөгөөд энэ нь шороо тоосыг багасгахад нөлөөлдөг байна. Түүнчлэн "Бага гүн" нуурыг газрын гүний шүүрүүлэх усаар тэтгэж хамгаалалтад авчээ. "Багануур" ▶

ХК-ийн хамт олон нөхөн сэргээлтийн ажилд энэ мэт анхаарч байгаа ч Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга Д.Энхбат тэдний ажлыг дүгнэхдээ “Монполимет”, “Шижир алт”, “Багануур”, “Бороо гоулд” гээд хуруу дарам цөөн компани нөхөн сэргээлтэд анхаардаг. Эдгээрийг бусдаасаа арай дөнгүүр нь гэж хэлж болно. Хүн харахад тодорхой ажил хийж, байгалийг ногооруулж чадсан хэдий ч яамны шалгуурт үнэхээр хүрэхгүй” гэжээ. “Багануур”-ын уурхай “дөнгүүр” гэсэн үнэлгээнээс салахаар шийдэж нөхөн сэргээлтийн үйл ажиллагаагаа улам сайжруулах үүднээс энэ оноос

БНСУ-ын “Миреко” компанитай хамтран ажиллахаар болсон байна. “Миреко” нь нөхөн сэргээлтийн ажлыг улсдаа болоод Азид амжилттай хийдэг нэр хүндтэй компани аж. Одоогийн байдлаар тус компани нь “Багануур”-ын уурхайн ойр орчим 10 га газар туршилтын журмаар тариалсан нь амжилттай болж өнгөрөгч сарын 24 нд “Миреко”-ын дарга манай улсад айлчилж, нөхөн сэргээлтийн үйл явцтай танилцжээ. “Миреко”-той хамтран ажилласнаар “Багануур”-ынуурхайн хамт олон олборлолт явуулсан талбайгаа анх байсан хэмжээнд биш юм аа гэхэд дундаас дээш түвшинд нөхөн сэргээнэ гэдэгтэй итгэлтэй байна. ■

юмсан” хэмээн халаглана. Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ахмадын хорооны дарга Л. Дашзэвэг “Сумын төвөөс 20 гаруй км зайд олборлолт явуулснаас болоод Шар усны гол ширгэсэн. Үүний улмаас сумын төвийн иргэд усны гачаалалд ороод байна” гэв. Гурванбулаг сумын иргэдийн усны нөөцийг хангадаг байсан Шар усны гол 1962 онд үерлэж сумын төвтэй холбоо тасарч байжээ. Гэтэл өнөөдөр нутгийн иргэд усны дутагдлаас болоод нүүх үү, үлдэх үү гэсэн эргэлзсэн бодолд автана. Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг дарга Д.Баяржаргал “Алтны уурхайн буруутай үйл ажиллагаанаас болоод иргэд усны дутагдалд орж байна. Хавар, зуны цагт ширгэсэн голын сайраас ус гаргаж уудаг. Гэхдээ энэ нь чанарын шаардлага хангадаггүй. Чанаргүй уснаас үүдэлтэй өвчлөл манайд газар аваад байгаа. Цөөхөн хүн амтай гэхэд жилдээ 50 орчим хүн олгой авахуулсан тохиолдол ч байгаа” гэсэн юм. Элбэг хангалуун эх нутгийнхаа газар шороон дээр, аагим халуун зун, нүцгэн сайраас ус горьдон суух нутгийн иргэд хөөрхийлөлтэй. Бусдын буруутай үйлдлийн улмаас булаг шандаа ширгээлгээд бохир усаар ундаалж байна гэдэг харамсалтай санагдана. Төрсөн нутгийнх нь хүй дарсан чулууг хагалж, ундаалсан усыг нь ширгээж байгааг харсан иргэд эсэргүүцлээ илэрхийлж, шаардлага тавьдаг хэдий ч уурхайн удирдлагууд “Бид лицензтэй” гээд хайхардаггүй байна. Энэ талаар Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ▶

Асуудал

Монголын байгаль уйлж байна

Ч.Зөёноо

Монгол гэрээс гарч ирээд, зурагтын дурангийн өмнө санаа зовсон шинжгүй морь харах харийн хүний дүрсээр МҮОНТ-ийн “Алт тойрсон асуудал” нэвтрүүлэг эхэлж байна. Эл нэвтрүүлэгт аль улсын иргэн гэдэг нь үл мэдэгдэх хэдэн хүн Баянхонгор аймагт алт олборлох бөгөөд харь аялагатай монгол хэлээр “Манай том дарга хотод байгаа. Түүнд ашиглалтын лиценз болон бусад материал бий. Биднийг телевизийн дуранд гарч болохгүй гэсэн шаардлага Элчин сайдын яамнаас тавьсан” хэмээн мэдэн будилж зогсоно. Энэ мэт нэрээ нууцалж нүүрээ нуун өгүүлэх нийтлэг дүр зургийг бид олонтаа хардаг билээ. Газрын хэвлийг сэндийчиж, голын амь тасалчихаад эргэж ч харалгүй хаяад явах ашигт малтмал олборлогчдын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр цөөнгүй бичиж нэвтрүүлдэг. Хамгийн сүүлийнх нь гэхэд л дээрх “Алт тойрсон асуудал” нэвтрүүлэг юм. Уул нь тал, тал нь там болтлоо сэндийчүүлсэн эх нутгийн байгаль гунигтай дүнсийж, сэвэлзэх төдий салхинд шороо босон хуйлрах нь сэтгэл өвдмөөр. Монгол орны хаа сайгүй энэ мэт дүр зураг олон. Тухайлбал, Төв аймгийн Заамар, Өвөрхангайн Уянга, Бат-Өлзий, Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө гээд өврийн сайхан хангай, өргөн

сайхан тал нутгийн минь онгон зэрлэг байгаль өнөөдөр дурсамж төдий болон үлдсэнийг гэрчлэх баримт олон. Дусал ус, дэлбээгээ нээх цэцэггүй болж буй нутгаа харахаар монгол хүний сэтгэл эзгүйрнэ. Баянхонгор аймгийн малчин Ц.Баасан “Өлзийт голын зэгсэнд адуу бэлчихэд харагдахгүй шахам байсан цаг саяхан. Харин одоо гол нь ширгэж малын хамар хатгах өвсгүй, хүн амьдрах нөхцөлгүй нүцгэн тал боллоо. Уг нь сайхан хангай нутаг байсан



► Улаан сайрын нэгдүгээр багийн дарга Л.Одхүү хэлэхдээ “Биднийг шаардлага тавихаар газар ашиглах зөвшөөрөлтэй гээд хүлээж авдаггүй. Хэрвээ компанийн нэг өдрийн ажил тасалдуулбал алдагдлыг орон нутгаас төлөөрэй гэдэг. Тэд чинь өдрийн 30-40 саяар л ярина шүү дээ” гэв.

Саяхан Ашигт малтмалын газраас хийсэн уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэрсэн газрын тооллогод 15 аймгийн 56 сумын нутгийг хамарсан 500 гаруй нэгж талбайг хамруулжээ. Уг тооллогын дүнгээр Монголын нутаг дэвсгэрийн 3984.46 га талбай эвдрэлд орсныг тогтоосон байна. Чухам энэ их талбайг хэн сүйтгэсэн гэдэг нь тодорхой бус байна. Хэдийгээр төрөөс уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж гаргадаг ч дагаж мөрддөг нь ховорхон. Тухайлбал, Баянхонгор аймгийн ИТХ-ын дарга Г.Батжаргал “БОАЖЯ Байдрагийн голоос 800-1000 метр хүртэл ойр зайд олборлолт хийж болохгүй гэдэг тушаал гарсан. Гэтэл одоо голын эргээс хоёрхон алдын цаана олборлолт явуулж байна. Хууль зөрчсөн энэ мэт үйлдэл БОАЖЯ-наас Засгийн газарт уламжлагдаад эдгээр жижиг уурхайн лиценз хүчингүй болох ёстой. Гэтэл тэд өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулсаар байна” гэлээ. Бодит байдал дээр хууль тогтоомж ингэж л хэрэгжиж байна. Алт л олж байвал бусдыг үл ойшоож уух усыг нь ширгээж, унаган байгалийг нь сүйтгэх тэдний хувьд байдаг л хэрэг болжээ. Ядаж байхад яр гэгчээр “нинжа” гэх, гар аргаар алт олборлогчид байгалийн жинхэнэ дайсан. Хүрз, хувингаар зэвсэг хийсэн тэдний очсон газар бүхэн балагтай. “Нинжа” нарын алт олборлохоор ухсан нүхэнд өвс хайсан мал, алт хайсан хүн унаж үхэж байгаа тухай баримт мэдээлэл байнга сонсогдоно. Нутгийн иргэд малаа хараа хяналтгүй нэг ч хором орхиж болохоо байжээ. Малчин Хоролоо “Эцэг өвгөдийн үлдээсэн энэ сайхан бэлчээр нутгийг минь алт хайсан хүмүүс сүйдэлж дууслаа. Малаа байнга л харж явахгүй бол ухсан нүхэнд хоёр гурваараа унаж үхэх юм” гэжээ. Монгол Улсын иргэн гэх бичиг баримттай, баримтгүй хүмүүс ядуугийн түмэн зовлон тоочин алт хайн тэнүүчилсээр.

Монголын уудам нутгийн багагүй хэсэг нь гадаад, дотоодын ашигт малтмалд шунагчдын гарт сүйдлэгдэн үйлж байна. ■

Тэд бидний тухай

“Reuters” агентлагийн тусгай сурвалжлагч Дэвид Стэнвэйний бичсэн “Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд” нийтлэлийг “Mongolian Economy” сэтгүүл өмнө нь хөрвүүлэн хүргэж байсан. Тэгвэл “Reuters” энэ оны есдүгээр сарын 1-нд Тавантолгойг тойрсон асуудалтай холбоотойгоор уг нийтлэлээ шинэчлэн гаргасан нь сонирхол татна. Манай Засгийн газрын шийдвэр гаднынханд ямаршуу сэтгэгдэл төрүүлснийг эндээс мэдэж болох юм.



Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд

Эрдэс баялгийн асар их нөөцтэй Монгол Улс түүнийгээ ашигласнаар ирэх арван жилд эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийд тэргүүлнэ гэсэн хүлээлт нэгэнт үүсчээ. Наймдугаар сарын сүүлчээр Америкийн дэд ерөнхийлөгч Жо Байден Улаанбаатарт очихдоо ЗХУ-ын нөмөрт олон жил сульдсанаа үл харгалзан монголчууд ардчилалд шилжиж чадсаныг тэнгэрт тултал магтсан билээ.

Эдүгээ Монгол Улсын хувьд бяцхан эдийн засгаа хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг л эн тэргүүний зорилго юм. Засгийн газар нь энэхүү зорилгодоо хүрэхийн тулд тэвчээргүй ард түмнийхээ шахалт хийгээд хоёр аварга хөрш болох Хятад, Оросын дарамтыг яаж зохицуулах бол? Хөрөнгө оруулагчид үүнийг л хамгийн ихээр мэдэхийг хүснэ. Монголд байж болох эрсдэлүүдийг энд тоймлон хүргэе:

Тавантолгойн маргаан

Нүүрсний нөөцөөрөө дэлхийд толгой цохих Тавантолгойн орд зэс, алтны аварга Оюутолгойтой хамтдаа

олон арван жилийн турш Монголын эдийн засгийн “зүтгүүр” болох учиртай. Харамсалтай нь энэхүү ордыг ашиглалтад оруулах ажил олон талын ашиг сонирхлоос болоод саатаад байгаа юм. Гэвч ард түмний дунд их хүлээлт үүсгэсэн хувьцаагаа гаргаж, 2012 оны сонгуулиас өмнө амлалтаа биелүүлэхийн тулд Монгол Улс энэ асуудлаа аль болох хурдан шийдвэрлэх шаардлагатай болоод буй.

Төрийн өмчит “Эрдэнэс тавантолгой” компани Тавантолгойн зүүн хэсгийн хувьцааг гаргах хөрөнгө оруулалтын банкуудаа хэдийнэ сонгосон боловч энэ нь баруун хэсгийн “дуудлага худалдаа”-ны үр дүнгээс шууд шалтгаалж таарна. Өнгөрсөн долдугаар сард Монголын Засгийн газар баруун Цанхийн хөрөнгө оруулагчаар Хятадын “Shenhua”, Америкийн “Peabody” болон Орос-Монголын хамтарсан консорциумыг нэрлэсэн. Гэвч Япон болон Өмнөд Солонгосын пүүсүүдийг “анзааралгүй” хассан гэх шалтгаанаар эргэж буцаад, одоог хүртэл тодорхой ►

» шийдэлд хүрээгүй байна.

Энэхүү холион бантан Монголын геополитикийн дарамт ямар байдгийг харуулаад зогссонгүй, мөн энэ оронд үйл явц ямар замбараагүй, ойлгомжгүй байдгийг давхар илтгэж байгаа юм.

Юуг анхаарах вэ:

-Засгийн газар Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээг хийхдээ гадаадын түншүүд болон иргэний нийгэм гээд бүгдийг аз жаргалтай байлгаж чадах уу? Чадлаа ч гэсэн түүнийгээ цагт нь амжуулах уу?

-Гадаадын хөрөнгө оруулагчид Монголын тунгалаг бус шийдвэрийг ойлгож, эргэж буцсан байдлыг нь хүлээж тэсэх үү?

Популизм

Сонгууль хаяанд ирлээ. Дөрвөн жилийн өмнө ард иргэдэдээ өгсөн үнэтэй амлалтаа биелүүлэхийн тулд эрх баригч эвслийн гишүүд чадах чинээгээрээ шуурхай ажиллах хэрэгтэй болж байна.

Монголын Засгийн газар нийгмийн боловсрол болон эрүүл мэндэд анхаарахаа амлаж, уул уурхайн орлогоороо дэд бүтцийг сайжруулж эдийн засгаа шинэчлэхэд зарцуулна гэж ярьдаг. Гэсэн ч бэлэн мөнгө хурдан авахын тулд ашигт малтмалын нөөцөө хямд зарж байна хэмээн монголчууд Засгийн газраа буруушаасаар.

Зургаан тэрбум ам.долларын Оюутолгойн ихэнх хувийг Канадын "Ivanhoe mines" компанид өгөх 2009 оны шийдвэр шуугиан дэгдээсний хажуугаар гадаадын хөрөнгө оруулалттай олон тооны жижиг төсөл нийгмийн идэвхтнүүд болон зарим хууль тогтоогчийн дургүйг хүргээд буй.

Жо Байденыг ч Америк, Япон, Өмнөд Солонгосын цөмийн хаягдлыг Монголд булшлах зорилготой ирлээ хэмээн монголчууд сэжиглэж амжсан. Эдийн засаг дахь гаднынхны нөлөө улам нэмэгдэж байгаад сонгогчид ямар дургүй байгаагийн нэг том жишээ энэ юм.

Юуг анхаарах вэ:

-Монголын Засгийн газар эрдэс баялгаа хэрхэн ашиглах вэ? Төсвийн тогтворжуулалтын сан байгуулсан хэдий ч иргэдэдээ бэлэн мөнгө амласан, тараасан хэвээр л байна.

-Гадаадын хөрөнгө оруулалт Монголын "хөдөөгийн" эдийн засгийг өөрчилж байгаа ч энэхүү огцом өсөлт юу авчрах вэ? Зөвхөн Оюутолгойн хөрөнгө оруулалт л гэхэд энэ орны

Баялгийн хараал

“Баялгийн хараал”-ыг дайрч биш, тойрч гаръя

Ашигт малтмалын нөөцөөрөө Монгол Улс дэлхийд толгой цохиж явна. Зэс, алт, нүүрс, уранаас эхлээд газрын ховор элемент хүртэл манайд бий. Гэвч байгалийн баялаг дандаа сайн сайхныг авчирдаггүйг мэргэжилтнүүд сануулдаг. Монголчуудын хөгжилд хүрч чадах, эсэх нь уул уурхайн орлогоо хэрхэн удирдахаас л шалтгаалах юм.

Баялгаасаа болоод баяжсан орнууд байхад баларсан орнууд ч цөөнгүй. Аз болж бидэнд бусдын алдаанаас суралцаж, туршлагаас судлах боломж их байна. Дэлхийн банк, Олон улсын валютын сангаас эхлээд “юм үзэж, нүд тайлсан” олон хүн Чилийг Монголд тохирох загвар гэж ярьдаг. “Эдийн засгаа хэрхэн эрсдэлээс хамгаалж, орлогоо яаж зөв зарцуулж байгааг Чилийн туршлагаас харж болно” хэмээн АНУ-ын Глобал засаглал санаачилгын захирал Параг Ханна ч зөвлөж байв. Гэтэл сүүлийн үед тус улсад хүртэл үймээн самуун дэгдээд горьгүй. Товчхондоо, Монгол Улс ямар нэгэн орныг шүтэн бишрээд, дуурайхдаа гол нь биш, улс орнуудын байгалийн баялгаа хэрхэн ашиглаж буй явцаас сурсамж авах хэрэгтэй ажээ. Энэ нь монголчууд “баялгийн хараал”-ыг дайрч биш, тойрч гарахад нэмэртэй болов уу. Тиймээс “Mongolian Economy” сэтгүүл баялагтай орнуудын хөгжлийн түүхээс толилуулж байна. Энэ удаад хил залгаа оршдог хэрнээ улс төр, эдийн засгийн хувьд тэс ондоо замаар явсан Чили, Боливи хоёрын туршлагыг хүргэхийг хичээлээ. ▶

2009 оны бүхэл бүтэн ДНБ-тэй дүйцэж байгаа шүү дээ.

-Монголын Засгийн газар ард иргэдийнхээ өсөн нэмэгдэж буй үндэсний үзэл, гадаадын пүүсүүд болон ажилчдын байдлыг хэрхэн зохицуулж байна вэ?

Хараат байдал

Монголын 2.7 сая иргэний олонх нь Хятад болон Оросын манлайлал нэмэгдэж байгаад санаа зовох бөгөөд Тавантолгойд энэ хоёр их гүрэнд давуу эрх олгож байгаа нь тэдний зовиолыг улам нэмэгдүүлэв.

Энэ оны эхний хагас жилд Монголын экспортын 90 хувь нь урд хөрш рүүгээ урсчээ. Хятадууд ашигт малтмалыг ихэнхдээ л хямдралтай үнээр худалдаж авч байгаа нь тодорхой боловч Монголын эдийн засгийн хувьд ямар чухал нөлөөтэйг дээрх тооноос харж болно. Урт хугацааны хараат байдлаа багасгах боломжийг эрэлхийлж байгаа бол Монгол Улсад мэдээж бэлэн мөнгө хэрэгтэй. Харамсалтай нь бэлэн мөнгө зөвхөн

урд хөрштэйгээ хийх худалдаанаас л орж ирэх боломжтой.

Түлш, эрчим хүч, тээврийн тал дээр хоёр хөршөөсөө улам л хараат болж байгаа нь Монголын уул уурхайн салбарын гол эрсдэлийг илтгэх загвар юм. ОХУ шатахууны нийлүүлэлтээ хумиж чадна гэдгээ мэдрүүлсэн бол Хятад чухал төмөр замын гарцаа хаахдаа нэг их тоохгүй байж мэднэ. Үүний зэрэгцээ Монгол Улс нүүрсээ Япон болон өмнөд Солонгост хүргэхийн тулд Оросын төмөр замын сүлжээнээс хамаарах нь гарцаагүй.

Юуг анхаарах вэ:

-Хятадаас хараат байдлаа багасгах гэсэн монголчуудын чармайлт Оросын эзэмшлийг нэмэгдүүлэх юм биш биз? Эсвэл эсрэгээрээ, Оросоос хараат байдлаа бууруулах гэж байгаад Хятадын нөлөөг улам ихэсгэх талтай юу? Монголын нүүрс болон бусад ашигт малтмалын хувьд ойрын хугацаанд Хятадын зах зээл гэсэн ганц л сонголт байна гэж үү? ■

► Чилид болж буй бослого, ажил хаялт замбараагаа алдлаа. Оюутны холбооны тэргүүн, 23 настай Камила Валлехогийн санаачилсан хөдөлгөөнд өнгөрсөн хавраас зөвхөн оюутан, багш нар идэвхтэй оролцож байсан бол эдүгээ үйлдвэрчний эвлэлүүд хүртэл нэгдээдбайгаа юм. Чанартай боловсрол эзэмшихийн тулд их мөнгө төлөх, үгүй бол хангамж муутай улсын сургуульд элсэх гэсэн сонголт оюутнуудын дургүйг хүргэж, боловсролын салбарт зарцуулж буй төсвөө нэмэхийг Засгийн газраасаа шаардаж байгаа юм. Харин ажилчид өндөр татвар төлж байгаадаа сэтгэл дундуур байгаа ажээ. Түүнчлэн босогчид Аугусто Пиночетын үеийн Үндсэн хуулийг өөрчлөх шаардлага тавьж байгаа юм.

Ерөнхийлөгч Себастьян Пиньера тэргүүтэй Чилийн эрх баригчид самгардав. Уг нь өдийг хүртэл энэ орон Латин Америктаа нэлээд тогтвортой, сайн засаглалтайд тооцогдож явсан юмсан. Дэлхийн зэсийн зах зээлийн 30 хувийг дангаараа атгадаг энэ улс төсвийн орлогоо маш чамбай зарцуулж чаддагаараа зартай. 4630 км сунаж, говь хангайг хосолсон энэ нутгийн нэг хязгаараас нөгөө хязгаар хүртэлх агаарын температурын ялгаа нь 10 градуст хүрдэг ажээ. Зэсийн нөөцөөрөө дэлхийд тэргүүлэх Чили улсын өнөөг хүртэл туулж ирсэн зам ямар байв?

1535-1550-иад онд испаничууд Чилийн нутгийг эзлэх үедээ ашигт малтмалын арвин нөөцтэйг нь мэдэлгүй, хөдөө аж ахуйн салбарт түлхүү анхаардаг байжээ. XVIII зууны дунд үеэс л Чилийн эдийн засагт зэсийн олборлолт чухал байр суурь эзлэх болсон байна. Харин 1810 онд Чилийн ард түмэн испаничуудыг шахаж, тусгаар тогтнолоо зарлажээ. 1837 онд тус улс Аргентин улстай хамтран Боливийн эсрэг дайтсан нь амжилттай болж, Номхон далайн I, II дайны үеэр Өмнөд Америкийн баруун хэсгээр өөрийн байр сууриа бататгав. Мөн энэ үеэс зэс үйлдвэрлэхийн хажуугаар нүүрс, мөнгө олборлох болжээ. Үүний үр шимээр Чилийн эдийн засаг огцом өсөж эхэлсэн байна.

Гэвч бүх зүйл амар бүтсэнгүй. 1970-1973 онд Сальвадор Альенде Чилийн төрийн эрхийг барихдаа аж ахуйн нэгж, банкуудыг хувьчилж, хөдөө аж ахуйн салбарт ч шинэчлэл хийж эхэлсэн нь олон улсын томоохон корпорациудын дургүйцлийг төрүүлж байжээ. Энэ шинэчлэл амжилттай хэрэгжээгүйн зэрэгцээ эдийн засгийн уналт, улмаар хямралыг дагуулсан юм. Чилийн нутаг

дэвсгэрт эмх замбараагүй байдал ноёлох болж, эсэргүүцэл, ажил хаялт энгийн үзэгдэл болжээ. Чухам энэ үед л Аугусто Пиночет төрийн эрхийг булаан авч, дарангуйллаа тогтоосон байна. 1974-1990 оныг хүртэл Чилийн Ерөнхийлөгч байсан Аугусто Пиночетын үед 30.000 хүн хэлмэгдэн амиа алдсан гэдэг. Гэвч чухам түүний үед л Чилийн өнөөгийн эдийн засгийн баттай, сайн суурь тавигдсан гэж үзэх хүн цөөнгүй. Тэрбээр 1976 онд төрийн өмчит “Codelco” компанийг байгуулсан нь эдүгээ зэсийн үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлж буй. 1989 онд Чили ардчилсан орон болсон ч Аугусто Пиночетын үед хүчин төгөлдөр болсон Үндсэн хууль одоог хүртэл үйлчилж байгаа юм.

Уул уурхайн салбар Чилийн эдийн

Чили

Тусгаар тогтносон өдөр: 1810.09.18

Хүн ам: 17.1 сая, үүнээс 11 хувь нь хөдөө амьдарч байна

ДНБ: 203.4 тэрбум ам.доллар


Нэг хүнд ногдох ДНБ: 11.873 ам.доллар

Ядуурлын түвшин: 15.1 хувь

Гадаадын шууд хөрөнгө оруулалт: 2009 онд 12.7 тэрбум ам.доллар

Гадаад валютын нөөц (алт оролцуулаад): 25.3 тэрбум ам.доллар

Үндэсний валют: Чилийн песо



аж. Гэвч зэсийн үйлдвэрлэл, экспорт нэмэгдэхийн хэрээр Чилийн эдийн засагуулуурхайгаас хамааралтай болж байлаа. Дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ унахад төсвийн орлого нь шалдаа бууна гэдгийг тус улсын эрх баригчид эрт ухамсарлажээ. Тиймээс эрдэс баялгийн орлогоо уул уурхайгаас бусад салбараа хөгжүүлэхэд зарцуулсан байна. Эдүгээ металлурги, мод боловсруулалт, хүнс болон оёдлын үйлдвэрлэл Чилид чамлахааргүй хөгжсөн. Мөн загаслал болон ойн аж ахуй давамгайлсан хөдөө аж ахуйн салбар нь Чилийн ДНБ-ий долоон хувийг бүрдүүлдэг аж. За тэгээд улаанбуудай, чихрийн нишингэ, усан үзэм, төмс, жимс тариалдаг байна. Үүний хажуугаар үйлчилгээ, ялангуяа технологийн салбар нь үлэмж ихээр

хөгжиж буй аж. Тус улсын эрх баригчид боловсрол, эрүүл мэндийн салбарт нэлээд анхаардаг. Тиймээс ч өнөөдөр Чили улс зөвхөн ашигт малтмалаараа биш, уул уурхайн техник, технологийн нийлүүлэлтээр дэлхийд толгой цохиж байгаа юм.

Чилийн дэд бүтэц маш сайн хөгжсөн учраас гадаадын хөрөнгө оруулалт асар ихээр орж ирдэг. 2009 онд л гэхэд 12.7 тэрбум ам.долларыг гаднынхан энэ улсын эдийн засагт шингээжээ. 80 мянган км үргэлжилсэн автозам, 8100 км төмөр замын зэрэгцээ усан тээвэр ч Чилийн дэд бүтэцэд голлох байр суурь эзэлдэг байна.

Дэлхийн зах зээл дэх зэсийн үнийн хэлбэлзлээс эдийн засгаа хамгаалахын тулд 2000 оноос төсвийг тогтвортой байлгах санаачилга гаргаж, уул уурхайн орлогынхоо дийлэнх хэсгийг нөөцөлдөг болсон. Ингэхдээ зэсийн үнийн олон жилийн таамаглал гаргадаг мэргэжлийн тусгай хүмүүстэй болж, улсын төсвөө урт хугацаагаар төлөвлөдөг болжээ. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын хамгийн хүнд үед буюу 2008 онд хүртэл Чили 44.79 тэрбум ам.долларын орлогыг төсөвтөө төвлөрүүлсэн боловч үүнийхээ 35.09 тэрбумыг нь зарцуулж, үлдсэнийг нь нөөцөлсөн байдаг. ►

засагт голлох үүрэг гүйцэтгэдэг нь ойлгомжтой. Дэлхийн зэсийн зах зээлийн 30 хувийг эзэлдэг энэ улс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тал дээр түлхүү анхаардаг

► Чилитэй хил залгаа орших Боливи улс байгалийн хийн нөөцөөрөө дэлхийд толгой цохидог хэрнээ ядуурлаас хагацаж чаддаггүй нь хачирхалтай. Цагаан тугалга, газрын тос, цайр, гянтболд, мөнгө, төмөр, алтны нөөцтэй нутгийг эзэгнэнхэн төрсөн боливичууд мөн ой, усны баялаг ихтэй. Гэвч тус улсын хүн амын 60 хувь нь ядуу гэсэн ангилалд багтаж байгаа юм.

1532-1538 онд мөн л испаничуудад эзлэгдэж, колоничлогдож байсан энэ орон 1825 онд тусгаар тогтнолоо зарласан боловч ард иргэд нь тайван амьдарна гэдгийг хэсэгтээ л үзээгүй. “Хөнжилдөө унтах завгүй хөнөөлдөн тэмцэлдэнэ” гэдэг шиг эцэс төгсгөлгүй үргэлжлэх гадаад, дотоод дайн энэ улсын хөгжлийн тушаа болжээ.

1879-1883 онд болсон Номхон

нэмэгдүүлнэ хэмээн ард түмэндээ тунхаглажээ. Ядуу гэр бүлд төрж өссөн тэрбээр өөрөө энэхүү ургамлын ачаар л ерөнхийлөгч болж чадсанаа бахархан ярьдаг нэгэн. “Энэ навч намайг хүний хувьд, улс төрчийн хувьд төлөвшүүлсэн болохоор би америкчуудын үгэнд орж, түүний тариалалтыг хориглож чадахгүй” хэмээн Эво Моралес мэдэгдэж байсан. Эдүгээ Боливи улс Колумби, Перутэй зэрэгцэн дэлхийн кокаины зах зээлийн гол нийлүүлэгчдийн нэг болсон нь мэдээж АНУ-аас эхлээд бусад орны эрх баригчдын дургүйцлийг хүргэж байгаа юм.

2009 онд Эво Моралес шинэ Үндсэн хууль санаачлан батлуулахдаа улсынхаа нэрийг Олон үндэстний Боливи улс болгон өөрчилсөн байдаг. Түүнчлэн эдийн засгийн тулгуур

төсөвт багагүй хэмжээний хөрөнгө төвлөрүүлдэг ч тэр бүхнээ ядууралтай тэмцэхэд зарцуулсаар юу ч үгүй хоцорно. Ядуурал, ажилгүйдэл газар авсны зэрэгцээ тус улсад авлига, хээл хахууль байдаг л үзэгдэл болжээ. Дэлхийн банк далд эдийн засгийн судалгаа гаргахад Боливи улс 151 орноос хамгийн дээгүүрт цохиж явна. Боливийн далд эдийн засаг ДНБ-ийхээ 68.1 хувьд хүрсэн байна.

“Хар аравдугаар сар” гэх хэргээр өмнө нь сайд, генерал, адмирал байсан хүмүүсийг олон жилээр яллах болсон тухай мэдээлэл өнгөрсөн наймдугаар сарын сүүлчээр цацагдсан юм. Энэ хэрэгт Боливийн ерөнхийлөгч асан Гонсало Санчес де Лосада, Батлан хамгаалахын сайд асан Карлос Санчес Берсаин нарыг ч буруутгаж байгаа



Боливи

Тусгаар тогтносон өдөр: 1825.08.06

Хүн ам: 10 сая, үүнээс 34 хувь нь хөдөө амьдардаг

ДНБ: 19.7 тэрбум ам.доллар

Нэг хүнд ногдох ДНБ: 1973 ам.доллар

Ядуурлын түвшин: 60.1 хувь

Гадаадын шууд хөрөнгө оруулалт: 2009 онд 423 сая ам.доллар

Гадаад валютын нөөц 2009 онд (алт оролцуулаад): 8.5 тэрбум ам.доллар

Үндэсний валют: Боливийн песо

далайн II дайны үеэр боливичууд ялагдал хүлээж, эцэстээ Номхон далайд гарах гарцаа Чилид алджээ. Эдүгээ тус улс Монголын нэгэн адил далайд гарцгүй орон болой. 1952 онд томоохон хувьсгал болсноос хойш бараг жил бүр л хувьсгал гарч, төрийн эрх баригчид нь толгой дараалан солигдож эхэлжээ. Эмх замбараагүй байдал, иргэний дайн Боливийн хувьд өдөр тутмын үйл явдал болсон байна. Сүүлдээ тус улсын иргэний хөдөлгөөнүүд байгалийн хийн салбараа төрийн мэдэлд авахыг эрх баригчдаасаа шаардаж эхэлсэн гэдэг. Ард түмнийхээ энэ хүсэл, сонирхол дээр тулгуурлан өнөөгийн Ерөнхийлөгч Эво Моралес нь 2006 онд сонгогдон гарч иржээ. Дээд боловсрол ч эзэмшээгүй тэрбээр хийн үйлдвэрлэлийг төрийн мэдэлд авч, Америкийн “ExxonMobil”, Испанийн “Repsol”, Бразилийн “Petrobras”, Францын “Total”, Их Британийн “British Gas” зэрэг олон улсын томоохон корпорацитай хийсэн бүх гэрээг хүчингүй болгоно гэдгээ амласан байна. Түүнчлэн гадаад өрөө төлөхөөс татгалзаж, кокаин гаргаж авдаг кок ургамлын тариалалтыг

салбаруудаа төр хянадаг болжээ. Байгалийн хий болон бусад эрдэс баялгийн нөөц ард түмний өмч хэмээн шинэ Үндсэн хуульдаа тусгасан ч боливичууд энэ бүхний үр шимийг хүртсэн гэхэд хэцүү аж.

Боливийн нэг хүнд ногдох ДНБ 1973 доллар байгаа нь маш бага тоо ажээ. Латин Америкийн бусад орон дундаас зөвхөн Гондурас, Парагвай, Никарагуа л үүнээс бага үзүүлэлттэй юм байна. Уул уурхайн олборлолт их явагддаг ч нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж чаддаггүй учраас эдийн засгийн өсөлтөд нь төдийлэн нэмэр болдоггүй гэнэ.

2010 онд Боливи улс 6.1 тэрбум ам.долларын экспорт хийсний дийлэнх хэсгийг байгалийн хий, түүхий нефть, цайрын хүдэр, цагаан тугалга эзэлж байна. Мөн хугацаанд тус улс таван тэрбум ам.долларын импорт хийжээ. Бразил, АНУ, Япон зэрэг оронтой худалдаа хийдэг боливичууд эдгээр оронд газрын тосоо түүхийгээр нь өгчихөөд, эргүүлээд тэднээсээ нефтийн бүтээгдэхүүн өндөр үнээр худалдаж авдаг нь өрөвдөлтэй. Уул уурхайн салбар нь улсын

боловч хоёул Америкт амьдарч байгаа тул яллаж чадахгүй байгаа гэнэ.

2003 оны аравдугаар сард байгалийн хийгээ АНУ болон Мексикт худалдахыг эсэргүүцсэн эвлэлүүд олон тооны бослого гаргасан. Тухайн үед Эль-Альто хотын оршин суугчид нийслэлдээ хүрэх замыг хаан жагсахад зэвсэгт хүчин гал нээснээр 64 хүн амь үрэгдэж, 405 хүн гэмтсэн нь “Хар аравдугаар сар” хэмээх хэргийг үүсгэжээ. Олон жилийн турш боливичуудыг амраалгүй ирсэн бослого, үймээн өнөөдөр ч байраа тавьж өгөхдөө хойрго байгаа юм.

Саяхан л гэхэд нутгийн хоёр хязгаарыг холбох зам тавих ажлыг эсэргүүцсэн хэсэг хүн жагсаал хийсэн. Гэтэл Чилийн эрх баригчид үүнд Америкийн Олон улсын хөгжлийн агентлаг буруутай хэмээн үг хаяж амжжээ. Ер нь Боливийн эрх баригчид америкчуудад дургүйгээ нуудаггүй. Өнгөрсөн наймдугаар сард БНХАУ-д айлчилсныхаа дараа Эво Моралес “Хятад бол дэлхийн хамгийн том гүрэн. Тун удахгүй АНУ Хятадын колони болно гэдэгт би итгэлтэй байна” хэмээн мэдэгдэж байв. ■

Уншигчийн булан

“Mongolian Economy” сэтгүүлийн редакцис уншигч, захиалагч нартайгаа эргэх холбоотой байх үүднээс “Уншигчийн булан” нээж байна. Уншигч, захиалагчдад сэтгүүлийн талаарх санал хүсэлтээ илэрхийлэх боломж нээлттэй. Та

бүхнийг энд биднийг урмын үгээр тэтгэхээсээ илүүтэй, ташуурдсан санал шүүмжлэл, нийтлэл материалаа улам чанаржуулах, сэдэв, хүрээгээ өргөтгөх чиглэлийн үнэтэй санаа оноо ирүүлж байна гэдэгт найдъя.

Ч.Төмөрчулуу /Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын дарга/:

“Mongolian Economy” сэтгүүлийг уншихаар номын санд суугаад гарсан юм шиг болдог

-Хүн гэгээлэг сэтгэлтэй. “Mongolian Economy” сэтгүүл хүмүүсийн сэтгэхүйг шинэ түвшинд гарахад тус болж байгаа санагддаг.

Нөгөө талаас эргэлзээтэй таамаг, санаа бодлыг цэгцтэй болгоход хувь нэмэртэй байдаг. Миний хувьд энэ сэтгүүлийг уншихаар мэдлэг авах гээд номын санд суугаад гарч байгаа юм шиг сэтгэгдэл төрдөг. Анхны дугаарыг нь үзээд л захиалсан хүний хувьд ер нь уншихгүй байж болохгүй санагддаг болсон. Манай хэвлэлүүдээр нийтлэг гардаг шиг бохир мэдээлэл байдаггүй. Эрүүл эдийн засгийг хөгжүүлэхэд зориулагдсан гэж хэлж болно. Цалингаа аваад хүмүүс өрхийн төсвөө тооцдог доо. Тэгвэл тэрхүү өрхийн төсөвтөө “Mongolian Economy” сэтгүүлийг захиалгыг оруулахад зүгээр гэж зөвлөх байна.

Манай байнгын уншигчийн хувьд ямар санаа оноо нэмэрлэх вэ гэдэг асуулт тавьж байгаа чинь сайн байна, баярлалаа. Одоо манайд уншигчидтайгаа ийн эргэх холбоо тогтоодог хэвлэл ер нь цөөхөн байх шүү. Бараг байхгүй ч байх. Миний хувьд эдийн засгийн ойлголтыг схемчилсэн, модель маягаар ганц нэг зүйл оруулж өгөхөд гэмгүй.

Х. Шинэбат / “Нарантуул” захын 161 дүгээр лангууны түрээслэгч/:

Захирлуудын ярилцлагууд надад сайн зөвлөгөө болдог

-Би “Mongolian economy” сэтгүүлийг захиалан уншдагтаа баярладаг. Уг сэтгүүл дээр гардаг нэр хүндтэй, бизнесийн салбарт амжилт олсон хүмүүсийн ярилцлагын мэдээлэл жижиг бизнес эрхлэгч надад сайн зөвлөгөө болж чаддаг. Ярилцлагуудаа хөнгөн, сонирхолтой байдлаар өгдөг болохоор цаг зав гаргаж, уншихад хялбар байдаг.

Мөн гадаадын зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, бууралтын талаар тогтмол мэдээллэдэг нь таалагддаг. Танай сэтгүүлийн хамт олонд амжилт хүсье.

М.Уламбаяр /Орон сууцны санхүүжилтийн корпорацийн газрын захирал/:

Эдийн засаг, бизнесийн мэдээллийг цэгцтэй хүргэдэг

-Хөдөө явж явж, дөнгөж ирээд, танай сэтгүүлийн наймдугаар сарынхыг уншаад сууж байна. Наймдугаар сарын дугаартаа нийгмийн хариуцлагын асуудлыг түлхүү гаргажээ. Энэ их чухал сэдэв л дээ. Эдийн засаг, бизнесийн мэдээллийг цэгцтэй хүргэдэг нь таалагддаг.

Ер нь эдийн засгийн мэдээллийг энгийн, ойлгомжтой бичиж байхад л болно доо.

Ц.Түмэнцогт /“Женерал Электрикс” компанийн суурин төлөөлөгч/:

Макро эдийн засгийн бодлогын түвшинд ч гэсэн сайн нийтлэлүүд гардаг

-Цаг үеэ олсон чухал сэдвүүдийг зөв хөндөж чаддаг. Уул уурхайн, гадаадын хөрөнгө оруулалтын, эдийн засгийн, бизнесийн хүмүүстэй ярилцлага хийхдээ асуудлыг зөв гаргаж ирдэг. Макро эдийн засгийн бодлогын түвшинд ч гэсэн сайн нийтлэлүүд гаргадаг болохоор дэмжиж байгаа.

Цаашдаа нийтлэлүүдээ тухайн салбарт тулгамдаж буй асуудлаар олон улсын тэргүүн туршлага, дэлхийн чиг хандлага ямар байгааг түлхүү харуулсан экспертүүдийн түвшнийх байлгаж, түүнийгээ хадгалж, тууштай авч явах юм бол мөнхийн уншигчдынхаа итгэлтэй түнш байх болов уу.

Ж.Сандагсүрэн / “Очир- Ундраа” ХХК-ийн Удирдлага маркетингийн газрын захирал/:

Ирээдүйд танайх The Economist сэтгүүлтэй эн зэрэгцэж чадна

-Миний хувьд “Mongolian economy” сэтгүүл нь нэг талын цогц мэдээллийг олон талын байр суурь, баримт зэргээр баяжуулан хүргэдэг нь үнэхээр сайн юм. Танайх материалынхаа баримтыг сонирхолтойгоор дурьдаж өгдгөөрөө бусдаас өөр байж чаддаг. Мөн ярилцлага авч байгаа хүнээ сайн сонгодог гэж бодогддог. Ирээдүйд танайхыг Английн “The Economist” сэтгүүлтэй энэ зэрэгцэхүйц хэмжээнд очиж чадна гэдэгт итгэлтэй байдаг шүү. Амжилт хүсье. ■

www.mongolianeconomy.mn

тун удахгүй...

**MONGOLIAN
ECONOMY**
МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, БИЗНЕСИЙН СЭТГҮҮЛ

[Онцлох сэдэв](#) | [Шилдэг нийтлэл](#)

[Бидний тухай](#) | [Холбоо барих](#) | [Нэвтрэх](#) | [Захиалах](#) | [С](#)

2011 оны 8-р сарыг



ХАЙЛТ

[Нүүр](#) | [Эдийн засаг](#) | [Улс төр](#) | [Санхүү](#) | [Бизнес](#) | [Уул уурхай](#) | [Дэд бүтэц](#) | [Шинжлэх ухаан & технологи](#) | [Байгаль эх](#) | [Хүний хөгжил](#) | [Ертөнц](#) | [Байр суурь](#)

Шилдэг нийтлэл

“Мянганы үйлдвэр” мянгуужингийн үлгэр болох уу?

...Монголд өнөөдөр
нефтийн үйлдвэр босох
суурь нь ч алга.
“Монголын маргааш
дуусахгүй ээ” гэж...



2 3 4 5

Онцлох сэдэв



“Өглөгийн тангараг”

Шинэ мэдээ

- #####
- #####
#
-

**MONGOLIAN
ECONOMY** ШИН
ХЭВ

**MONGOLIAN
ECONOMY**



Үйл явдал



Редакцийн зочин

Уул уурхай ямаршуу байгаа бол, нэг тольдож үзэх үү? 2003 оноос эдүгээ ес дэх удаагаа зохион байгуулагдаж буй “Discover Mongolia” чуулга уулзалт хөрөнгө оруулагчдын дунд Монголын ашигт малтмалын салбарыг таниулах нэрийн хуудас болж чадсан билээ. “Mongolian Economy” сэтгүүл энэхүү олон улсын чуулга уулзалтын үүсгэн байгуулагчдыг редакцидаа урьсан юм. Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, “FSCO” корпорацийн гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан, “Монруд” компанийн захирал Г.Анхбаяр, эдүгээ “Behre Dolbear” компанийн эрдэс баялгийн салбарын зөвлөгч Д.Төрбат, “Ньюком” группийн Харилцаа, хамтын ажиллагааны захирал Э.Содонтогос нар манай редакцид цуглалаа. Тэд 2003 онд авахуулсан гэрэл зургаа бие биедээ дамжуулан сонирхоно. Мөн тэд арьсаар урласан нэгэн өргөмжлөлийг бидэнд сонирхуулахаар авчирахаа мартсангүй. “Discover Mongolia”-гийн зохион байгуулагчид нь хэвлэл мэдээллийн дэмжигчид болон спонсорууддаа өгдөг өргөмжлөлөө үндэсний хэв шинж агуулсан өвөрмөц шийдлээр урладаг ажээ. Тэр үеэс хойш их зүйл өөрчлөгджээ.

“Discover Mongolia” чуулга уулзалт есөн нас хүрэхдээ ямар зам туулав? Монгол дээл, жанжин малгай, эсгий цүнхтэй холбоотой санаанд оромгүй олон сонирхолтой дурсамж руу “Mongolian Economy” сэтгүүл өнгийж харлаа. Энэ бүх хөгжилтэй яриа манай эрдэс баялгийн салбарын сүүлийн есөн жилийн түүхийг сонирхолтойгоор өгүүлсэн юм.

–“Discover Mongolia”-г зохион байгуулах санаагаа анх яаж олж байсан тухайгаа ярихгүй юү?

Д.Жаргалсайхан: -Канадад PDAC гээд Монголын уул уурхайн үндэсний ассоциацитай их төстэй чиг үүрэг бүхий төрийн бус байгууллага байдаг юм. Тэднийх жил бүрийн гуравдугаар сард Торонто хотод хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг, үзэсгэлэнтэй хавсарч зохион байгуулдаг л даа. Тэгээд Монгол Улс зах зээлийн



“Discover Mongolia” өнгөт эсгийг Монголд моодонд оруулсан

харилцаанд шилжиж орсноос хойш манай холбогдох яамныханд урилга өгч, Монголын төлөөллийг оролцуулах талаас анхаарч эхэлсэн. 1993 онд тухайн үеийн Геологи, эрдэс баялгийн сайд Цогтбаатар намайг тэр уулзалтад авч явсан юм.

Н.Алгаа: -Жанжин малгайтай, монгол дээлтэй хоёр хүний сураг л гарч байлаа ш дээ (инээв).

Д.Жаргалсайхан: -Тэр үеийн зураг надад байдаг юм, хүсвэл сонирхож болно шүү. Сайд бид хоёр Торонтод цугласан хөрөнгө оруулагчдын анхаарлыг Монгол руугаа хандуулах гэсэндээ үндэсний иж бүрэн хувцастай явсан. Тэгсэн чинь хуралд оролцогчид нь Монголын уул уурхай гэхээсээ илүү бидний хувцаслалтыг сонирхоод, хөөргөө гаргаж ирээд тамхилсан чинь нөгөөдүүл чинь бүр жигтэйхэн (инээв).

Н.Алгаа: -Ш.Отгонбилэг УИХ-ын гишүүн байх үедээ эрдэс баялгийн салбарт байнгын ажиллагаатай төрийн бус байгууллага хэрэгтэй гэж үзээд уул уурхайн ассоциацийг санаачлан байгуулсан л даа. Өөрөө ерөнхийлөгч нь болж, намайг захирлаар нь сонгосон юм.

Д.Жаргалсайхан: - 2001 онд Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгчөөр би сонгогдчихов оо. Алгаа бид хоёр нягтлантайгаа гурвуулаа жижгэвтэр ганц өрөөнд л ассоциацийг

хүчирхэг байгууллага болгоно гэсэн зорилготойгоор ажлаа эхэлж байлаа. 1997 оны Ашигт малтмалын тухай хууль батлагдсанаар гадаадын мөнгөтэй хүмүүсийг Монгол руу оруулах нөхцөл бүрдсэн шүү дээ. Гэвч зөвхөн хууль гаргаад хөрөнгө оруулагчид ирдэг юм биш байна. Тэд чинь ирээд бие биетэйгээ уулздаг, мэдээлэл авдаг, төр засгийнхны санаа бодлыг сонсдог байх хэрэгтэй юм байна гэдгийг ойлгосон. Тэгээд л нөгөө Торонтод болдог PDAC-гийнх шиг хурлыг Монголд хийгээд үзвэл яасан юм бэ гэсэн санаа орж ирсэн. Анх 2002 онд “Discover Mongolia” гэдэг нэр байхгүй, ассоциаци дангаараа “UB Palace”-д уул уурхайн үзэсгэлэн, чуулга уулзалт зохион байгууллаа.

Н.Алгаа: -250 сандал засуулчихаад, шөнө нь нойргүй хонолоо. Хүн ирэх болов уу, ирэхгүй болов уу, мэдэхгүй байхгүй юү (инээв). Анх удаагаа л олон зуун хүн оролцох хурал зохион байгуулж байгаа нь тэр. Туршлага байхгүй, эргэж харах болгонд нэг юм дутуу юм шиг санагдаад.

-Тэгээд хүмүүс ирсэн үү? Гаднынхан ер нь хэр сонирхож байсан бэ?

Н.Алгаа: -250 сандал дүүрч, санаа амарсан даа.

Д.Жаргалсайхан: -Тэр бидэнд их урам өгсөн. Гэхдээ хувийн компаниудын дэмжлэг, тодорхой санхүүжилтгүйгээр ▶



том захиалга авч байгаадаа бөөн баяр болсон эмэгтэйчүүд маань тооцоогоо жаахан буруу хийчихжээ. Нөхдүүд гэнэдээд бага үнэ хэлчихсэн чинь дараа нь ашиг багатай болж таарахгүй юу. Уг нь тэр олон цүнхийг хугацаандаа амжиж хийхийн тулд гэртээ хүртэл гараа цэврүүттэл ажилласан. Тиймээс бид тэднийг “Discover Mongolia”-гийн хүлээн авалтадаа урьж, ашгийг нь нэмж өгөх замаар дэмжиж байлаа.

-Тэгээд эсгий цүнх хөрөнгө оруулагчдад таалагдаж байв уу?

-Таалагдалгүй яах вэ, нэхнэ шүү дээ, нөгөө цүнхээ гээд.

Н.Алгаа: -Гадаадын зочид амьдралдаа тийм цүнх хараагүй байх (инээв). Тиймээс их баяртай байсан. Ганц дутагдалтай тал нь бариулгүй юм болохоор сугавчлах хэрэг гарна, гэтэл эсгийний үс хувцсанд нь наалдаад байсан.

Д.Жаргалсайхан: -Бид жил бүр цүнхнийхээ дизайныг сайжруулж ирсэн. Гол нь монгол хэв шинжийг агуулсан байх учиртай.

Э.Содонтогос: -“Discover Mongolia” өнгөт эсгийг Монголд модонд оруулсан байх аа. 2005 онд цагаан эсгий дээр логогоо өнгөөр хийж, инноваци бий болгосон. Тэрний дараахан Улаанбаатарт өнгөт эсгийний дэлгүүрүүд үүдээ нээсэн ш дээ.

-Хурлын мөнгийг аль болох Монголдоо шингээх талаас анхаардаг гэсэн чинь их таалагдлаа. Тэгвэл уул уурхайн салбарт орж ирж буй энэ их хөрөнгө оруулалтыг аль болох дотооддоо шингээж авч үлдэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ?

Д.Жаргалсайхан: -Уул уурхайн салбарт орж байгаа нэг доллар бусад салбарт дөрвөн долларын хэрэгцээг бий болгодог гэсэн олон улсын жишиг байдаг. Оюутолгойг дагаад цахилгаан, тээвэр, эрүүл мэнд, банкны үйлчилгээ хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Өнөөдөр эдийн засаг огцом өслөө, барилгын салбар эрчимжлээ л гээд байна. Гэхдээ энэ бүхэн хуурай тоо юм. Тэр орон сууцнуудын хэдийг нь хэн худалдаж аваад байгаа тухай судалгаа алга. Зүгээр таамаг бол бий. Орон сууцны эрэлт хэрэгцээний 50 гаруй хувь нь уул уурхайн салбараас гарч ирж байгаа гэж байна.

Тэгэхээр Оюутолгой компанийн 34 хувийг төр эзэмших үү, 51 хувийг нь авах уу, эсвэл бүгд Фрийдландыг хөөж гаргах уу гэдэгт асуудлын гол нь байгаа юм биш. Тэр Оюутолгойн төсөлд хөрөнгө оруулалт болж ирж байгаа 100 төгрөгнөөс аль болох ихийг нь монголчууд авах гэж хичээхэд л байгаа юм шүү дээ.

Н.Алгаа: -Үүний тулд мэдээж ▶

▶ томоохон хурал хийхэд хэцүү гэдгийг бас ойлгосон. Тэгээд 2003 онд нэлээд хэдэн компанид мөнгө төгрөгөөр туслаач гэж санал тавьсны дагуу “Майн инфо”, “Монруд” хамгийн түрүүнд гараа сунгасан. Тэр үед Төрбат “Майн инфо”-гийн ерөнхий менежер, Анхаа “Монруд”-ын ерөнхийлөгч байлаа. Тус бүр таван мянган доллар гаргая, орлого олбол тэндээсээ нөхнө, олохгүй байлаа ч бид өөрсдөө шатая гэсэн. Тэгээд зохион байгуулах хороо байгуулагдаад, нэртэй, логотой болоод, “Discover Mongolia” мэндэлсэн түүхтэй. Тухайн үеийн таван мянган долларыг ч их бүдүүн зүрхтэй хүмүүс л гаргадаг байлаа шүү дээ.

-Гадаад сурталчилгаагаа яаж хийдэг байсан бэ. Тэр үед Монголын уул уурхайн салбар дэлхийд танигдаагүй байсан болохоор бэрхшээл мэдээж гарч л байсан биз дээ?

Н.Алгаа: -10 мянган долларын долоон мянга нь Хойд Америктаа хамгийн нөлөө бүхий “Northern Miner” гээд уул уурхайн сонинд реклам гаргахад зарцуулагдсан сайн санаж байна. Сэтгүүлүүдэд бол реклам гаргана гэж саналтгүй. Үнийг нь дийлэхгүй байлаа. Гэхдээ гадаадад сурталчилгаагаа явуулаад эхлэхээр бүртгэлийн хураамж, спонсороос санхүүжилт орж ирдэг л юм билээ.

Э.Содонтогос: -Гадаад руу чиглэсэн PR хийдэг байсны хүчинд Английн “Mining Journal”, Канадын “Northern Miner”, Австралийн “Asia Miner” зэрэг хэвлэлийг Монголд анх татаж оруулж ирсэн юм шүү дээ. Бид хэдэн жилийн турш Австрали, Канад зэрэг оронд болдог уул уурхайн хурлуудад сурталчилгаа, танилцуулгаа хүргэдэг

байлаа.

-Түрүүн ярьж байсан 10 мянган доллар юу болсон бэ. Шатсан уу?

Д.Жаргалсайхан: -Шатаагүй ээ, зардлаа нөхсөн.

Н.Алгаа: -Анхны “Discover Mongolia”-д дэлхийн төмөрлөгийн үйлдвэрлэлээр хоёрдугаарт ордог “Vale” компаниас нэг нөхөр ганцаараа ирдэг юм байна. Бид ч тэр хүнтэй сайн уулзаж, ярилцалгүй яах вэ. Тэгсэн чинь нутагтаа очингуутаа удирдах зөвлөлийн хүмүүстээ Монголын талаар танилцуулсан байгаа юм. Тэгээд л Улаанбаатарт төлөөлөгчийн газраа нээчихсэн. Бидний хувьд энэ их том амжилт байлаа.

-“Discover Mongolia”-г зохион байгуулах явцад дурсамжтай сайхан зүйлс мэдээж олон л байсан биз дээ?

Д.Жаргалсайхан: -Анхны чуулга уулзалтаар спонсорууддаа өгсөн эсгий цүнх одоо ч бидэнд бий. Ер нь бид хурлаас орж ирэх мөнгийг ямар нэг байдлаар Монголдоо л шингээхийг хичээдэг байсан. Хэрвээ та нар анзаардаг бол манайхан томоохон хурлын үеэр нэг хар цүнхэнд материалуудаа хийгээд тараадаг шүү дээ. Тэр нь Эрээнээс ч авсан юм уу, бүү мэд. Харин бидний цүнх бол их өвөрмөц, үндэсний хэв шинж агуулсан байдаг юм.

Д.Төрбат: -Тэр чинь их сонин түүх л дээ. Дарханы өрх толгойлсон, эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг Норвегийн төслөөр сургалтад хамруулаад, эсгийгээр яаж бүтээгдэхүүн хийхийг зааж өгөөд, хоршоо болгон бүртгүүлээд байсан юм. Тэгээд тэр эмэгтэйчүүд дөнгөж ажлаа эхэлж байхад нь бид бариад авсан. Тэгсэн чинь анх удаа

Төр саад л болохгүй бол бидэнд буян үйлдэж байгаа хэрэг

▶ ханган нийлүүлэлт чухал. Өнөөдөр дуулдаж байгаа таатай мэдээлэл гэвэл монгол компаниуд уул уурхайн томоохон төслүүдэд бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх тал дээр гаднынхантай өрсөлдөж эхлээд байна. Гэвч дэлхийн хэмжээний томоохон төсөл мэдээж хамгийн сайн стандартын шаардлага тавьдаг. Монголчууд өөрсдөө тэр хэмжээнд өсөж очих ёстой. Үүнийгээ мэдэрч эхэлсэн нь сайн хэрэг.

-Гэхдээ тэр стандартад хүрэхийн тулд юу хийх шаардлагатай вэ? Монгол компаниуд яахаа мэдэхгүй, магадгүй зөвлөгөө зааварчилгаа их хэрэгтэй байгаа байх.

Д.Жаргалсайхан: -Нэг тендерт ялагдана, хоёр дахид нь дахиад ялагдана, гурав дахь удаагаа ялдаг болно. Тэр үйл явц л одоо явж байна. Гоё мэдээ гэвэл ялагдахын зовлонг олон монгол компани амссан. Тэр нь хамгийн сайн сургамж, яагаад ялагдчихав аа гэдгээ олон компани мэддэг боллоо. Түүнээс биш, Данко зүрхээ гаргаад, төөрсөн ард түмэнд замыг нь зааж өгдөг шиг хэн нэгэн гарч ирээд, мундаг зөвлөгөө зааварчилгаа өгнө гэж юу байх вэ. Идсэн эрүү хувхайрч, идүүлсэн бут ургадаг гэж гоё үг байдаг шүү дээ. Монгол компаниуд одоо идүүлж байна, гэхдээ тэр зовлон дээрээ сурч байгаа юм.

-“Discover Mongolia”-г төр, засгийн зүгээс яаж дэмжиж байв?

Д.Жаргалсайхан: -Би тэр үед Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын дарга байсан учраас чуулга уулзалтад төрийн төлөөллийг идэвхтэй оролцуулах тал дээр анхаарахад арай хөнгөн байлаа. Гэхдээ төр, засаг биднийг дэмжиж байсан гэхэд хэцүү. Хамгийн эмгэнэлтэй жишээ гэвэл “Буян”-гийн Б.Жаргалсайхан салбарын сайд байх жилийн хурал юм. “Discover Mongolia”-д ирээд, хөрөнгө оруулагч нарыг загначихаад явчихаж байгаа юм чинь.

Д.Төрбат: -Төр ер нь саад л болохгүй бол бидэнд буян үйлдэж байгаа хэрэг шүү дээ.

Н.Алгаа: -Бас нэг жишээ байна. 2008 онд бил үү дээ, “Discover Mongolia” чуулганы хоёр дахь өдөр Төрийн ордонд хөрөнгө оруулагчдын хурал зохион байгуулсан. Тэгээд төрийн байгууллагын нэрээр бидний мөнгөөр авчирсан бүх хүнийг Төрийн ордонд аваачихсан ш дээ.

-Өнөөдөр Монголын уул уурхай дэлхийд моодонд ороод, “Discover Mongolia”-д оролцох хөрөнгө оруулагчдын сонирхол ч эрс нэмэгдээд байна. Харин анх байдал ямар байсан бэ? Эхний чуулга уулзалтыг хөрөнгө оруулагчид яаж хүлээж авч, гол нь гадаадын хэвлэлд ямаршуу мэдээлэл гарч байв?

Д.Төрбат: -“Reuters”, “Bloomberg” л товч мэдээлэл гаргасан. Өөрөөр бол гараагүй ээ. Уул уурхайн хурал хаа сайгүй зохион байгуулагддаг болохоор гаднын хэвлэлүүд нэг их онцлоод байгаагүй.

Н.Алгаа: -Гэхдээ “Буян”-гийн Б.Жаргалсайхан хөрөнгө оруулагчдад “Бид нар та нараар дутахгүй, Монголоос явж болно” гэж хэлсний дараа байдал шал өөр байсан. Өдөр нь “Discover Mongolia”-гийн Засгийн газрын цагаар тэрийгээ хэлэхэд, оройны хүлээн авалтын үеэр “Bloomberg” аль хэдийнэ цацчихсан байсан. Тиймэрхүү мэдээлэл л их хурдан тардаг юм билээ.

-Анхандаа мэдээлэл нэг их гараагүй гээд ярилаа шүү

дээ. Одоо бол дэлхийн томоохон агентлагууд бүгд л “Discover Mongolia”-г сурвалжлахаар зорьж ирдэг болж. Ийм цаг ирнэ гэж есөн жилийн өмнө бодож байсан уу?

Г.Анхбаяр: -Яг үнэнийг хэлэхэд би лав бодож байгаагүй.

Э.Содонтөгос: -Би бодож байсан.

Д.Төрбат: -Би бүр мэдэж байсан (бүгд инээлдэв).

-Тэгвэл Алгаа захирал зөгнөж байсан гээч...

Н.Алгаа: -Үгүй ээ, мөрөөдөж л байсан даа.

Д.Жаргалсайхан: -Гэхдээ хоёр дахь уулзалтын үеэр цар хүрээ нь өргөн болоод, гаднынхан нэлээд их сонирхож ирсэн шүү дээ.

Г.Анхбаяр: -Би энд нэг л зүйлийг онцолмоор байна.



Өнөөдөр хүн бүр уул уурхай ярьдаг болж. 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийг болсон, болоогүй гээд л янз бүрээр тайлбарлаад байна. Уул уурхай өргөжин тэллээ, хөгжлөө гэж байна. Гэхдээ тэр үед яг арьс махаараа гаднын хөрөнгө оруулагчдыг татах гээд явж байсан хүмүүс энэ бүхнийг мэднэ үү гэхээс биш, өнөөгийн улсууд мэдэрч чадахгүй. Яагаад гэвэл анх биднийг гадаад яваад хөрөнгө оруулалт татъя гэхээр Монгол гэж ямар орон хаана байдгийг ч мэддэггүй байлаа шүү дээ. Тийм үед, тийм хууль хийсэн тулдаа өнөөдөр гаднынхан Монголд их хэмжээгээр хөрөнгө оруулж байгаа юм. Одоо бараг л гаднынхан өөрсдөө ороод ирчихсэн юм шиг яриад байдаг, үнэндээ бодлогын чанартай тэд нарыг оруулж ирсэн.

-Сүүлийн хэдхэн жилийн хугацаанд манай уул уурхай ихээхэн өргөжөөд байна. Оюутолгой, Тавантолгойн уурхай ашиглалтад орох гэж байгаагаас гадна үндэсний компаниуд олон улсын хөрөнгийн зах зээлээс мөнгө босгож эхэллээ. Энэ бүхнийг дагаад “Discover Mongolia” яаж өөрчлөгдөж байна вэ?

Н.Алгаа: - Бид жил бүр нөхцөл байдал ямар байна вэ гэдгийг ажиглаж, түүнтэйгээ уялдуулан хурлынхаа чигийг гаргадаг. Анхандаа “Discover Mongolia” хайгуулд ихээхэн анхаарал төвлөрүүлдэг байлаа. Одоо жинхэнэ хөгжлийн ▶

төслүүдийг онцгойлж байна. Өөрөөр хэлбэл, Тавантолгой, Оюутолгой, тэдгээрийг дагасан ханган нийлүүлэлтэд анхаарлаа хандуулаад ирж байна. Чанарын өөрчлөлт мэдээж гарч байгаа. Бид энэ жилээс “Хамтдаа хөгжье” гэсэн уриатай болж, зөвхөн уул уурхайгаас гадна, дэд бүтэцтэйгээ, орон нутагтайгаа хамт хөгжих чиглэлд илтгэлүүдээ ч түлхүү оруулах гэж байгаа юм.

Э.Содонтогос: -Ер нь “Discover Mongolia”-г зүгээр нэг арга хэмжээ гэж бодохоос илүү Монголын уул уурхайн салбарт болж байгаа үйл явдал, эволюци гэж ойлгох хэрэгтэй болов уу. Эхлээд бид Монголд ийм их баялаг байна шүү, ирээд Монголыг нээцгээ гэж байлаа. Харин одоо бүгдээрээ Монголыг хамтдаа, хариуцлагатайгаар хөгжүүлэе гэж уриалж байна. Түүнчлэн Mining ABC буюу уул уурхайн цагаан толгойн сургалт явуулахаас гадна нарийвчилсан чиглэлээр, тухайлбал усны хайгуул зэрэг сэдвээр тусгай семинар зохион байгуулах жишээтэй. Ерөнхийдөө “Discover Mongolia”-г хөгжлийн, боловсролын, танин мэдэхүйн цогц үйл явдал гэж харах хэрэгтэй болж байна.

Д.Жаргалсайхан: -Энэ жилийн гол санаа бол “Уул уурхайтай хамтдаа хөгжье” гэж байгаа юм. Уул уурхайг

Н.Алгаа: -“Даяар Монгол”, “Миний Монголын газар шороо” хөдөлгөөнийхөн уул уурхайг эсэргүүцээд жагсаж байхад нөгөө талд нь дэмжиж байгаа залуус бас жагссан. Тэгээд ямар ч асуудал гаргахгүй хоёр талд нь лоозонтой хүмүүс зогсоод л хоёр өдөр болсон доо. Ер нь их соёлтой жагсаал байсан юм даг.

-Уул уурхайг одоо ч гэсэн буруу, зөв гэж ярьж байгаа шүү дээ. Энэ тал дээр ямар бодолтой байдаг вэ?

Н.Алгаа: -Иргэний нийгэм, төр, засаг, уул уурхайн салбар ойлголцож байж л уул уурхай цааш явах нь ойлгомжтой болсон. Энэ нь уул уурхайн тулгын гурван чулуу гэж ойлгож болох юм уу даа. Уул уурхай хэрэгтэй юу, үгүй юу гэдэгтээ биш, гол нь энэ нь хариуцлагатай байх ёстой юм байна аа гэдгийг нийгэм бага багаар мэдэрч эхлээд байна. Одоо нинжа нарын асуудлыг шийдчихвэл боллоо.

Г.Анхбаяр: -Нинжа гэснээс нэг юм яримаар санагдаад байна. “Та нар ухаж байхад бид яагаад болдоггүй юм бэ” гэсэн ойлголтыг хувиараа алт олборлогчид өгсөн. Тэгээд сэтгүүлчид нэг хэсэг нинжа нарыг нэлээд өмөөрч бичиж байлаа. Бид геологийг таван жил сурдаг. Тэр хугацаанд байгаль хамгаалах талыг багагүй заадаг юм. Тухайлбал,



цохиж унагаачихаад цааш явдаг биш, түүн дээрээ дөрөөлөөд хөгжье. Түүнчлэн Монголд хэчнээн уул уурхай яриад дэд бүтэцгүй бол хэцүү учраас энэ сэдвийг ч голлож байгаа. Мэдээж хариуцлагатай уул уурхайн сэдвээр тусгай хуралдаан хийж байгаа юм. Энэ бүхнээс “Discover Mongolia” нийгмийн, салбарын өөрчлөлттэй зохицоод явж байгааг харж болно. Нийгэм их хурдан өөрчлөгдөж байна шүү дээ.

-Монголыг хамтдаа хөгжүүлэе гэсэн уриатай болж байгааг та бүхэн онцоллоо. Өнгөрсөн онд “Discover Mongolia” гэдэг нэрээ “Develop Mongolia” болгох уу гэсэн санал асуулга явуулж байсан даа. Тэрний үр дүн ямар байсан бэ? Ер нь цаашдаа нэрээ өөрчлөх төлөвлөгөө бий юу?

-Үгүй ээ, солиод хэрэггүй гэсэн. “Discover Mongolia” гэдэг нэр маань өөрөө брэнд болчихсон учраас сольж хэрэггүй юм билээ.

Д.Жаргалсайхан: -Өнгөрсөн хугацаанд бүх юм сайхан байсан уу гэвэл үгүй. Алдаж оносон зүйл байлгүй яах вэ. 2004-2005 онд Монголын уул уурхайг тойрсон хийрхэл явлаа шүү дээ. Монголын нийгмийн дайрч өнгөрч байгаа бүх бэрхшээлийг “Discover Mongolia” ч дайрч өнгөрч байгаа юм. Тэр байтугай, 2005 онд бил үү дээ, хурлын гадаа хэсэг залуу ирж жагссан. Уул уурхай хэрэггүй гээд.

би дадлага хийж явж байхдаа сорьц авахын тулд хаднаас чулуу буталж, байгаад багшдаа загнуулсан. “Чи яагаад зүв зүгээр байж байгаа зүйлийг хагалж бутаргаж байгаа юм бэ? Хэрвээ чи сайн геологич бол хажуу талд нь уначихсан байна ш дээ, тэрийг л аваад үзээч” гэж байсан. Ингэж сургаж байдаг юм. Гэтэл нинжа нар яадаг билээ? Мэргэжлийн бус тэр хүмүүст байгаль хамгаалах тал дээр ямар ч ухагдахуун байхгүй. Зөвхөн ашгийн төлөө явдаг. Тиймээс нийгэмд энэ бүхнийг зөвөөр ойлгох хэрэгтэй байна.

-Мэргэжлийн хүмүүс байгаль хамгаалах тал дээр илүү байдаг гэж та хэлэх гээд байна уу? Тэгвэл яагаад өнөөг хүртэл нөхөн сэргээлт Монголд ийм дорой байж ирсэн юм бол?

Г.Анхбаяр: -Миний бодлоор энэ бүхэн хөрөнгө мөнгөтэй л холбоотой. 1997-1998 онд бид бүгдээрээ ядуу байлаа шүү дээ. Уул уурхай гэхэд ашиг тун багатай. Одоо бол шал өөр боллоо, ашигт малтмал үнэд орлоо. Ашиг их болохоор нөхөн сэргээлтээ хийж эхэлнэ шүү дээ.

Д.Жаргалсайхан: -Өмнө нь Байгаль орчны багц хуульд уул уурхайн ашиглалтын лиценз эзэмшигч нь ашиглалт явуулаад дууссаныхаа дараа тухайн орчныхоо унаган төрхийг сэргээгээд, орон нутагт хүлээлгэж өгнө гэж заасан байсан. Тэгвэл ямар төрхийг нь “унага” гэдэг билээ? Энэ нь манай ▶

► нийгэм, төр, засгаас гаргасан цоорхой байхгүй юу. Нөхөн сэргээн гэж яг юуг хэлэх вэ гэсэн тайлбар, тодорхойлолт нь байхгүй байсан. 1998 оноос энэ бүхэн болохгүй байна гэдэг нь мэдрэгдээд, 1999 онд л нөхөн сэргээлтийн анхны стандарт, тодорхойлолт гарч ирсэн юм.

Н.Алгаа: -Одоо бол олон жижиг уурхай олон газар байна шүү дээ. Гэтэл төрийн байгууллагууд тэр бүхэнд хүрч ажиллаж чадахгүй байна. Орон нутагт тэрийг нь хянадаг байцаагч нар байдаг ч ихэнхдээ нөхөн сэргээлт гэж юу болохыг ч мэдэхгүй хүмүүс бий. Нэг дунд сургуулийн багшийг ч юм уу томилчихдог юм билээ. Тэгэхээр нь уул уурхайн компанийн нөхдүүд нэг цаас гаргаж ирж танилцуулаад л буцаачихаж байх жишээтэй. Товчхондоо, төр хууль гаргачихаад, хяналтаа тавьж чадахгүй байна. Заавал сум бүр нэг байгаль орчны байцаагчтай байх албагүй шүү дээ, харин Заамарт бол гурав байх ёстой. Тэгээд тэр хүмүүсээ мэргэшүүлж сургаад явдаг механизм хэрэгтэй байна. Сум бүрт нэг хянагч байгаа нь үр дүнгээ өгөхгүй байгааг ийм замаар засаж янзлахын оронд болохгүй байна, зогсоо гээд байдаг. Одоо бол хүмүүс энэ бүхнийг ойлгоод, хариуцлагатай уул уурхайд анхаараад эхэлсэн нь сайн хэрэг.

Г.Анхбаяр: -2004 он шиг санагдаж байна. Тэр үед Заамарын нөхөн сэргээлтийн асуудал яригдаж байсан. Бид алт, зэс орсон нэлээд үнэтэй чулуугаар "Discover Mongolia"-гийн эмблем бүхий дурсгалын зүйл хийж, дуудлага худалдаанд оруулсан юм. Гэхдээ худалдаж авах хүн олдохгүй байснаас өөрсдөө аваад, мөнгийг нь Заамарын байгаль хамгаалах санд өгч байлаа. Одоо бодоод байх нь ээ энэ нь нөхөн сэргээлтийн талд хийсэн нэг алхам байсан юм шиг ээ.

-Таван жилийн дараа "Discover Mongolia"-гийн цар хүрээ ямар болсон байх бол.

Н.Алгаа: -"Discover Mongolia"-г Азийн томоохон уулзалт болгох мөрөөдөлтэй байдаг.

Д.Жаргалсайхан: -Мөрөөдөл дуусчихвал амьдрал дуусчихна шүү дээ. Бидний 2002 онд халуун сэтгэлээрээ эхлүүлсэн ажил үр дүнгээ өглөө, гэхдээ одоо бид зайгаа тавьж өгөх ёстой. Яагаад гэвэл бидний цаг үе өнгөрч байна, нийгмээс тавигддаг шаардлага ч өндөр болж байна. Миний зүгээс "Discover Mongolia"-гийн өдөр тутмын ажилд оролцмооргүй байгаа, тиймээс ч одоо дандаа залуучууд зохион байгуулж байгаа шүү дээ. Канадын PDAC шиг болчихоосой, хэрэгтэй улсууд нь санаа оноогоо солилцдог байнгын индэр болоосой л гэж зорьдог.

Э.Содонтогос: -Гэхдээ бид зохион байгуулах хорооны гишүүд хэвээрээ байгаа. Залуучуудаа чиглүүлээд л, санаа бодлоо хэлж байгаа гэсэн үг. Гэхдээ хамаг юманд нь оролцдог байхгүй. Эрх чөлөөг нь өгч байгаа.

-Сүүлийн хэдэн жилийн "Discover Mongolia" чанараа алдла гэж яриад байгаа. Ялангуяа өнгөрсөн онд төр засгийнхан ч үл тоомсорлоод ирээгүй, нэлээд сул боллоо гэсэн шүүмжлэл гарч байсан. Та бүхний халааг авч, хурлыг зохион байгуулж буй залуусынхаа ажлыг хэрхэн үнэлж, дүгнэдэг вэ?

Г.Анхбаяр: -Манай хурлын онцлог бизнес талдаа шүү дээ. Төр, засгийн байгууллагууд нэг их оролцдоггүй. Нэг талд нь хөрөнгө оруулагч, нөгөө талд нь үйлдвэрлэгч хоёрыг л уулзуулах нь хурлын гол зорилго юм. Чи надад хөрөнгө оруулах уу, би чамд бүтээгдэхүүн гаргаж өгөх үү гэдгээ "Discover Mongolia"-гийн үеэр ярьж байгаа хэрэг. Харин төр, засгийн төлөөллийг яагаад оролцуулаад байдаг юм гэхээр тэдний л буруу үйл ажиллагаатай холбоотой. Манай эрх зүйн орчин тогтвортой байж чаддаггүй. 2-3 жил болоод л хуулиа өөрчилдөг, нэг шинэ журам гаргачихдаг. Харин хөрөнгө оруулагчдын хувьд хууль эрх зүйн орчин тогтвортой байсан цагт урт хугацааны бизнес төлөвлөгөөгөө гаргаж, тооцоогоо

хийнэ шүү дээ. Тийм болохоор гаднынхан Монголын хууль эрх зүйн орчин тогтвортой байх юм уу, үгүй юу гэдгийг сайд дарга нараас асуухыг хүсдэг байхгүй юу.

Д.Жаргалсайхан: -Төр, засгийн төлөөлөл хуралд оролцогчдын асуултуудад хариулахад их хэцүү шүү дээ. Тухайлбал, энэ жил гэхэд нөгөө "Урт нэртэй" хуулиа яах юм бэ, хайгуулын лицензээ яах юм бэ гээд асуух нь ойлгомжтой. Тэгээд Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын төлөөлөл ирлээ гэхэд юу гэж хариулах юм бэ? Ямар нэгэн хариулт хэллээ, амлалт өглөө гэхэд дараа нь биелүүлж чаддаггүй. Тэрнээсээ айгаад ирэхээ байчихаад байгаа юм.

Н.Алгаа: -Ер нь сайд, дарга нар ирж үү, илтгэлийг олон хүн сууж сонсож байна уу гэдгээр хурлын цар хүрээг дүгнэх буруу юм шиг байгаа юм. Өнгөрсөн жилийн хурлын үеэр би зориуд "цай, кофе" хавьцаа байнга байсан. Тэгээд хуралд оролцогчдод бие биетэйгээ уулзаж, сонирхсон сэдвээрээ чөлөөтэй ярилцах цаг түлхүү гаргаж өгөх хэрэгтэй юм байна гэдгийг анзаарсан.

Г.Анхбаяр: -Өмнө нь бид гаднаас илтгэгч нарыг урьж авчирч чаддаггүй байлаа. Гурван жилийн өмнөөс илтгэгч авчирч байна, энэ жил бүр олон, зарим нь өөрсдөө саналаараа ирж байгаа. Тэр байтугай, Лондоны хөрөнгийн биржийнхэн "Discover Mongolia"-г жижигрүүлсэн хэлбэрээр Лондонд хийе гэсэн санал тавьсан. Энэ бол маш сайхан, өргөжиж байгаагийн нэг хэлбэр. Цаашид илүү өргөжиж хөгжөөсэй гэж бодож байна.

-Манай уул уурхайн салбарын эрчимтэй өсөлт юу авчрах бол? Төр, засаг эрдэс баялгийн орлогоо зөв зарцуулж, иргэдийнхээ амьдрал, амьжиргааг сайжруулж чадах болов уу?

Н.Алгаа: -Би бол чадах байх аа л гэж бодоод байгаа. Удаан явцтай байгаа л даа. Гэхдээ өөдрөг байгаа.

Д.Жаргалсайхан: -Би ч гэсэн энэ тал дээр их өөдрөг ханддаг л даа. Яагаад гэвэл гаднаас Монголын өндөр боловсролтой олон залуу буцаж ирж байна. Нөгөө талаас манай хүн амын ихэнх нь залуучууд. Залуучууд түрэн гарч ирж байна. Тэдний сэтгэхүйн өөрчлөлтийг бид хэчнээн эсэргүүцээд яах билээ.

Д.Төрбат: -Гэм нь тэр нөхдүүд ирээд төрийн байгууллагад орох гээд зүтгэж байгаа явдал. Тэр бол жинхэнэ аюулын дохио. Америкт сурч, амьдарч ирчихээд энд яаманд ажилд орох гээд дайраад байгаа нь их буруу.

Э.Содонтогос: -Үүнтэй холбоотой хэлэхэд миний хувьд макро эдийн засгийн менежмент болоод төрийн албаны өөрчлөлт чухал гэж боддог. Хувийн хэвшлийнхэн их хурдтай давшиж явахад түүнийг гүйцэж чадах түвшинд манай төрийн албаныхан очоосой гэж бодож байгаа. Ерөнхийдөө "Discover Mongolia"-г хараад манай төр, засаг уул уурхайн чиг хандлагыг ойлгодог болчихоосой гэж бодож байна. "Fashion TV"-гийн арваннэгдүгээр сарын сезоныг үзээд, энэ жил Нью-Йоркт хүүхнүүд ингэж гангарах нь дээ гэж боддог шиг "Discover Mongolia"-г хараад, ирэх жил бид энэ тал дээр илүү анхаарах ёстой юм байна шүү гэж боддог болоосой.

Гадаадад сурталчилгаа санасан хэмжээгээрээ явуулчих ч мөнгөгүй эхэлсэн "Discover Mongolia" өнөөдөр Монголын уул уурхайн салбарын нэрийн хуудас болоод байгаа билээ. Монголыг сонирхсон хөрөнгө оруулагчид эндээс л хэрэгтэй мэдээллээ авдаг болсон үе иржээ.

"Би л лав их бахархдаг аа. Уран бүтээлч хүний хувьд нэг тийм том бүтээл шиг" хэмээн Э.Содонтогос хэлснээр бидний ярилцлага өндөрлөсөн юм. Олон улсын хэмжээний энэ томоохон чуулга уулзалтыг санаачилж, бий болгосон таван "уран бүтээлч" маань өнөөдөр бүгд толгойгоор давсан их ажилтай ч бидний урилгыг авч, хүрэлцэн ирсэнд талархлаа илэрхийлье. ■



Ухаа худаг дахь ДЦС жилдээ 72.2 сая кВт/цаг эрчим хүч үйлдвэрлэж, 73600 тн нүүрс хэрэглэдэг

Технологи

Монгол инженерүүдийн дэлхийн энэтэй “бүтээл”

Ч.Зоёноо

Усны нөөц улам багасаж байгаа өнөө үед “Энержи Ресурс” компани Өмнөговь аймгийн Ухаа худагт дулааны цахилгаан станц / ДЦС/ бүтээн босголоо. Манай сэтгүүл энэ удаагийн “Технологи” буландаа уг станцын байгальд ээлтэй дэвшилт технологийг онцолж байна. Энэ нь монгол инженерүүдийн анх удаа бие даан цогцоор нь, технологийн өндөр түвшинд барьсан хамгийн анхны ДЦС юм.

“Энержи ресурс” ХХК-ийн захиалгаар MCS-ийн инженер, мэргэжилтнүүд бүтээн босгожээ. 2009 оны наймдугаар сард шаваа тавьж, жил хүрэхгүйн хугацаанд ашиглалтад орсон уг станц нь байгальд сөрөг нөлөө багатай төдийгүй дэлхийн жишигт нийцэж чаджээ. Тус станц хуурай хөргөлтийн систем ашигладаг, хөргөлтийн ус шаарддаггүй. Тийм учраас бусад станцаас найм дахин бага ус зарцуулдаг аж. Мөн турбинаас гарч байгаа уурыг шууд агаараар хөргөх, үнсийг хуурайгаар зайлуулах зэргээр усны хэрэглээг багасгадаг гэнэ. Түүнчлэн цагт 35 тонн/цаг уур үйлдвэрлэх гурван зуухтай. Тус бүр нь 6 МВт цахилгаан энерги үйлдвэрлэх гурван турбин-генератортой, нийт 18 МВт цахилгаан энерги үйлдвэрлэх хүчин чадалтай аж. Олон улсад хүчин чадлын хувьд жижигт тооцогдох боловч, Монгол

Улсын хувьд дунджаар 4-5 аймгийн төвийг цахилгаан эрчим хүчээр хангах хэмжээний хүчин чадалтай ажээ. Тухайн ДЦС нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн техник технологиор тоноглогдсон байна. Тухайлбал,

- Зуухны хувьд олон улсад хэрэглэгдэж, шалгарсан “CFB” технологитой.

- Франц улсын GEA компанийн агаарын хөргөлттэй төхөөрөмжөөр тоноглогдсон.

- Ус боловсруулах систем нь АНУ-ын технологи, тоног төхөөрөмжтэй.

- Үндсэн цахилгааны систем нь ХБНГУ-ын “ABB”, “Siemens” фирмийн технологи, төхөөрөмж гэх мэт.

Төвийн бүсийн эрчим хүчний системд холбогдоогүй. Уг дулааны станц хүчин чадлын хувьд 85 хувьтай ажиллаж байна. Одоогоор жилдээ 72.2 сая кВт/цаг эрчим хүч үйлдвэрлэж 73600 тн нүүрс хэрэглэж байгаа аж. Станцын зуух нь нүүрсийг нам температурт шатаадаг бөгөөд дутуу шатсан нүүрсээ шохойн чулуугаар “хачирлаж” дахин ашигладаг. Ингэснээр үнсэнд агуулагдах хорт бодисын хэмжээ маш бага болдог байна. Мөн утааг цахилгаан шүүлтүүрээр дамжуулан цэвэрлэдэг бөгөөд энэ шүүлтүүр нь утаанд байх үнслэгийн хэмжээг 99.6 хувиар бууруулдаг тул байгаль орчинд хаягдах хортой бодисууд багасч /CO₂,

NO_x, SO₂, тоос/-ыг дэлхийн стандарт хэмжээнд барьж чаддаг ажээ. ДЦС-ын баталгаат ажиллах хугацаа 30 жил бөгөөд гурван жил тутамд урсгал засвар хийж байхаар болжээ.

ДЦС-ын бүтээн босголтын үед тоног төхөөрөмж оруулж ирэхээс эхлээд байгаль цаг уурын хүнд нөхцөлөөс хамаарч хүндрэлтэй асуудал олон гарч байжээ. Энэ талаар төслийн ажил хариуцсан менежер З.Түмэннасан “Хэдийгээр ДЦС барих явцад туршлага дутаж алдсан оносон зүйл бий ч ийм богино хугацаанд том бүтээн байгуулалт хийж чадсандаа сэтгэл өндөр байна. Барилга угсралтын ажил, зураг төсөл боловсруулах ажилтай зэрэгцэн хийгдэж байсан нь төсөв болон бусад төлөвлөлтийг хийхэд хүндрэл учруулж байсан. Гэхдээ бид чадсан” гээд инээв. Тэд уг ажлыг гүйцэтгэхийн тулд залуу ажилчдын баг бүрдүүлсэн нь богино хугацаанд ашиглалтад өгөхөд нөлөөлсөн байна. Эндээс монгол залуусын ямар чадварлаг болох нь тодхон харагдах биз ээ. Энэ нь томоохон ажил хийхдээ үргэлж гаднынхны гар харж суудаг цаг өнөөдөр ард хоцорсныг харуулж байх шиг. Монгол боловсон хүчин дэлхийд үнэлэгдэж байгаа жишээ олон байна. Техник, технологийн эрин зуунд бид өөрсдөө хийж, бүтээж чадахын нэгэн жишээ энэ билээ. ■

Амьдрал

Би ирээдүйд сайхан амьдарна аа!

Сайхан амьдрах туйлын хүслэн хүмүүн бүрийн сэтгэлийн нэгэн чанадад гэрэлтэж тэр л зүг сэтгэлийн жолоо, амьдралын хэмнэлээ залдаг. Дутахын гачлан, уйлахын зовлонгүй амьдрах гэдэг хүний дээдийн хүслэн билээ.

Тиймээс манай сэтгүүл энэ удаагийн “Амьдрал” буландаа өөрийн хүсэл мөрөөдөл, хөдөлмөрийн хүчээр элбэг хангалуун амьдарч байгаа мөн сайхан амьдрах итгэлтэй яваа хүмүүсийн талаар өгүүлж байна.

Туслах ажилтнаас өрмийн мастер

Э.Батжаргал гэх энэ эр өнөөдөр дэлхийд хоёрхон байдаг газрын гүний өрмийг ажиллуулдаг тухай мэдээллийг дуулгахад таатай байна. Уг өрөм нь “UDR-5000” буюу газрын гүн рүү 5000 метр хүртэл гүн өрөмдөх хүчин чадалтай ажээ. Одоогоор энэ өрөм Австрали болон Монголд тус бүр ганц байдаг аж. Тэрбээр биеийн тамрийн багш, дасгалжуулагч мэргэжилтэй ч цалин мөнгөний хүрэлцээгүй байдлаас шалтгаалж 2003 онд “Мэйжор дриллинг Монгол” ХХК-д туслах өрөмчнөөр оржээ. Өдгөө 30 насны босго давж яваа тэрбээр “Биеийн тамрийн багшийн цалин тухайн үед 43 мянган төгрөг байсан. Энэ цалингаасаа мөн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал төлнө шүү дээ. Тиймээс ёстой аманд ч үгүй хамарт ч үгүй цалин авдаг байлаа. Цалин маань амьдралд хүрэхгүй болохоор ажлынхаа хажуугаар амьжиргаагаа дээшлүүлэх бас бус зүйл мөн ч их хийсэн дээ. 2003 онд нэг найз маань санал тавьснаар “Мэйжор дриллинг Монгол” ХХК-д туслах өрөмчнөөр орсон. Тухайн үед туслах ажилтан гэхэд 300 доллараар цалинждаг байлаа. Биеийн тамрийн багш, өрөмдлөгийн туслах ажилтны цалин хоёрын хооронд тэнгэр, газар шиг ялгаатай байсан” хэмээн сонирхуулсан юм. Туслах ажилтнаас өрмийн мастер болтлоо дэвшиж чадсан Э.Батжаргал өнөөдөр Оюутолгой уурхайд газрын гүн рүү 2000-2700 метрийн гүнд өрөмдлөг хийж хаана, ямар хэмжээтэй ашигт малтмал байгааг илрүүлдэг. Тэрбээр “Би энэ мэргэжлээрээ бахархдаг. Газрын гүн рүү ямар ч нүдэн баримжаагүйгээр өрөмдлөг хийнэ гэдэг тийм ч амар ажил биш. Сүүлийн үед Монголд далд уурхайтай холбоотой мэргэжилтнүүд бэлтгэгдэн гарч байна. Гэхдээ л манайд 2000 метрийн гүнд өрөмдлөг хийдэг номын дуу сонссон монгол



мэргэжилтэн одоогоор байхгүй. Би л гэхэд дадлагат тулгуурласан мэргэжилтэн шүү дээ. Гэхдээ монгол хүн аливаа зүйлийг сурахдаа сайн. Жишээлбэл, арван жилийн өмнө “Мэйжор дриллинг Монгол” ХХК-ийн өрөмдлөгийн мэргэжилтэн нь Австрали хүмүүс байсан. Харин өнөөдөр энэ компанид ээлжийн ахлагч зургаа, долоон гадаад ажилтныг эс тооцвол бусад нь монгол хүн болсон. Өнөөдөр би дуртай зүйлээ хийж хангалттай цалин авч, сайхан амьдарч байгаадаа сэтгэл тэнэгэр байна” гэлээ.

Анх өрөмчний туслахаар орж байхад түүнд хэлний бэрхшээлээс эхлээд техник технологийн нэр томъёо мэдэхгүйгээс толгойгоо эргэтэл загнуулах үе олон байжээ. Э. Батжаргал “Хүн гэдэг хийж бүтээх эрмэлзлэлтэй бол амьдрал гэдэг тэр аясаар өндийгөөд ирдэг юм билээ. Сайхан амьдрах тэмүүлэлтэй байсан цагт хүнийг сайхан амьдрал хүлээж л байдаг юм” хэмээн ярьсан. ▶

▶ Өнөөдөр Монгол Улсад уул уурхайн хөгжлийг дагаад боловсон хүчний дутагдал тулгамдсан асуудал болоод байна. “Ашигт малтмал олборлох зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон компаниудын 90-ээс доошгүй хувь нь Монгол ажилчид байх ёстой” гэдэг заалт Ашигт малтмалын тухай хуульд байдаг. Гэтэл бодит байдал дээр уул, уурхайн дэвшилтэт технологи, нарийн мэргэжлийн ажилчид өнөөдрийн байдлаар манайд байхгүйтэй адил. Өмнөговь аймгийн иргэд уул, уурхайн компанид ажилд орж байгаа хэдий ч ихэнх нь үйлчлэгч, тогооч гэх мэт цалин багатай ажилд оногдож байгаа талаар хэлж байсан. Өнөөдөр манай улсад хөдөлмөрийн чадвартай 860 гаруй мянган хүн байдгаас 2010 оны байдлаар 113 мянга гаруй

ажилгүй иргэн байдаг гэж Үндэсний статистикийн газраас гаргасан баримтыг бид өмнө нь дурьдаж байсан. “Эрдэнэс Тавантолгой”, “Оюутолгой” гэх мэт томоохон уурхайнууд ашиглалтад орсноор энэ мэт ажилгүйдлийн тоог эрс бууруулна гэсэн хүлээлт нийгэмд үүсээд байгаа. Сүүлийн жилүүдэд төр, засгаас уул, уурхайн салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тал дээр анхаарч эхэлсэн.

ШУТИС-ийн багш нарын хэлж байгаагаар элсэлтийн шалгалт өгөөд хамгийн өндөр оноо авсан оюутнууд эргэлзэх зүйлгүй уул, уурхайн ямар нэгэн ангийг сонгож байгаа гэнэ. Элсэлтийн шалгалтын үед 800 онооноос 770 оноо авсан оюутан уул уурхайн ангид орж чадахгүй уйлаад үлдэж байгаа тухай ч хэлсэн юм.

Намайг ажлын байр хүлээж байгаа

Их засаг дээд сургуульд хоёр жил компьютер, программ хангамжийн чиглэлээр сурч байсан Ш.Батцэнгэл сургуулиа орхижээ. Тэрбээр ирээдүйн амьдрал нь ямар байх талаар тийм ч сайхнаар төсөөлж чаддаггүй байж. Харин одоо хүнд машин механизмын засварчны мэргэжлээр “Оюутолгой” ХХК-ийн тэтгэлгээр сурч байгаа аж. “Би ирээдүйд сайхан амьдрахын тулд энэ мэргэжлийг сонгосон. Баталгаатай өндөр цалинтай ажил олно гэдэг хэцүү. Харин уг сургалтыг төгсөх юм бол намайг ажлын байр хүлээж байгаа” хэмээн баяртай өгүүлнэ. Өдгөө түүнтэй 35 хүртэлх наснаы 40 гаруй залуу сурдаг бөгөөд ажлын байр нь бэлэн гэсэн үг. Мөн сургалтад хамрагдах хугацаандаа сарын 250 долларын тэтгэлэг, өдрийн хоол үнэгүй өгдөг ажээ. Ш.Батцэнгэл

“Сайхан амьдрахын тулд сайн цалинтай байх ёстой. Хүн хэрэгцээгээ хангахын тулд мөнгө олох чадвартай байх нь хамгийн чухал. Би анх зарын сониноос уг сургалтын талаар мэдээд хамрагдсан. Харин одоо хоёр дахь жилдээ сурч байна. Энэ жил “Trans west” сургалтын төвийг төгсөөд ажилтай болно. Өмнөх жил бас л Засгийн газрын шугамаар хэрэгжсэн “Вагнер Ази” компанийн мэргэжил олгох сургалтыг дүүргэсэн. Сургалтад сууж байх явцад архи, тамхи хэрэглэхгүй байхаас эхлээд сайн сурах гээд олон шаардлага тавьдаг. Тавьсан шаардлагыг нь биелүүлээд байвал сурахад хүндрэлтэй биш. Би одоо дөнгөж 23 настай ирээдүйд мэргэжлээ дээшлүүлж, инженер болоод эх орондоо элбэг хангалуун сайхан амьдрахыг л зорьж байна даа” гэсэн юм.



Жолооны ард суугаа нь Ш.Батцэнгэл

Уурхай жинхэнэ эр хүний ажил

Би есдүгээр ангид байхдаа л уул уурхайн чиглэлээр их сургуульд сурна гэж боддог байсан. Уурхай жинхэнэ эр хүний ажил юм шиг санагддаг. Учир нь, газрын гүний баялгийг өөрийнхөө хүч, оюунаар олборлоод гаргаж ирэх хэчнээн сайхан бол. Өнөөдөр уул, уурхай Монгол Улсыг хөгжлийн шинэ шатанд аваачих талаар их ярьж байна. Би дараа жил сургуулиа төгсөөд улс, эх орныхоо хөгжилд гар бие оролцоно гэхээс тэсч ядна. Ирээдүйд өндөр цалинтай сайхан амьдардаг, өөрийнхөө хүссэн мэргэжлийг эзэмшээд мундаг мэргэжилтэн гэж магтуулах юмсан гэж мөрөөддөг” гэж ШУТИС-д уул, уурхайн ашиглалтын инженер мэргэжлээр сурдаг гуравдугаар ангийн оюутан Д.Есөнтөмөр

хэлсэн билээ. Их сургуулиа төгсөөд, гадаадад гарч мэргэжил дээшлүүлэх зорилготой тэрбээр ажлын байранд огт санаа зовохгүй байгаа ажээ. Уул, уурхайн чиглэлээр их сургууль төгсөж байгаа оюутнуудын ихэнх нь ажлын байраар бүрэн хангагддаг болохоор санаа амар байгаа боллолтой. Тэрбээр “Ажлын байрны санал бидэнд их ирдэг. Хамгийн гол нь сайн дүнтэй мөн хоёроос доошгүй гадаад хэлтэй байх шаардлагыг тавьдаг” гэсэн юм. Д.Есөнтөмөр энэ их өрсөлдөөн дунд онц сайн сурч байгаадаа сэтгэл өөдрөг байдаг ажээ. Тэрбээр амьдрал гэх хөлгүй далайд сайхан аж төрнө гэдэгтээ итгэл дүүрэн ирээдүй рүүгээ тэмүүлж явна. ■



Санхүүгийн зах зээл

Зэсийн хомсдол үүснэ

Лондоны металлын бирж дэх зэсийн үнэ савлагаа ихтэй байна. Оны эхээр тонн нь 10 мянган ам.доллараас давж байснаа өсөж буурсаар өнгөрсөн наймдугаар сарын эхээр 8600 ам.доллар болсон юм. Гэвч наймдугаар

сарын сүүлчээс эргээд өсөж, эдүгээ 9000 ам.доллараас даваад буйг графикаас харна уу. Уурхайчдын ажил хаялт, Хятадын эрэлтээс шалтгаалан зэсийн үнэ цаашдаа өсөх хандлагатайг шинжээчид тэмдэглэж байна.

Эдүгээ ашиглаж буй уурхайнуудын хүдрийн чанар муудаж байгаагаас зэсийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлдэг Чили болон Перугийн олборлолт мэдэгдэхүйц багасаж байгаа юм. Үүний хажуугаар Эскондида уурхайд болсон ажил хаялтаас болж олборлолт хоёр долоо хоног саатаж, үр дүнд нь "BHP Billiton" компани 40 мянган тонн зэс үйлдвэрлэж чадалгүй алдсан аж. Өнгөрсөн долдугаар сард Чилийн зэсийн олборлолт өмнөх оны мөн үеэс 18 хувиар унажээ. Долдугаар сарын дундуур мөн "Codelco"-гийн уурхайчид ч ажил хаясны зэрэгцээ Коллахуаси уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл өнгөрсөн жилийнхээс бага байна гэдэг нь тодорхой болсон юм. Түүнчлэн зэсийн үйлдвэрлэлээр дэлхийд толгой цохих Индонезийн Грасберг уурхайн ажилчид ч суулт зарласан нь зэсийн үнэ өсөхөд хүргэв. Наймдугаар сарын эхээр хямдарсан зэсээр нөөцөө бүрдүүлэх зорилготой хятадууд Лондоны металлын биржээс уг металлыг их хэмжээгээр худалдаж авсан нь ч үнийн өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ.

Гэвч зэсийн үнэ өөр ямар ч таваараас илүү макро эдийн засгийн үзүүлэлтүүдээс шалтгаалдаг. АНУ, Европын төсвийн хямрал, Хятадын инфляци уг металлын ханшид сөргөөр нөлөөлөх вий гэсэн эргэлзээ трейдерүүдийн толгойг гашилгаж эхлээд байгаа юм.

"Дэлхийн эдийн засаг унахад зэсийн үнэ буурдгийг бид гурван жилийн өмнө харсан шүү дээ" хэмээн "Standard Bank" хөрөнгө оруулалтын банкны таваарын стратегич Волтер дэ Вэт ярьсныг "Kitco News" дамжуулав. Санхүү, эдийн засгийн хямралаас болж 2008 оны зун 8000 ам.долларт хүрсэн тонн зэсийн ханш өвөл нь 3000 ам.доллараас доош ортлоо навс унасан билээ. Эдүгээ дэлхийн эдийн засаг дахиад хямралд өртвөл зэсийн ханш 8000 доллар болтлоо шалдаа унах тухай Волтер дэ Вэт сануулаад, гэвч энэ тохиолдолд түүнийг худалдан авах сонирхол эрс нэмэгдэхийг тэмдэглэсэн байна.

Зэсийн үнэ буурахгүй, харин ч өснө гэсэн таамаглалтай шинжээч ч цөөнгүй байгааг "Kitco News" онцолжээ. "Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нүүрлэсэнтэй холбоотойгоор


зэсийн ханш савлах төлөвтэй ч бидний үзэж байгаагаар 2012 онд өндөр хэвээр байна" хэмээн "TD Securities" компанийн дэд ерөнхийлөгч Барт Мелек тэмдэглэв. Энэ оны дөрөвдүгээр улиралд тонн зэсийн дундаж ханш 9480 ам.доллар байна гэж тэрбээр таамаглаж буй аж. "Ямартай ч Хятадын идэвх эрс суларна гэж бодохгүй байна. Тиймээс зэсийн эрэлт, хэрэгцээ сайн хэвээр байх хандлагатай" гэж Барт Мелек онцолжээ. "TD Securities"-ийн үзэж буйгаар ойрын хэдэн жилд Хятадын ДНБ-ий өсөлт 8-9 хувьтай гарах бөгөөд энэ нь эрэлт буурахгүйг илтгэх аж.

"Миний бодлоор Хятадын нөөц багасаж байгаа учир оны сүүлчээр их хэмжээний зэс авч, боловсруулан зарна. Тиймээс дөрөвдүгээр улиралд үнэ дээшлэх төлөвтэй" хэмээн "Scotia-bank" банкны дэд ерөнхийлөгч Патрисиа Мор ярьжээ. Үүний хажуугаар Шанхайд тонн зэс 10 мянган ам.доллараас дээш арилжаалагдаж байгаа нь Хятадад эрэлт их байгааг илтгэж буй. Үнийн доорхойноос ашиг олох гэсэн трейдерүүд Лондоны металлын биржээс улаан металл худалдаж авахдаа дуртай байгаа ажээ.


Хятад улс мөнгөний бодлогоо чангатгаж байгаа ч зэсийн эрэлт буурна гэж айх зүйлгүйг Патрисиа Мор тайлбарласан байна. Харин ч Хятад болон олон хөгжиж буй орны зэсийн хэрэгцээ нэмэгдэж байхад олборлолт эрчимжиж чадахгүй байгаагаас энэ оны дөрөвдүгээр улиралд зах зээл зэсийн хомсдолд орно хэмээн шинжээчид үзэж байна. Энэ онд хомсдол 400 мянган тонн байна хэмээн Барт Мелек үзэж байгаа бол "Harbor Intelligence" компанийн тооцооноос харахад уг үзүүлэлт 333 мянган тонн байх аж. Гэтэл "Brook Hunt" компанийн судалгаагаар бол 465 мянган тоннын зэсийн хомсдол бий болох төлөвтэй.

Монгол Улсын хувьд энэ оны эхний долоон сард 328 мянган тонн зэсийн баяжмал экспортолсон нь 577.7 сая ам.доллар болжээ. Үндэсний статистикийн хорооны мэдээллээс үзэхэд зэсийн баяжмал нийт экспортын 24 хувийг бүрдүүлж байгаа юм. Гэхдээ 2013 оноос зэсийн олборлолт огцом өсөх нь ойлгомжтой. Дэлхийд хоёрдугаарт жагсах уурхай болно хэмээн мэргэжилтнүүдийн хүлээж буй Оюутолгойн орд жилдээ 500.000 тонн зэс гаргана гэсэн төлөвлөгөө бий. Энэ нь Чилийн томоохонд тооцогдох Коделко Хорте уурхайн хүчин чадалтай дүйцэхүйц хэмжээ юм. ■

Зэс (тонн/ам.доллар)




Хар тугалга (тонн/ам.доллар)




Никель (тонн/ам.доллар)



Цагаан тугалга (тонн/ам.доллар)



Цайр (тонн/ам.доллар)



Дулмаа амьдралдаа анх удаа цалингийн зээл авахаар банк руу алхаж явна. Хоёр хүүтэй өрх толгойлсон эмэгтэй тэрбээр улсын эмнэлэгт сувилагчаар ажилладаг бөгөөд өнгөрсөн онд цалин нь 30 хувиар нэмэгдэхэд “Болоо ш дээ” хэмээн баярласан. Хүний хөгжил сангаас өгч буй бэлэн мөнгө ч энэ өрхийн амьжиргаанд хэсэгтээ л сайнаар нөлөөлсөн. Гэвч мах, хүнсний үнэ, нийтийн тээвэр, цахилгааны мөнгө, сургалтын төлбөр зэрэг зэрэг нэмэгдчихээр ямар хэрэг байх билээ. Зээл л авахгүй бол Дулмаа бага хүүгээ их сургуульд оруулж чадахгүй болчихож байгаа юм. Улаанбаатар хотод инфляцийн түвшин өнгөрсөн долдугаар сард 11.4 хувьтай гарчээ.

Банкнаас зээлээ авчихаад Дулмаа гэртээ ирж, зурагтаа асаахад энэ оны хоёрдугаар улиралд эдийн засгийн өсөлт 17.3 хувьд хүрсэн тухай таатай мэдээлэл гарч байна. Гэвч энэ хугацаанд иргэдийн амьжиргаа мөн хувиар сайжирч чадсан бил үү? Дулмаагийн анхаарлыг эдийн засгийн гэхээсээ илүү инфляцийн өсөлт л татах ажээ. Бензиний үнэ өссөөр байх уу, унааны мөнгө дахиад нэмэгдэх үү, мах, ногоо хямдрах болов уу? Энэ бүх асуултын хариу ямар байх нь ганц Төвбанкнаас биш, Засгийн газраас мөн хамаарах учиртай.

Санхүү, эдийн засгийн хямралаас болж төсвийн данс улайж, валютын нөөц ёроолоо шүргэхээ дөхөх үед Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч хоёр төсөв, мөнгөний бодлогоо уялдуулна хэмээн амлаж, санамж бичиг үйлдэж байв. Засгийн газар бүсээ чангалж, Төвбанк бодлогын хүүгээ шат дараалалтайгаар өсгөснөөр 34 хувьд хүрч гаарсан инфляцийг чөдөрлөж чадсан юм. Гэтэл эдийн засаг сэргээд, төсөвт орлого ороод ирэнгүүт дээрх хоёр байгууллага маань дахиад л хоёр тийш хараад суучихлаа. Төвбанкны хувьд төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангаж, инфляцийг нэг оронтой тоонд байлгахын төлөө чадах бүхнээ хийж буй. Бодлогын хүүг он гарсаар хоёр дахь удаагаа нэмж, 11.75 хувьд хүргэсний зэрэгцээ банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 11 хувь болгож өсгөх шийдвэр гаргажээ.

Монголын ДНБ-ий өсөлт (хувиар), Лондоны металлын бирж дэх тонн зэсийн үнэ (ам.доллараар)



Эдийн засгийн өсөлт Дулмаад хамаагүй

Гэхдээ эдийн засагт хэт халалтын шинж тэмдгүүд илэрч байгаа энэ үед бодлогын хүүг өсгөлөө гээд инфляцийг “номхтгож” дийлэхгүйг мэргэжилтнүүд тайлбарлаж буй.

Харин Засгийн газар инфляцид санаа тавихаасаа илүүтэй эдийн засгийн тоон өсөлтийг чухалчилж, хажуугаар нь бэлэн мөнгө тарааж, улс төрийн амлалт биелүүлээд тун ч завгүй. Өнөөдөр долоон тэрбум ам.доллараар үнэлэгдэж буй Монголын ДНБ ирэх арван жилд жилдээ л 20 хувиар өсөх хандлагатайг Сангийн дэд сайд Ч.Ганхуяг онцолсон. Уг нь эдийн засгийн огцом өсөлтөөсөө илүү урт хугацааны тогтвортой өсөлт чухал болохыг Олон улсын валютын сангийн Ажлын хэсгийн ахлагч Стивен Барнетт байнга сануулдаг шүү дээ. Голланд өвчин гэх нэрийг дэлхийд таниулсан ч алдаанаасаа суралцаж, хөгжилд хүрч чадсан Нидерландад эдийн засаг нь жилд ердөө 3-4 хувиар өсдөг тухай Дэлхийн банкны тэргүүлэх эдийн засагч Рожер ван дэн Бринк ярьж байсан. Гэвч энэхүү тогтвортой өсөлт нь хүмүүсийн амьдралд бодит өөрчлөлт авчирч, амьжиргааг нь сайжруулж чадсан байдаг. Харин өндөр өсөлт юунд хүргэдгийг монголчууд гурван жилийн өмнө үзсэн бус уу?

2007 онд бэлэн мөнгө эрчимтэй тарааж эхэлснээс яг нэг жилийн дараа инфляци 34 хувьд хүрч, рекорд тогтоож байв. Тэгээд дэлхийн зах зээл дэх

зэсийн үнэ хямралаас болж навс унахад Монголын эдийн засаг хүнд цохилтод орж, хүүхдийн мөнгөө ч тарааж дийлэхээ байсан шүү дээ. Товчхондоо, 2007 онд 10.2 хувиар огцом өссөн Монголын эдийн засаг хоёрхон жилийн дараа “хасах” үзүүлэлттэй болчихсон байлаа. Харин өнөөдөр ашигт малтмалын үнэ эргээд тэнгэрт хадсанаас улсын орлого үлэмж нэмэгдэж, төсвийн тэнцэл ч ашигтай гарч буй. Гэвч энэ нь мөчлөг дагасан төсвийн зам руу эргэж оруулах аюултайг Дэлхийн банк анхааруулсаар. Зэсийн үнэ өсөхөд Монголын ДНБ өсөөд, буурахад нь дагаад доошилж байгааг графикаас харна уу. Үүнийг л мөчлөг дагасан эдийн засаг гээд байгаа юм шүү дээ. Харин өнөөдөр зөвхөн зэс биш, нүүрсний үнэ унахад л манай эдийн засаг хэцүү байдалд орохоор болжээ.

Төсвийн орлого, зарлага асар ихээр нэмэгдсэн, бэлэн мөнгө тараасан, банкуудын олгосон зээлийн хэмжээ үлэмж өссөн, инфляци гаарсан зэргээс үзэхэд Монголын өнөөгийн эдийн засгийн нөхцөл 2008 оны хямралын өмнөх үетэй даан ч ижил байгааг Дэлхийн банкны улирлын тойм харуулна. Хөгжингүй орнуудын төсөв, өрийн асуудал хямрал дагуулж мэдэхээр байгаа энэ үед гай таарч зэс, нүүрсний үнэ буурвал Монголын эдийн засгийн ирээдүй гурван жилийн өмнөх рүүгээ ухраад очиж мэдэх ажээ. Хэрэв ▶

дэлхийн эдийн засаг дахин унавал монголынх шиг жижиг, нээлттэй эдийн засаг гарцаагүй өртөхийг Дэлхийн банк анхааруулж байна. Үүнээс сэргийлэхийн тулд УИХ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль батлаад бүтэн жил болсон ч сонгууль өнгөртөл хэрэгжүүлэхээргүй байгаа нь гунигтай. Төсвийн зардлаа танах биш, харин ч тэлэх тухай эрх баригчид ярьж байна. Баян ядуу хамаагүй монгол хүн бүрт тарааж буй 21 мянган төгрөг багадаад,

ирэх жилээс сайн муу сурдгаар нь ялгалгүй бүх оюутанд тэтгэлэг өгнө гэж байна шүү дээ.

Энэ бүхнээс үзэхэд инфляцийг нэг оронтой тоонд барина гэдэг бүтэшгүй даваа хэмээн Монголбанкны мэргэжилтнүүд санаа алдах аж. Харин Төвбанк бодлогын хүүгээ нэмээд байгаа нь үсрэнгүй хөгжилд хүрнэ гэсэн Засгийн газрын зорилгод саад болох төлөвтэй. Ингэхэд үсрэнгүй хөгжил гэж юу билээ? Эдийн засаг тоон утгаараа өсөх явдал

уу, эсвэл монгол хүн бүрийн амьжиргаа дээшлэх явдал уу? Дулмаагийн хувьд бол ДНБ өснө үү, байна уу хамаагүй. Цалин нэмэгдэж, бэлэн мөнгө авсан ч амьдрал сайжирдаггүйг тэрбээр голдоо ортол ойлгож авсан. Харин дэлгүүр орох бүртээ мах, гурилын үнэ өссөн болов уу гэж бодож, айдгаа л болихыг Дулмаа хүснэ. Монголын олон олон Дулмаагийн хүслийг биелүүлэхийн тулд Сангийн яам, Төвбанк хамтарч, төсөв, мөнгөний бодлогоо нэг тийш чиглүүлэх учиртай. ■

Хөрөнгийн зах зээл

Б.Болд: IPO хийхийн тулд тогтсон үйл ажиллагаа, сайн үнэлгээтэй байх ёстой

Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, “Ньюком” группийн гүйцэтгэх захирал Б.Болдтой хийсэн ээлжит цуврал ярилцлагаа хүргэж байна. Бидний энэ удаагийн ярилцах сэдэв олон улсын бирж дээр IPO-г хэрхэн хийх боломж, нөхцөлийн талаар өрнөлөө. Тэрбээр гадаад зах зээлд хувьцаагаа гаргах хүсэл сонирхолтой яваа компаниудад чухал зөвлөгөө өгсөн юм.

-Монголын уул уурхайн салбарын хөгжилд Монголын хөрөнгийн бирж ямар үүрэг гүйцэтгэх вэ?

-Миний ойлгож байгаагаар хөрөнгийн бирж дээр гарах хэд хэдэн онцлог шалтгаан байна. Нэгдүгээрт, одоо гаднын бирж дээр хувьцаагаа арилжаалж байгаа Монголд үйл ажиллагаа явуулж буй компаниуд. Жишээлбэл, Канадад 15 тэрбум ам.долларын үнэлгээтэй “Айвенхоу майнз”, Хонгконг-д таван тэрбум ам.долларын үнэлгээтэй “Mongolian mining Corporation” болон бусад гадаадын бирж дээр бүртгэлтэй Монголын компаниудын үнэлгээг нэгтгээд ойролцоогоор 30 тэрбум



долларын үнэлгээтэй компаниуд гадаадын хөрөнгийн биржийн зах зээл дээр байна гэж бодъё. Тэгвэл эдгээрийн 5-10 хувийг л Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалдаг болчихвол манайд ойролцоогоор 1,5-3 тэрбум ам.долларын арилжааны боломж гарч ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл, гадаадад хувьцаагаа арилжаалж байгаа Монголын компаниуд дотоодын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргаснаар нийт дотоод хувьцаа

эзэмшигчдийн хүчтэй дэмжлэг болон магадгүй улс төрийн савалгаатай бодлогын эсрэг тэмцэх хүч бий болно гэсэн үг. Энэ нь яагаад чухал вэ гэхээр “Айвенхоу майнз”-ийн хувьцаа Канадын хөрөнгийн бирж дээр хоёр жилийн дотор 2-20 доллар болоход хязгаарлагдмал байдлаар цөөн тооны монголчууд Канадаас тэрхүү хувьцааг худалдаж авах боломжтой байсан шүү дээ. Өөрөөр хэлбэл, монголчууд өөрсдийнхөө байгалийн баялаг дээрээс ▶

► мөнгөн хөрөнгө бүтээх боломжтой болж байгаа юм. Нөгөө талаас мөн эрсдэл даах чадвартай байх ёстой. Мөнгөө алдаж болзошгүй гэдгийг байнга санах ёстой.

Хоёр дахь нь стратегийн ордууд байна. Хэрвээ стратегийн ордуудын лицензээмшигчкомпаниудынхувьцааг авахаар томоохон уул, уурхайн гаднын хөрөнгө оруулагчид манай хөрөнгийн бирж дээр арилжаа явуулдаг болбол Монголд босгож чадах мөнгөн дүн ихсэж бусад дотоодын уул, уурхайн компаниудын хувьд хөрөнгийн эх үүсвэр олох боломжтой болно. Өөрөөр хэлбэл, юмаа хямдхан өгөхгүй хөрөнгө оруулагчдыг өрсөлдүүлж үнээ ихэсгэх боломжтой гэсэн үг. Ер нь уул уурхайн салбарын хөгжил гэдэг нь хайгуулаа улам баталгаажуулах асуудал байдаг болохоор ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө шаарддаг. Тиймээс уул уурхайн хайгуулын санхүүжилтийн хөрөнгө оруулалтыг дэмжээд өгвөл уул, уурхайн салбар хурдацтай хөгжих боломжтой.

-Дотоодын уул уурхайн компаниуд МХБ-ээс их мөнгө босгох үе хэзээ ирэх бол?

-Их мөнгө гэдэг бол өөр ойлголт л доо. Хэдэн зуун сая, тэрбум ам.доллараар яригдах асуудал. Одоогоор манай улсад хууль эрх зүйн орчин хараахан бүрдээгүй байгаа учир Тавантолгой, Оюутолгойгоос бусад дотоодын компаниудын хувьд их хэмжээний мөнгө босгох болоогүй байна. Хэдэн зуун сая, тэрбум ам.доллараар яригдах хэмжээний хөрөнгө босгох хөрөнгө оруулагчид манайд хараахан төвлөрч амжаагүй байна. Гэхдээ “Тавантолгойн” хувьцааг дотоодын хөрөнгийн бирж дээр борлуулж эхэлбэл байдал нэлээд өөрчлөгдөнө. Зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дурьдсанаар Тавантолгой 10 тэрбум долларын үнэд хүрнэ гэж байсан. Тэгвэл үүний 10 хувийг л дотоодын хөрөнгийн бирж дээр борлуулна гэж тооцвол нэг тэрбум долларын арилжаа явагдана. Энэ тохиолдолд манай хоёр сая 800 мянган иргэн бүгд хувьцаанд оролцоод байхгүй шүү дээ. Жилийн дараа гэхэд эдгээр хувьцаа дотоодын бирж, хоёр дахь зах зээл дээр борлуулагддаг болсноор ойролцоогоор 10-20 мянган хүний гар дээр л дээрх хувьцаа төвлөрч эхэлнэ. Энэ мэт хөдөлгөөн дундаас хувьцааны төвлөрөл явагдаж, үүний үр дүнд уул уурхайн салбарыг ойлгодог хөрөнгө оруулагчид Монголд үлдэнэ. Цаашдаа магадгүй хөрөнгө

оруулалтын сангууд ч юм уу Монголын уул уурхайн өөр компаниуд руу хөрөнгө оруулах сонирхолтой болж эхэлнэ. Тэр үед л дотоодын уул уурхайн компаниуд их хэмжээний хөрөнгө мөнгө босгох боломжтой болох юм. Одоохондоо 5,10,20 сая долларын хэмжээний л мөнгө бодож байгаа байх.

-Манай улсын уул уурхайн компаниудын мөнгө босгох урсгал гадагш чиглэж байгаа. Энэ нь дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үйлсэд хэр нөлөө үзүүлэх вэ? Давуу бөгөөд сул тал юу байх бол?

-Уул уурхайн компаниудын эрсдэлийг ойлгодог хөрөнгө оруулагчид Канад, Австрали, Лондонд байдаг. Уул уурхайн компаниудыг дэлхийн уурхайнуудтай харьцуулаад аль нь ашигтай, ашиггүй талаар судалгаа хийдэг “ноу хау” мэдлэг мэдээлэл тэнд байгаа тул их хэмжээний хөрөнгө босгоход бид тэд наргүйгээр явж чадахгүй. Олон улсын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргасан компаниудыг Монголд авчрахад эрх зүйн талаасаа анхаарч ажиллаж байна. Харин хайгуулын компаниудын хувьд Монголын хөрөнгийн бирж дээр 10-20 сая ам.долларын хөрөнгө босгодог орчныг бүрдүүлмээр байна. Монгол Африк биш шүү дээ. 1960-1980-аад оны үед хуучин ЗХУ манай мөнгөөр зарим социалист оронтой хамтарч нэлээд олон ордын хайгуул хийсэн. Одоо бол тэдгээр ордын илэрцүүдийг аваад нэмж өрөмдлөг хийгээд баталгаажуулах л асуудал байгаа юм. Энэ нь тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардана. Харин биднийг нийт газар нутгийнхаа 10-15 хувийг л судалсан гэдэг. Гэхдээ л бидэнд орос ах нарын явуулсан мэдээллийн хангалттай сан бий.

Харин сул тал нь гэвэл гадаадаас мөнгө босгох тусам мөнгөний бодлого эрсдэлд орох магадлалтай. Гадаадад 600 сая доллар босгочихсон компанийн мөнгө Монголд гэнэт нэг дор орж ирэх үү, эсвэл улсын хилээс гадна талд төлбөр хийгдэх үү гэсэн асуудал гарч ирнэ. Үлдлээ гэхэд Монголын юунд зарцуулагдах бол. Эсвэл гадаадад эргэлдэж гадаадынхаа түншээр, гадаад дансаараа дамжуулан техник, технологи, сэлбэг хэрэгслийн худалдаа хийх үү. Нэг талаасаа энэ нь сайн. Нөгөө талаасаа төгрөг, долларын харьцаа жижигхэн эдийн засагтай манай улсад ямар байх вэ, хэр нөлөөлөх бол гэсэн асуудал бий.

-Дотоодын компаниудад гадаадын биржид хувьцаагаа хэрхэн гаргаж, IPO хийх ямар боломж байгаа талаар ярина уу?

-Гадаадын биржид хувьцаа гаргана гэдэг нь хэд хэдэн шаардлага хангах ёстой. Компанийн засаглал, санхүүгийн тайлан, мэдээллийн шинж чанар, компанийн ил тод байдал, шударга ажиллах зэрэг зарчмаас үүдэн тодорхой хэмжээний стандарт шаардлагуудыг хангах ёстой. Зарим бирж, борлуулалт, орлого, ажилласан жилийн хугацааг хардаг. Гурваас дээш жил ажилласан, жилийн цэвэр ашиг нь 50 сая доллараас дээш байх ёстой гэдэг ч юм уу. Ер нь хувьцаа гаргана гэдэг чинь хамгийн үнэтэй санхүүжилт юм. Зээлээс үнэтэй санхүүжилт шүү дээ. Үйл ажиллагаа нь жигдэрсэн, зээлийн санхүүжилт гаргах боломжтой бол гадны биржид хувьцаагаа гаргахаасаа өмнө бонд гаргах нь зүйтэй. ХХБ өнөөдөр найман хувийн бонд гаргаад явж байна. Хувьцааны эзэмшигч жилд дундажаар АНУ-д 10 хувь, манайх шиг жижиг зах зээлтэй, эрсдэлтэй оронд магадгүй 25-аас илүү хувьцааны үнийн өсөлт авахыг хүлээж суудаг. Тэгэхээр тийм хэмжээний санхүүжилт хийнэ гэдэг нь тухайн компани өөрийнхөө хувьцааг бодит үнээс нь 25 хувиар хямд зарж байгаа юм. Хувьцаагаа ийм хямдхан өгөхөд хүрдэг гэсэн үг. Хувьцаа гаргах нь уул уурхайн хайгуулын эхний шатанд зохимжтой байх. Өндөр эрсдэл гаргаж өндөр ашиг олдог шүү дээ. Ийм үед хувьцаа гаргах нь зөв шийдвэр байх болов уу. Харин үйл ажиллагаа нь илүү тогтсон, харилцаа холбооны, онгоцны компаниуд гадаадад хувьцаагаа гаргана гэвэл дэндүү хямд үнээр үнэлэгдэх аюултай. IPO хийх нь сайн муу хоёр талтай. Хувьцааны үнээ зөв тодорхойлох ёстой. Өнөөдөр Монгол моодонд ороод байгаа. Энэ моодны сайн тал нь гадаадын хөрөнгө оруулагчид ихэд сонирхдог болжээ. Муу тал нь гэвэл янз бүрийн чаддаг, чаддаггүй, итгэхэд бэрх, мэдэх, мэдэхгүй гадаадынхан Монголд олноор ирж байна. Хамгийн түрүүнд гадаадын хөрөнгө оруулагчдыг мөнгөтэй эсэхийг нь сайн судлах, мэдэх ёстой. Түүнээс англиар сайн ярьдаг, шар толгойтой бүхнийг хөрөнгө оруулагч гэж үзээд итгэвэл юунд хүргэх вэ.

-Манай дотоодын компаниудын хувьд гадаад зах зээлд хувьцаагаа гаргах сонирхолтой болжээ. Гэвч ажлаа юунаас эхлэх, хэрхэн яаж ажиллахаа мэддэггүй. Энэ талд ►

► зөвөлгөө өгнө үү?

-Хувьцаагаа гаргана гэдэг нь хамгийн түрүүнд үйл ажиллагаа нэлээд жигдэрсэн компани байх ёстой. Ямар ч мэдлэг мэдээлэлгүй, санхүүгийн моделгүй, тайлан тооцоогүй шинэ төсөл бариад л гадаадын бирж дээр IPO хийнэ гээд гүйвэл бүтэшгүй. Монголын хувьд амжилттай хийсэн группуд бий шүү дээ. "Ремикон" компани байна. Энэ компанийн хүмүүс хөрөнгийн зах зээлийг нэлээд ойлгодог мэдлэгтэй залуустай тул Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа амжилттай гаргаад бетон зуурмагийн тэргүүлэх компанитай болсон. Энэ бол дотоодын бирж дээр IPO-г амжилттай хийсэн сайн жишээ. Мөн "Бэрэн" группийг дурдаж болно. Төмрийн үйлдвэрээ өргөжүүлээд явбал бас л амжилттай яваа компанид орно.

Нөгөө талаас маш сайн үнэлгээтэй компани байх ёстой гэдгийг л дахин давтан хэлмээр байна. Тухайлбал, 100 сая ам.доллараас дээш үнэлгээтэй байх ч юм уу. 100 сая долларын үнэлгээ нь Монголд магадгүй 50-60 сая ам. долларын борлуулалттай байх ёстой болно. Ийм хэмжээний борлуулалттай компани манайд хэд байгаа билээ. 15 сая долларын борлуулалттай компани гадаадын биржид очиход цаад тал хүлээж авах уу гээд л асуудлууд урган гарч ирнэ. Хүлээж аваад бүртгэсэн ч гэсэн хувьцаа нь багаар арилжаалагддаг, хүмүүс ихээр авдаггүй хувьцаа болж хувирна. Ийм компаниудын хувьцааг мэргэжлийн хөрөнгө оруулагчид бус жижиглэн мөн хувь хүмүүс худалдан авдаг. Бага арилжаатай компаниудын хувьцааг мэргэжлийн бус жижиглэнгийн хөрөнгө оруулагчид ихэвчлэн худалдаж авдаг. Нимгэн арилжаатай, үнэлгээ нь жижигхэн, спекуляцны /speculation/ хувьцааны нэг аюул нь үнийн савалгаа ихтэй, нэг унаад нэг өсдөг. Энэ нь дараа дараагийнхаа хувьцааг гаргахад хүндрэлтэй болгодог. Сүүлийн үеийн хэд хэдэн ийм жишээ бий. Өнөөдөр Канад, Австралийн хэд хэдэн компаниуд хайгуул ашиглалтын лиценздээ түшиглээд тодорхой хайгуулын ажил санхүүжүүлэх зорилгоор мөнгө босгож байна. Тэнд тэр эрсдэлийг даах чадвартай хөрөнгийн хуримтлал байгаа боловч зарим хувьцаа спекуляцинд авагдсан шинж чанартай байна. Өөрөөр хэлбэл, хэт савалж моодонд орж, эсвэл хэт савалж моодноос гарч байна. Тэгэхээр урт хугацааны хөрөнгө оруулагч хэрэгтэй юу эсвэл түргэн

мөнгө босгох шаардлага нь чухал уу гэдэг зарчмын асуудлуудыг бодох нь зөв. IPO хийх чиглэлээр зөвөлгөө өгдөг хөрөнгө оруулалтын олон зөвлөх банк байдаг. Ийм банкууд танай компани олон улсын зах зээл дээр IPO хийхэд бэлэн болсон эсэхийг хэлж өгдөг. Мөн дэлхийд Ernst and Young, Deloitte, KPMG, Pricewaterhousecoopers гэсэн дөрвөн том аудитын компаниуд байна. Эдгээр нь дэлхийд компаниудын IPO-ны бэлтгэлийг хийдэг том багтай. Нэгдүгээрт, танай компани наад зах нь олон улсын стандартаар аудиттай байх хэрэгтэй, хоёрдугаарт, гадаадад компаниа бүртгүүлсэн байх, гуравдугаарт, уул уурхайн лицензүүд JORC код юм уу, 43-101 стандартыг хангасан байх ёстой гэх мэтчилэн зөвөлгөө өгдөг.

Компаниуд IPO хийхийн тулд үнэлгээ хийлгэх ёстой. Тус үнэлгээ нь компанийн ирээдүйн хэдэн жилийн санхүүгийн моделийг гаргаж ирнэ. Жилд хэдий хэмжээний төмрийн хүдэр, нүүрс гаргах гэж байгаа, дундажаар ямар үнээр борлуулах, ямар ашиг олохоор байгаа зэрэг моделийг 15, 20, 30 жилээр гаргадаг. Эндээс хөрөнгө оруулалт хийхэд сонирхолтой эсэхийг харна. Тэрбум доллар гэсэн том тоо гарч ирвэл мэдээж маш сонирхолтой. 25 сая доллар бол олон улсын хөрөнгийн биржид гарахад хүнд болоод ирнэ. Тухайн ордоос үнэлгээний дүн хамаарна. Манай улсад ч энэ чиглэлээр зөвөлгөө өгдөг байгууллагууд бий. Тухайлбал, Бидисек, MICS буюу Монголын хөрөнгө оруулалтын банк гэх мэт дээрх чиглэлээр мэргэшин ажиллаж байгаа нэлээд хэдэн байгууллага байгаа шүү дээ.

-Гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголын компаниуд МХБ-д давхар бүртгүүлэх сонирхолтой байдаг. Дотооддоо давхар бүртгүүлэх боломж бий юу?

-Эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна. Дотоодын компаниудыг давхар бүртгүүлэхийн тулд хууль эрх зүйн орчин талаас хийх ажил багагүй байна л даа. Тухайлбал, манай уул уурхайн нэг компани Лондонгийн бирж дээр хувьцаагаа гаргасан British Virgin Islands эсвэл Cayman Islands-д бүртгэлтэй байлаа гэж бодъё. Тэгвэл тус компани Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргалаа гэхэд ямар дүрэм журманд захирагдаж явах нь тодорхой бус байна шүү дээ. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг Англи эсвэл Монголын хуулиар зохицуулах уу

гэх мэт асуудлыг тодорхой болгож, эрх зүйн орчныг сайтар бүрдүүлэх шаардлагатай байна.

-МХБ-ийн шинэчлэлийн менежментийн үйл ажиллагаа өнөөдөр ямар шатандаа явна вэ?

-Хэд хэдэн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа. Үнэт цаасны төлбөр тооцоо хадгаламжийн төв МХБ-ийн шинэтгэлтэй нягт уялдаа холбоотой ажиллах шаардлагатай байна. ТӨХ энэ чиглэлээр тодорхой санал боловсруулсан бол Лондонгийн хөрөнгийн биржээс ч хамтран хөгжүүлэх саналаа ТӨХ-нд тавьчихсан. Нэг ёсондоо МХБ баруун, зүүн гараа зэрэг хөгжүүлэх ёстой. Нэг гар нь хөгжөөд нөгөө нь хөгжихгүй байвал ямар үр дүн авчрахав. Тиймээс ҮЦТТХТ-тэй аль аль талаасаа хамтран ажиллах нь чухал байна. Төлбөр тооцоон дээр тухайн хүн мөнгөө урьдчилан төлж байж хувьцаагаа арилжаалдаг систем манайд үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, би өнөөдрийн арилжааны ирээдүйг урьдчилж хараад мөнгөө байршуулах ►

www.sec.gov

/Санхүүгийн зохицуулах хороотой ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг Америкийн үнэт цаасны хороо

http://www.hkex.com.hk/eng/listing/listreq_pro/ListReq.htm

/Хонконгийн хөрөнгийн бирж дээр бүртгүүлэхэд тавигдах шаардлагууд

http://www.asxgroup.com.au/Listings.htm#application_admission_official_list

/Австралийн хөрөнгийн бирж дээр бүртгүүлэхэд тавигдах шаардлагууд

<http://www.pwc.com/gx/en/audit-services/index.jhtml>

http://www.tmx.com/en/listings/listing_with_us/index.html

/Торонтийн хөрөнгийн бирж дээр бүртгүүлэхэд тавигдах шаардлагууд/

шаардлагатай болно. Тэгвэл дэлхий даяар арилжаа хийсэн өдрөөс хойш 2-3 хоногийн дараа төлбөр хийдэг систем үйлчилж байна. Энэ нь эрсдэлтэй л дээ. Тухайн хүн арилжаа хийсэн өдрөөс хойших заасан хугацаанд төлбөрөө төлөхгүй бол яахав, гэтэл энэ хугацаанд хувьцааны ханш уналаа гэж бодье, тэр алдангийг хэн төлөх вэ гэх мэт харилцагч хоорондын эрсдэл гарах аюултай тулгардаг. Тэгэхээр харилцагч хоорондын итгэлийн системийг бий болгох хэрэгтэй болж байна. Тухайлбал, Бат мөнгөтэй ч мөнгөө урьдчилан байршуулах боломжгүй байж болно. Тэгвэл энэ хүнд итгэе, дараа нь мөнгөө шилжүүлээ л гэсэн систем юм. ҮЦТТХТ-өөс санаа зовж буй олон асуудал байгаа. Гэхдээ гадаадын хөрөнгө оруулагчдыг оруулж ирье л гэж байгаа бол энэ системийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай.

Хоёрдугаарт, Лондонгийн ХБ-ээс IT буюу компьютерийн системийн шинэчлэл хийж байгаа. Энэ оны эцэс гэхэд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Мөн 60 хүнийг Лондонд сургалтад хамруулахаар төлөвлөсөн. 30 хүн нь төрийн байгууллага, 30 нь брокер дилерийн компаниудын ажилтнууд. Харин төсвийн хязгаарлалт энэ тэрэгээс болоод төрийн байгууллагын ажилтнууд Лондон явж чадаагүй. Тэгэхээр энэхүү сургалтыг Монголд зохион байгуулах нь дээр юм шиг байна. Ялангуяа брокер дилер, хувийн хэвшлийн оролцоог илүү анхаарах шаардлагатай байна. Саяхан МХБ-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан Х.Алтайг гүйцэтгэх захиралаар томилсон. Мөн МХБ-ийн ерөнхийлөгчөөр Билл Гормон ажиллаж байна.

-Ньюком групп “Newcom mining service” компани байгуулж, уул уурхайн салбарт орж ирж байна гэж ойлгож байна. Тийм үү?

-Бид олон жил хамтран ажиллаж, биенээ таньж, мэддэг болсон Жон Карлсен захиралтай хамтран “Newcom mining service” компани байгуулсан. Жон Карлсен өмнө нь Вагнер Азийн гүйцэтгэх захиралаар ажиллаж байсан, Монголд сүүлийн 15 жилд Вагнер Азийн бизнесийг өргөжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн хүмүүсийн нэг. Newcom mining service компани нь уул уурхайн тоног төхөөрөмжийн үйлчилгээ, засвар, түрээсийн бизнес хийхээр ажлаа эхэлсэн. Дараа жилийн өдйд гэхэд 180 ажилтантай болох том зорилттой байгаа.

Үзэл бодол

Яагаад?



Монгол Улсад эдийн засгийн шинэтгэл явагдаж байна уу? 90-ээд оны эхэн үеийн гэнэн итгэмтгий, дунд үеийн өөдрөг бадрангуй, 2000 оноос хойши хөгжилд чиглэсэн реформын үе шатууд үр дүнгээ өгсөн үү? Шинэчлэл өөрөө үйл явц болохоор “явагдаж байна” гэсэн товч хариулт өгч болно. Реформын үе шатууд ч өөрийн тавьсан зорилго, хамрах хүрээ, цаг хугацаа, орон зайдаа тодорхой үр дүнгээ өгсөн. Гэтэл яагаад шинэчлэлийн үйл явцаар бий болох ёстой эдийн засгийн тогтвортой өсөлт ард түмэнд бодитойгоор мэдрэгдэхгүй байна? Яагаад 10 гаруй хувийн өсөлт гарлаа гэж нэг хэсэг нь бахархаж байхад ихэнх хэсэг нь бахархахгүй, харин ч гайхан эгдүүцэж байна? Яагаад эдийн засгийн шинэчлэл хийгээд л байсан юм бол авлига газар аваад, ядуурал нэмэгдээд байгаа юм? Яагаад бүгд л макро эдийн засаг, мөнгөний бодлого гэж жил бүр яриад л боловсруулаад л батлаад байгаа мөртлөө үр дүнд нь хүнд суртал улам нэмэгдээд бизнес хийх эдийн засаг, санхүүгийн орчин муудаад байгаа юм? Яагаад хүмүүс татвараас, төрөөс, эх орноосоо дайжиж зугтаагаад байна? Яагаад бид агуу их Монгол, Чингис хаан гэж гаднын жуулчдад бахархан танилцуулаад байгаа мөртлөө яг үнэндээ одоо бахархдаг юм нь маруухан байна? Яагаад ардчилал, түүний үнэлэмжүүд нийгмийн биед олигтой шингэхгүй байх, гэмт, хэрэг, ядуурал архидалт, нийгэм сааралтан гундах энэ бүхний уг шалтгаан, учир холбогдол нь хаана, юунд байна?

Энэ олон асуултыг бид өөрсдөөсөө асуух уу, эсвэл том том боть бүтээлүүд, хэтийн хөгжил, төсөл яриад костетик маягийн өнгөн засал хийгээд Чингисийн нэрийг бариад л хоосон бахархаад өөрсдийгөө хуураад өөрсдөө ч халтуурдаад явах уу? Асуух, тэр байтугай тодорхой хариултууд өгөх ёстой байх аа.

Хүний амьдралд тодорхой хугацааны дараа гишгэсэн мөрөө эргэн харах, эргэцүүлж цэгнэх, сургамж авч явдгийн адил реформын сүүлийн 20 жилийн туулсан замаа Монголын нийгэм, Монголын төр эргэн харж ултай суурьтай дүгнэлт, урагшаа харсан бодлогоо нягтлан тодорхойлох шаардлага бий болчихжээ. Нөгөө бидний “элэг зүрхнээс уяатай” гэж дуулах дуртай Монголынхоо хөгжлийг, түүнийг хангах бодитой арга замыг тодорхойлох цаг нэгэнт болжээ. Гэхдээ 2020, 2030 онд тэгж хөгжинө, тийм түвшинд хүрчихсэн байна ч гэдэг юм уу эсвэл Монгол Азийн бар, Азийн санхүүгийн төв болно, хөдөлмөр, капитал, баялгийн урсгал Монгол руу чиглээд л Монгол хөгжлийн цоо шинэ мундаг загвар болно гэсэн далд мөрөөдөл, санаа, агуулгатай одоо байгаа олон зуун хуудас цаас, ботьнуудын нийлбэрийг хэлж байгаа юм биш шүү. Бид дэндүү их цаас өөрсдөө бас олон улсын төслүүдтэй нийлээд өнгөрсөн жилүүдэд хангалттай үйлдвэрлээд нөөцлөөд авчихсан. Улс оронд mission гэж нэрлэдэг эрхэм зорилго, vision гэж нэрлээд байдаг алсын хараа хэрэгтэй юу гэвэл үнэхээр хэрэгтэй. Гэхдээ үүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь харин маш тодорхой, бодитой, жижигхэн юмнаас л эхэлдэг. Энэнд цаас хэрэггүй. Малаа хариулж буй малчин хүн, төрд алба хашиж буй хүмүүс, сургууль төгсөж буй эсвэл элсэх гэж буй залуус, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээд явж буй бизнес эрхлэгчид, эсвэл яаж ажил олдог юм билээ гэж санаашран яваа ажилгүйчүүд энэ бүх хүмүүст л яаж илүү сайн амьдрах нөхцөлийг нь бүрдүүлэхээс л хөгжил эхэлдэг.

Өөрөөр хэлбэл эцсийн дүндээ хөгжлийн тухай асуудал нь хүний сайн сайхан амьдрах чадварыг дээшлүүлэх л асуудал байдаг. Өөр юу ч ярьсан эцсийн дүндээ энэ цэг дээр л тулж очдог. ■

Инфляци өссөнд гахай буруутай

Хятадын эрх баригчдын инфляцийн Эсрэг зарласан дайн үр дүнгээ өгөөгүйгээс гадна аж үйлдвэрлэлийн өсөлтөө мэдэгдэхүйц доош нь чангаав. АНУ болон Европын орнууд хэцүү байдалд орсны зэрэгцээ эдийн засгаараа хоёрдугаарт жагсах БНХАУ хүртэл асуудал үүсгэж эхэлсэн нь улс үндэстнүүдийн санааг улам зовоох боллоо. Ялангуяа өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг урд хөршөөсөө авдаг монголчуудын хувьд энэ нь аюулын дохио болж байгаа юм.

Өнгөрсөн долдугаар сард Хятадын инфляци 6.5 хувьд хүрсэн нь сүүлийн гурван жилийн дээд үзүүлэлт болов. Тус улсын Төвбанк он гарсаар банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг зургаан удаа өсгөж, бодлогын хүүгээ гурвантаа нэмсэн нь ч үнийн өсөлтөд нөлөөлж чадсангүй. Үр дүнд нь шал өөр салбарт мэдрэгджээ. Зургадугаар сард 15.1 хувьтай гарч байсан аж үйлдвэрлэлийн өсөлт долдугаар сард 14 хувь дээр ирээд гацчихсан байна. Энэ онд инфляцийг дөрвөн хувьд “чөдөрлөнө” гэсэн Хятадын Засгийн газрын амлалт бүтэшгүй мөрөөдөл болсон нь нэгэнт ойлгомжтой болов. Тус улсын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Зан Пин ч үүнийг хүлээн зөвшөөрчээ.

Хамгийн аймшигтай нь эдүгээ хятадууд төдийгүй дэлхийг сандаргаад буй 6.5 хувь гэх үзүүлэлт зүгээр л статистикийн хуурай тоо аж. Бодит амьдрал дээр байдал илүү хүнд байгааг эдийн засагчид анхааруулж буй. Хятадад хүнсний бүтээгдэхүүн, ялангуяа махны үнэ огцом өсөж байгааг Дэлхийн банк тэмдэглээд, энэ хандлага цаашид ч үргэлжлэх төлөвтэйг сануулжээ. Өнгөрсөн долдугаар сард махны үнэ л гэхэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 хувиар нэмэгдсэн байна.

Азийн өрсөлдөх чадварын институтын захирал Ко Ямын хэлснээр Хятадын инфляцийн өсөлтөд гахай буруутай гэнэ. Сүүлийн нэг жилийн хугацаанд гахайн махны үнэ 50-60 хувиар өссөн тухай “Синьхуа” агентлаг



мэдээлэв. Хэрвээ гахайн махны үнийг хасаж тооцох юм бол инфляцийн түвшин 4.8 хувь байх байсныг Ко Ям учирлажээ.

Ер нь бараа, бүтээгдэхүүний үнэ Хятадын Үндэсний статистикийн хорооноос гаргасан тооноос хамаагүй хурдтай өсөж буйг урд хөршийн иргэд мэдэрч байгаа юм. Тухайлбал, тэдний өргөн хэрэглэдэг газрын самрын тосны үнэ ганц жилийн дотор 20 орчим хувиар дээшилжээ. Хүнсний үнэ тэнгэрт хадаж байгаа ч эрчим хүч, түлш, шатахууны ханш харьцангуй тогтвортой байгаа нь иргэдийн амьжиргаанд бага ч гэсэн нэмэр болж буй аж.


Хятадын эрх баригчид инфляцитай дайтаж сүүлийн хэдэн сарын турш эрчим хүч, түлш, шатахуун болон тээврийн үйлчилгээний үнийг “царцаасан”. Гэхдээ албан хүчээр явуулж буй энэ бодлого эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх янзтайг эдийн засагчид анхааруулж байна.

Нүүрсний үнэ нэмэгдсээр байтал эрчим хүчний ханшид хязгаарлалт тавьснаар урд хөршийн таван томоохон дулааны цахилгаан станц энэ оны эхний хагас жилд 2.4 тэрбум ам.долларын алдагдалтай ажилласан тухай Хятадын эрчим хүчний ассоциаци

мэдэгджээ. Тус улс эрчим хүчнийхээ 80 хувийг нүүрснээс гаргаж авдаг гэж бодохоор аймшигтай дүр зураг гарч ирэх нь ойлгомжтой. Алдагдлаа багасгахын тулд дулааны цахилгаан станцууд янз бүрийн шалтгаан тоочиж, үйлдвэрлэлээ бууруулсантай холбоотойгоор өнгөрсөн тавдугаар сараас урд хөршийн зарим муж эрчим хүчний дутагдалд орж эхлээд буй аж. Үүний хажуугаар энэ онд БНХАУ-д дөрвөн сая тонн дизель түлшний хомсдол үүсэх төлөвтэй гэсэн таамаглалыг “С1 Energy” компани гаргасан байна. Мөн нийтийн тээврийн үйлчилгээний үнийг төрөөс барьж буй явдал хотуудын төсөвт багагүй дарамт учруулж буй талаар “Forbes” мэдээлжээ. Таксины үйлчилгээний үнийг хүртэл Засгийн газраас нь хянаж буйгаас болж жолоочид жагсаал цуглаан зохион байгуулах нь хэвийн үзэгдэл болох шахав. Тухайлбал, Ханжоу хотод ийм төрлийн жагсаал болоход эрх баригчид нь үнээ ялимгүй өсгөхийг нь зөвшөөрч, дээрээс нь бас татаас өгөх шийдвэр гаргаж байж арайхийн намжаасан байх жишээтэй. Энэ бүхнээс үзэхэд 6.5 хувь гэсэн хуурай тооны ард Хятадын эрх баригчдын “чөдөрлөх” гэж хичээж буй том тоо нуугдаж байгаа юм. ■

Санхүүгийн зах зээл

IPO хийхэд таагүй болжээ



2010 онд Бразилийн “Petrobras” хөрөнгийн зах зээлээс 70 тэрбум ам.доллар босгосноор бизнес эрхлэгчдийн хорхойг хүргэсэн. Америкийн даатгалын компани болох IAI, Хятадын хөдөө аж ахуйн банк, автомашины “акул” GM тус бүр 20-иос дээш тэрбум долларын IPO хийж байв. Хямрал цаашилж эхэлмэгц хөрөнгө оруулагчдын цөс нь хөөрч, хувьцаа авахдаа өөдрөг байжээ. Монголоос ч “Hunnu coal”, “Naranga resources”, MMC Австрали, Хонконгийн хөрөнгийн биржид амжилттай гарч чадсан. Энэ бүхнийг харж баярласан бизнесмэнүүд энэ онд баахан IPO хийхээр төлөвлөсөн байв. Гэвч зах зээл амрахаар шийдсэн бололтой.

“Bloomberg”-ийн судлаачдын тооцоолсноос үзэхэд энэ оны сүүлийн хагас жилд дэлхий даяар 720 IPO хийх төлөвтэй бөгөөд энэ нь сүүлийн дөрвөн жилийн дээд үзүүлэлт юм байна. Гэхдээ одоогоор тавдугаар сард 10 тэрбум ам.доллар босгож чадсан Швейцарийн “Glencore” компаниас өөр томоохон IPO алга. Энэ нь 2010 оны хэмжүүрээр бол хэтэрхий “жул” тоо билээ.

Дэлхийн 23 хөгжингүй орны хөрөнгийн зах зээлийн байдлыг

илтгэдэг MSCI World индекс өнгөрсөн тавдугаар сард сүүлийн гурван жилийн дээд цэгтээ тулж очсон боловч маш их хэлбэлзэлтэйгээр буурсаар, наймдугаар сараас хойш бүр доошилсныг графикаас харна уу. Европын өрийн хямрал, АНУ-ын төсвийн асуудлаас болоод хөрөнгө оруулагчдын итгэл буурсныг энэ нь харуулна. Хятадууд инфляцийн түвшнээ багасгаж чадахгүй зовж, япончууд газар хөдлөлтөөс үүдсэн хохирлоо арилгах гэж ядаж байгаа энэ үед IPO хийх нь яаж ч бодсон маш их эрсдэлтэй алхам ажээ.

Он гарсаар олон улсын хөрөнгийн зах зээлд хийсэн IPO-гийн үлэмж хэсэг нь амжилтгүй болсон байна. Тухайлбал “Prada” анхдагч зах зээлд хувьцаа гаргахаасаа өмнө тооцоогоо хэд хэдэн удаа буулгасан бөгөөд Хонконгийн хөрөнгийн биржээс 2.6 тэрбум доллар босгоно гэж байснаа эцэстээ 2.1 тэрбумыг л олж авсан байна.

Баруун Европт ч ижилхэн дүр зураг ажиглагдаж буй. Энэ оны эхний хагас жилд IPO хийсэн 69 компанийн 36-гийнх нь хувьцаа анхдагч зах зээлд гарснаасаа доогуур үнээр арилжаалагдаж байгааг “Bloomberg” тэмдэглэжээ. Үүний хажуугаар


22 компани IPO-гоо төлөвлөсөн хугацаандаа гаргалгүй хойшлуулахаар шийдсэн байна.

Хөрөнгийн зах зээлээс мөнгө босгоно хэмээн төлөвлөж байсан хүмүүс энэхүү зорилгоо хойш тавьж, зах зээл тогтворжихыг тэвчээртэй хүлээх болжээ. Компаниуд IPO-гоо хойшлуулж байгаа тухай мэдээлэл энд тэндгүй цацагдана. Сүүлийн жишээ гэвэл “Facebook” мэтийн нийгмийн сүлжээний хэрэглэгчдийн дунд өргөн тархсан компьютерийн тоглоом зохион бүтээгч “Zynga” есдүгээр сарын эхээр IPO хийх зөвшөөрлөө авсан байсан боловч оны сүүлч хүртэл хойшлуулжээ. Тус компани анхдагч зах зээлд хувьцаа гаргахаа хойш тавьсан ▶

Топ 20






DAX



Dow Jones





► нь зах зээл тогтворгүй байгаатай холбоотой байж мэдэхийг “The New York Post” тайлбарласан байна. “Standard & Poor’s” агентлаг Америкийн зээлжих зэрэглэлийг бууруулснаар олон улсын хөрөнгийн зах зээл гүн

уналтад орсон боловч эдүгээ сэргэх хандлагатай боллоо. Гэвч зах зээл мэдрэмтгий хэвээр л байна. Хятадын инфляци өссөн, Америкийн ажилгүйдэл нэмэгдсэн гээд таагүй мэдээлэл бүрийг шүүрэн авч, голлох индексүүд

түвэггүй унах боловч сэргэхдээ ч амархан байна. Ийм тогтворгүй зах зээлд хувьцаа гаргахаас цааргалаж буй бизнесмэнүүд зүгээр дэлхийн эдийн засгийн байдал хэзээ сайжирч, цэгцрэхийг хүлээж сууна. ■

Статистик


Гадаад худалдааны алдагдал 1.2 тэрбум ам.доллар байна

Үндэсний статистикийн хорооны мэдээллээс үзэхэд өнгөрсөн наймдугаар сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 6.4 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 84.5 хувиар өссөн үзүүлэлт аж. Дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ өндөр байгаагийн зэрэгцээ нүүрс, газрын тосны олборлолт огцом нэмэгдсэн нь экспорт 55.6 хувиар өсөхөд нөлөөлжээ. Тэгвэл уул уурхайн эрчимтэй өсөлт, ялангуяа Оюутолгойн бүтээн байгуулалттай холбоотойгоор импортын хэмжээ 2.1 дахин өссөн байна. Ингээд гадаад худалдааны алдагдал наймдугаар сарын 15-нд 1.2 тэрбум ам.долларт хүрчээ.

Гадаад худалдааны нийт эргэлт (сая ам.доллараар)

2011	6404
2010	6177
2009	4023
2008	5779
2007	4009
2006	2977
2005	2241

Монгол Улсын экспортод эзлэх ашигт малтмалын хэмжээ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Made in Mongolia

Мод хөглөөч

Э.Зоригт

Хорвоо дэлхийг бүүвэйлэх морин хуурын хоёрхон чавхдаснаас уянгалах зөөлөн аялгуугаар монгол орныг төсөөлөх гаднынхан цөөнгүй. Монголчууд бид ч мөн адил морин хуураа дээдлэн, өөрийгөө болоод өвөг дээдсийн ариун түүхийг энэ хөгжимтэй салшгүй холбоотой хэмээн үзэж хоймортоо залдаг. Тиймээс манай сэтгүүл энэ удаагийн “Made in Mongolia” буланд аа морин хуур урлаачтай уулзлаа.

Хуур хийхэд хамгийн тохиромжтой мод нь хус, хуш, нарс

Босго давах төдийд мод, цавууны үнэр хамар цоргиж тог гэх чимээ сонстох аж. Хамаг оюун санаагаа хийж буй зүйлдээ төвлөрүүлсэн 30 гаруй настай энэ эр орчин тойрноос тасарчихсан гэлтэй харагдана. Хүн орж ирсэн гэдгийг ч мэдэх сөхөөгүй нимгэн хавтгай модтой “ноцолдох” түүнийг

“Bayar and Brothers” ХХК-ийн захирал, урлаач Б. Баярсайхан гэдэг. Энэ сонирхолтой үйлдэл нь сайн морин хуур урлах хамгийн чухал ажиллагаа ажээ. Түүний тогших хавтгай мод нь хуурын цар буюу ишний дор байрлах дөрвөлжин хайрцаг бүхий зүйлийн нэг тал нь аж. Ийнхүү тог тогших нь модыг хөглөж байгаа хэрэг. Б.Баярсайханы хэлснээр Мод бүхэн өөрийн хөг “хэл”-тэй байдаг гэнэ. Морин хуур урлаж буй хүн модны юу гэж хэлэхийг сонсож чаддаг мөн өөрийгөө ойлгуулдаг байх нь хамгийн чухал ажээ. Тиймээс мод тогшиж хөгийг нь тааруулж чадаж гэмээнэ морин хуур өөрийн гэсэн хөг аяг гаргаж чаддаг байна. Морин хуурын ишний дор байрлах дундаа нүхтэй дөрвөлжин хэсгийг цар гэдэг байна. Энэ хэсгийг бүрдүүлж байгаа модыг сайн хөглөхгүй бол хуур сайхан дуугарч чадахгүй. Б. Баярсайхан урлаачийн хэлсэнчлэн “Хүн бүрт цар хөглөх өөр өөрийн гэсэн арга бий. Зарим нь модыг хөгжмийн эгшгээр хөглөж байхад нөгөө хэсэг нь нимгэн зузааныг нь шалгадаг. Харин би бол тогшиж хөглөдөг. Мод хөглөх нь нэлээд ур дүй, дадлага туршлага шаардсан ажил. Хэрвээ царны хөг буруу байх юм бол хэчнээн сайхан чавхдас байлаа гээд хуур олигтой дуугарахгүй” гэсэн юм. Тухайлбал, өсгөгчгүй чанга яригч дуугардаггүй шиг царгүй морин хуур хөг ая гаргаж чадахгүй. Мод ямар хөгтэй байх нь маш олон зүйлээс шалтгаалдаг юм байна. Тиймээс морин хуур хийх модыг хэд хэдэн шалгуураар сонгоно. Чухам ямар мод сонгохоос л морин хуур урлах ажил эхэлдэг гэсэн үг. Уулын хаанаас, хэдэн настай, хэрхэн хатагдсан мод сонгох вэ гэдгийг нарийн шийдсний дараа ▶

► модыг хэмжээний дагуу авдаг байна. Хуур хийхэд хамгийн тохиромжтой модонд нь хуш, хус, нарс орно. Ингээд сонгосон модоо наранд зөв хатаах ёстой. Яаж хатаах нь тухайн урлаачийн өөрийн гэсэн нууц гэнэ билээ. Хэр удаан зөв хатаана чанарждаг байна. Б.Баярсайхан “Би 20 -иод жил хуур урлаж байна. Би анх хуур хийхийн тулд хатааж авсан модоо одоо ч гэсэн хадгалдаг. Хамгийн нандин гэсэн захиалгатаа тэр модноосоо ашигладаг” гэсэн юм. Ийнхүү хатаасан модоор хамгийн түрүүнд захиалагчийн өгсөн загварын дагуу морин хуурын толгойн хэсгийг хийнэ. Үүний дараа ишийг нь хийх бөгөөд хуур захиалсан үйлчлүүлэгчийн онцлогт тохируулан өргөн, нарийн, урт, богино хийдэг байна. Энэ хооронд, мар, чих, нум гээд бусад зүйлийг бэлэн болгоно. Хамгийн сүүлд царыг хийх бөгөөд дээр дурьдсанчлан хөглөж мөн эрхий хуруун чинээ жижиг харуул, алх, хөрөө зэрэг сонихон багаж хэрэгслээр харуулдах, зүлгэх, зүсэх гээд нэмэлт ажлыг хийж гүйцэтгэнэ. Дөрвөн хавтан бэлтгэх ба нүүрэн хэсгийн хавтанд нүх гаргана. Энэ нүх мөн дуугаралтад нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг учраас их учиртай. Үүний дараа бэлэн болсон хавтангуудыг хооронд нь нааж цар өөрийн гэсэн хэлбэр дүрсээ олно.

Хуурын чавхдасын нэг нь л гэхэд 100-120 ширхэг сүүлнээс бүрддэг

Урлаач сайн хуур хийж чадах эсэх нь түүний багаж хэрэгслээс ихээхэн хамааралтай. Одоо хорвоо дэлхийг гайхшруулсан хоёр чавхдасыг бэлтгэх ажил хүлээж буй. Морин хуурын чавхдасыг адууны сүүлээр хийх бөгөөд хууранд бэхлэх явцад тасрахааргүй бөх батыг сонгоно. Хэдийгээр харахад хоёрхон чавхдас байгаа мэт ч үнэндээ нэг чавхдас 100-120 ширхэг адууны нарийн сүүлнээс бүрддэг ажээ. Тиймээс ширхэг бүрийг сайтар шалгах хэрэгтэй. Дараагийн шатанд ийнхүү сонгосон сүүлээ боловсруулна. Хүн бүр өөр өөрийн аргаар боловсруулах ба хамгийн анхаарах зүйл нь сүүлийг гэмтээлгүйгээр цэвэрлэх явдал юм. Б.Баярсайхан сүүлийг цэвэрлэхдээ ихэвчлэн эдийн савангаар угаадаг гэнэ. Хэрвээ өөр төрлийн бодис угаалгын нунтгаар угаавал сүүлний тослог, бөх бат чанар алдагддаг байна. Ийнхүү чавхдасыг бэлэн болгосны дараа эд ангиудыг өөр хооронд нь холбоно.

Морин хуурын нэг онцлог нь хадаасаар тогтоосон эд анги нэг ч байхгүй бөгөөд ямар нэгэн металл,

төмөрлөгийн зүйл ордоггүй цөөхөн хөгжмийн зэмсгийн нэг юм. Ийнхүү хэлбэр дүрсээ олсон бэлдэцээ будаж, янзална. Морин хуурын эх бие бэлэн болох үед өмнө нь бэлтгэсэн чавхдасыг бөхөлнө. Царны дотор талд мөн хөглөгч байрлуулах агаад энэ нь чавхдаснаас ирэх аяыг боловсруулаад гадагш гаргадаг гэнэ. Энэ бүгдийн дараа хуурын хоёр чавхдасыг тоглох ая, тоглож буй хүнээсээ шалтгаалан өөр өөрөөр хөглөдөг ажээ. Ийнхүү бэлэн болсон морин хуур “Pegasus” дэлгүүрт эзнээ хүлээн эгнэнэ. Уг дэлгүүрт морин хуур дунджаар 350 мянган төгрөгөөр худалдаалагддаг аж. Б.Баярсайханы хийсэн морин хуур өдгөө чанартай, цэвэр дуугаралттай, өнгө үзэмж сайн гэх үнэлгээг үйлчлүүлэгчдийн зүгээс авчирчээ. Түүний хэлснээр “Өнөөдөр манайд олон хүн морин хуур хийж байна. Гэхдээ гарын таван хуруунд багтах цөөн тооны урлаачид л чанарын өндөр түвшинд хийдэг. Гадуур зарагдаж байгаа хуурыг аль нь сайн, аль нь муу гэдгийг жирийн хүний нүдээр ялгах боломжгүй. Тиймээс хүн бүр л өөрийн хийсэн морин хуурыг сайн гэх байх. Ийм учраас ихэнх мэргэжлийн морин

хуурчид өөрийн гэсэн хуур урлаачтай байдаг” гэсэн юм. Тэрбээр хуур урлаад зогсохгүй “Этүгэн” нэртэй морин хуурын хамтлагт хүчин зүтгэдэг.

Мөн “Pegasus” төвд бүх л төрлийн хөгжмийн сургалт, худалдаа эрхэлдэг ажээ. Өнөөдөр түүний урласан хөгжмийн зэмсэг нь Монголын морин хуурыг төлөөлж АНУ-ын Нью-Йорк дахь “Shubert club” хөгжмийн тvvxийн музей, Аризона мужийн Феникс дахь дэлхийн хөгжмийн музей /MIM/ -д тавигдсан байна. Түүнчлэн УАДБЧ, Морин хуурын чуулга, СУИС, ХБК, Соёлын дээд сургууль зэрэг урлагийн байгууллага төдийгүй Япон, Буриад, ӨМӨЗО-ны морин хуурчид Б.Баярсайханы бүтээлээр хөгжимддөг. Тэрбээр 2009 онд “Морин хуурын стандарт хэмжээ” хэлэлцүүлэг зохион байгуулж, баталгаажуулсан зэрэг нь түүний 20-иод жилийн туршид хичээнгүйлэн зүтгэсний үр дүн юм. Б.Баярсайхан морин хуурыг өр зүрхнээсээ хайрладаг нэгэн билээ. Өөрийн ур, ухаанаар хийсэн хуураар хүний сэтгэлийг хөдөлгөн хөгжимдөх нь амгалан хийгээд сэтгэл хөдөлгөм ажээ. Хуур, хүн хоёр зохицон уусахын хором энэ ажгуу. ■

Бизнесийн зөвлөгөө

Бизнес эхэлж буй хүний долоон алдаа

Таны төслийг “бөмбөг дэлбэлнэ” гэдэгт итгэсэн хөрөнгө оруулагч олон зүйлийн хажуугаар нүдээ аниад өнгөрч чадна. Гэвч заримдаа хэний ч анзаарамгүй энгийн үйлдлээс болж тэдний дургүйцэл маш их төрдгийг анхаарах хэрэгтэй. Хөрөнгө оруулалтын томоохон сангийн төлөөлөгчидтэй уулзаж, өөрийн төсөл, бизнест мөнгө олохоор яваа хүмүүс ямар алдаа гаргахгүй байвал зохихыг “Forbes” сэтгүүл тодруулсан юм. “General Catalyst” компанийн захирал Жоэл Камлер, “EDventure Holdings” сангийн ерөнхийлөгч Эстер Дайсон, “Almaz Capital Partners” сангийн Александр Галицкий, “Intel Capital” сангийн тэргүүн Игорь Табер, “Neurok” компанийн ерөнхий захирал Вадим Асадов нарын зөвлөгөөг хүргэе.



Хоцрох

Анхны уулзалтандаа хоцорч ирсэн бизнесмэн төсөл, бизнестээ санхүүжилт олох талбараас эхний ээлжинд хасагдах юм байна. Замын түгжрэл мэтийн шалтаг хэлээд хөрөнгө оруулагчдын бодлыг эргүүлж чадахгүй л болов уу. Өөрийн бизнес төслийг үнэн голоосоо хайрлаж, санхүүжилт хайж байгаа хүн замдаа хэр цаг зарцуулахаа тооцоолох ёстой шүү дээ. Бас хоцорч ирчихээд хөрөнгө оруулагчдын огт мэдэхгүй зүйлийн талаар яриад эхэлбэл тэднийг хүндлэхгүй байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх аж. Үүний хажуугаар ямар ч бэлтгэлгүй ирснээ ч гайхуулж дөнгөх юм ►► байна.



Мэдэн будилах

Хөрөнгө оруулагчидтай уулзах үедээ бизнесмэн ямар нэгэн асуултыг сонсоогүй дүр үзүүлэх, эсвэл сэдвээ өөрчилж, огт өөр зүйлийн тухай ярьж эхлэх нь “сэжигтэй” санагддаг аж. “Хэрэв хүмүүс асуултад шууд хариулахгүй, эхэлж ярьсан зүйлээ үгүйсгэж, мэдэн

будилж байгаа бол сайны дохио лав биш” хэмээн Эстер Дайсон онлов. Гэхдээ улайм цайм ярианы сэдвийг булзайруулах, харилцаж буй хүнийхээ байр суурийг ярианы явцад хүлээн зөвшөөрөн өөрийн бодлыг өөрчлөх хоёрын хооронд ялгаа байдгийг “Neurok”-ийн Вадим Асадов тэмдэглэлээ.



Зуучлагч авчрах

Хөрөнгө оруулагчидтай уулзахдаа төслийг нь танилцуулах өөр хүн дагуулж ирж буй бизнесмэн мөн л эргэлзээ төрүүлдэг байна. Хэрвээ энэ хүн өөрийн бизнесийн талаар хөрөнгө оруулагчдад танилцуулж чадахгүй юм бол ирээдүйн хэрэглэгчид болон

түншүүдтэйгээ яаж ойлголцох болж байна аа? гэсэн асуулт гарч ирнэ. “Шинэ санаа гаргасан хүнд сэтгэл хөдлөл, бүтээлч сэтгэлгээ, бага зэргийн түрэмгий араншин байх ёстой” гэж Жоэл Катлер үзэж буй. Хэрэв энэ бүхэн үгүй бол санхүүжилт олох боломж эрс багасаж магадгүй аж.



Бусдын цагийг үрэх

“Хэтэрхий их чалчдаг хүнийг тэвчиж чаддаггүй. Хэрэв бизнесмэн нэг цагаас илүү яривал дахиж уулзах, эсэхээ сайн бодох хэрэгтэй болно” хэмээн “Almaz Capital Partners”-ын Александр Галицкий өгүүлэв. Компани цаашид юу хийх, яаж ажиллах зэргийг алхам бүрээр нь нарийвчлан танилцуулах хэрэггүй. Мөн зах зээлийн бүх боломж, ирээдүйн

хэрэглэгчдийг ч нэгбүрчлэн тоочих шаардлагагүй. Бизнес эхэлж буй хүмүүсийн гаргадаг түгээмэл алдаа бол хэд хэдэн төсөл танилцуулаад, аль нэгийг нь сонгохыг хөрөнгө оруулагчдаас хүсэх явдал юм. Ер нь төслийн танилцуулга нь ажиллах баг, зах зээлийн багтаамж, бүтээгдэхүүний давуу тал гэсэн гурван гол асуудалд түшиглэсэн 15 слайдаас хэтрэхгүй хэмжээтэй байвал зохилтой.



Хэтэрхий дуулгавартай байх

Бусдын үгийг сонсохгүй, хэтэрхий гэжүүд зан гаргах нь мэдээж онцгүй л дээ. Нөгөө талаас нь авч үзвэл хүмүүсийн хэлсэн шүүмжлэл бүрт “За ойлголоо, засаад янзалчихъя” гэж хариулаад байгаа бизнесмэн итгэл төрүүлдэггүй. Хөрөнгө оруулагчдыг

өөртөө татахын тулд ямар ч арга хэрэглэж болно, гэхдээ л өөрийнхөө үзэл бодлыг тууштай хамгаалах ёстой гэж Александр Галицкий үздэг юм байна. Байнга өөрчлөгдөж байдаг эрсдэл ихтэй бизнесийн салбарт хөрөнгө оруулагчдын өмнө тууштай байж чадахгүй бол ганц ч зоос олж авч чадахгүй аж.



Бүдүүлэг үг хэлэх

Өрсөлдөгчид, хамтран ажиллаж буй хүмүүс, хуучин ажилтнуудынхаа тухай онцгүй зүйл ярьж, тэднийг бүдүүлгээр хэлэх нь хөрөнгө оруулагчдыг эргэлт буцалтгүй үргээнэ гэж мэдээрэй. Түүнчлэн худалдан авагчдыг төөрөгдүүлж, хуурч мэхлэх замаар ашиг олох тухай мартсан нь дээр. Хэрэглэгчдэдээ

шударга ханддаггүй хүнд хөрөнгө оруулагч яагаад итгэх ёстой гэж? Түүнчлэн “Би л байхгүй бол манай компани сүйрнэ” гэж ярих нь өөрийгөө доош хийж буй хэрэг. Зүгээр л сайн баг үүсгэж чадахгүй, өөрийн чадвар, боломжоо эрүүлээр үнэлдэггүй хүмүүс л ингэж ярьдаг байна.



Залхуурах

“Хэрэв бизнесмэн хүн эрч хүчгүй, өөрийнхөө төсөлд өөрийгөө бүхэлд нь зориулах хүсэлгүй бол би тэр хүнд мөнгө өгөх тухай лав бодохгүй” хэмээн “General Catalyst”-ын захирал Жоэл Катлер хариуллаа. Хөрөнгө оруулагчидтай уулзахдаа төсөл, бизнесээ үнэд хүргэж байгаад зарчихна гэсэн санаа цухалзуулж хэзээ ч болохгүй. Бизнесээ хөгжүүлэхийг бус зарахыг эрхэмлэж

буй хүнд мөнгө өгөх сонирхол хөрөнгө оруулагчдад төрнө гэж үү? “Өөрийн орлогоо тооцоолж, бизнесээ зарах тохиолдолд хэдий хэмжээний мөнгө авахаа урьтал болгон ярьж байгаа хүнийг би яасан ч үнэлэхгүй” гэж “Intel Capital” сангийн Игорь Табер учирлалаа.

“Forbes” сэтгүүлээс орчуулав ■

Бизнесийн завсарлага

Та ямар ном уншиж байгаа вэ?


Р.Зоригтбаатар

/"Тавантолгой" компанийн үйлдвэр эрхэлсэн дэд захирал:

-Уран зохиол гэхээсээ илүү түүхэн, баримтат үйл явдлыг дүрсэлсэн ном уншдаг. Хамгийн сүүлд нэг найзынхаа бэлэглэсэн "Монголчуудын түүхэнд тодорсон 33 цуут жанжин" номыг уншсан. Монголын түүхэнд Хүннү гүрнийг нягтгэсэн Модун Шаньюйгаас эхлээд Батмөнх, Чингис хаан, манлай баатар Дамдинсүрэнгийн тухай бодитой бичжээ. Хамгийн гайхалтай нь Халимагийн ард түмэн хэчнээн их бэрхшээл даван туулж, Уваши хунтайж ард түмнээ яаж авч явсныг маш тод томруунаар гаргасан байна.

Энэ номноос өмнө Х.Баянмөнх аваргын бичсэн "Хагас зуун жилийн ганцаардал...Миний ялалт"-ыг уншсан. Социализмын үед өөрт нь тохиож байсан амьдрал тэмцлийн талаар бичсэн даян аварга үнэхээр хүчтэй хүн.

Ш.Насанбатын бичсэн "Монголчуудын түүхэнд тодорсон 33 цуут жанжин" ном нь анх 2009 онд хэвлэгдсэн. Зохиогч энэхүү номоороо Монгол Улсын түүхэнд хосгүй их гавъяа байгуулсан эрэлхэг жанжин эрсийн түүхийг таниулахыг зорьжээ.




Б.Нагнайдорж

/Кино найруулагч/:

-Номын сонголт янз бүр л байдаг. Өөрийнхөө номтой нөхөрлөж байсан үеийг дурсан яривал их л сонин зүйлүүд, бас сонирхолтой дурсамжууд үлдсэн байна. Хүүхэд нас, залуу нас, ахмад насанд янз бүрийн зохиол номыг уншиж байсан маань сэтгэлд дотно хүмүүстэйгээ уулзаж учирч байсан мэт санагдана. Урлагтай амьдралаа холбож урлагийн бүхий л салбарын номыг уншиж өөрийгөө боловсруулан нээх зорилгоор номтой нөхөрлөж, гүн гүнзгий танилцсан билээ. Харин өтөл насандаа шинэ ном сонирхохоосоо илүү урьд өмнө нь гүйцэд уншаагүй болон дахин уншмаар санагдсан зохиолуудаа эргэн дахин сөхөж зарим номон дээр бүүр тэмдэглэл хөтлөж, утга санааг уудлан үзэж суух болжээ. Ялангуяа хүмүүсийн тухай дурсамжууд, түүх, цаг үеийн сонирхолтой үеийг харуулсан номыг унших болсон. Жишээ нь цэргийн нэрт жанжин Г.Жуковын дурьдатгал, алдарт

найруулагч М.Ромм, Акира Куросава, Хилари Клинтон, оросын нэрт эрдэмтэн А.Сахаровын тухай гэх мэт. Сүүлийн жилүүдэд гэвэл Чингиз Айтматовын зохиолын түүвэрүүд. Алдарт "Ингэн нүд", "Жамиля", Зуунаас урт өдөр" зохиолуудыг уншиж байгаа. Энэ бол маш сайхан зохиол, жинхэнэ нүүдэлчний үр удам, жинхэнэ хүний тухай өгүүлсэн учраас дахин дахин уншдаг. Мөн Р.Гамзатов, Дорнын яруу найрагч Б.Явуухулан, Д.Пүрэвдоржийн номуудыг их л ойр ойрхон сөхөж суудаг. Харин энэ ялдамд номын хорхоотой болж буй залуучууд хүүхдүүдэд ахмад хүний хувьд хэлэх хэдэн үг байна. Ном унших гэдэг бол сэтгэлийн агуу сайхан ертөнцөд аялж харь ертөнцөөр зугаацан, хүн ардтай нь танилцаж тэдний амттай сайхан хоолыг амсаж, аялгуу сайхан дууг сонсож суугаа мэт болдог учир "унш унш бас дахин уншаарай" гэж өвгөн би сэтгэлээсээ хүсэж байна.




Д.Мөнхсайхан

/AIDD группын санхүүгийн захирал/:


-Кармин Галлогийн "The Innovation secrets of Steve Jobs" нэртэй сонирхолтой номыг уншиж байгаа.

Дэлхийд алдартай "Apple" компанийн захирал Стив Жобс шинэчлэлийг хэрхэн хэрэгжүүлдэг тухай зохиолч долоон зарчим боловсруулсан байна. Шинэлэг зүйл гэсэн ойлголтыг "Apple" компанитай шууд холбодог бөгөөд, зохиогч шинийг зохион бүтээж хэрэгжүүлэхэд тустай долоон зарчмыг танилцуулсан байна. Эдгээр зарчмыг дурдвал: нэгд, Та өөрийнхөө дуртай сонирхолтой зүйлээ

л хий, хоёрт, алсын хараагаа том зорилгоор тогтоох, гуравт, бүтээгдэхүүн бус харин өөрийн мөрөөдлөө борлуул, дөрөвт, 1000 зүйлд "Үгүй" гэж хэлж сурах өөрөөр хэлбэл аливаа зүйлийн дизайныг өөр хэв маягаар бодож байх, тавд, сэтгэлд багтамгүй үйл явдалтай учрах, зургаад, бүтээлч сэтгэлгээгээ ашиглаж сур, долоод, хүмүүст хүргэх гэж байгаа мэдээллээ хэний ч анхаарлыг үргэлж татахуйц хэлбэрээр хүргэх. Галло хүн бүр шинийг санаачлагч байж чадахгүй боловч хүн бүр харин шинэчлэгч байж болно гэж үзэж байна. ■



RioTinto



**Рио Тинто Монгол улс, Монголын
Олимпийн багт хөрөнгө оруулж
байгаадаа бахархаж байна.**

Уул уурхайн дэлхийд тэргүүлэгч туршлагыг
нэвтрүүлснээр хүн бүр Оюу Толгойн амжилт,
Монгол улсын хөгжлөөс хүртэнэ.

www.riotinto.com/london2012



RioTinto

Монголын Үндэсний
Олимпийн хороо
АЛТАН ТҮНШ

**уурхайн гүнээс
аваргын энгэрт**

